



МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙН ТЭВЧИШГҮЙ ХЭЛБЭРҮҮД

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Төслийн нэр: “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд”

Гүйцэтгэсэн байгууллага: Хүний Эрхийн Үндэсний Комисс

Огноо: 2007 – 2008

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

2008

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙН
ТЭВЧИШГҮЙ ХЭЛБЭРҮҮД

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

АГУУЛГА	2
НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	
1.1. Судалгааны үндэслэл	4
1.2. Судалгааны зорилго, зорилт	5
1.3. Судалгааны арга зүй	5
1.4. Судалгааны нэр томъёо	7
1.5. Судалгааны хамрах хүрээ	8
ХОЁР: ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙН ТЭВЧИШГҮЙ ХЭЛБЭРИЙН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН БАРИМТ БИЧИГ БА ҮНДЭСНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖ	9
ГУРАВ: ХҮҮХДИЙГ НАЙМААЛАХ, БЭЛГИЙН МӨЛЖЛӨГ, САДАР САМУУНЫ СУРТАЛЧИЛГА ААНД АШИГЛАХ, МАНСУУРУУЛАХ БОДИС ҮЙЛДВЭРЛЭХ БОРЛУУЛАХАД ТАТАН ОРОЛЦУУЛАХ, ХҮЧЭЭР ХӨДӨЛМӨРЛҮҮЛЭХ ЗЭРЭГ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	17
3.1. Насанд хүрээгүй хүмүүсийг бэлгийн мөлжлөгт ашиглах гэмт хэрэг	17
3.2. Хүүхэд худалдаалах, хил дамжуулан худалдаалах гэмт хэрэг	21
ДӨРӨВ. УУЛ УУРХАЙН САЛБАР ДАХЬ ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨР	
4.1. Уул уурхай дахь хүүхдийн хөдөлмөрийн шалтгаан	26
4.2. Уул уурхай дахь хүүхдийн хөдөлмөрийн орчин, нөхцөл	29
4.3. Уул уурхай дахь хүүхдийн хөдөлмөрийн үр дагавар	32
4.4. Хөдөлмөрийн эдийн засгийн үр дагавар	33
4.5. Хүүхдийн сурч боловсрох нөхцөл байдал	34
4.6. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах чиглэлээр бодлогын түвшинд болон орон нутагас хэрэгжүүлж буй үйл ажиллагаа	38
4.7. Бүлгийн дүгнэлт	40
ТАВ: ХОТ СУУРИН ГАЗАР ДАХЬ ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨР	
5.1. Танилцуулга, ерөнхий мэдээлэл	41
5.2. Хогийн цэгт хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүд	44

5.3. Хөдөлмөрийн орчин, хэв шинж	46
5.4. Захуудад ажиллагч хүүхдүүд	51
5.5. Төмөр замын өртөөнд ажиллагч хүүхдүүд	58
5.6. Циркэд хөдөлмөр эрхлэгч хүүхдүүд	61
5.7. Айлд гэрийн үйлчлэгчээр ажиллаж буй хүүхдүүд	72
5.8. Бүлгийн дүгнэлт	74

ЗУРГАА. ХӨДӨӨ АЖ ХУЙН САЛБАР ДАХЬ ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨР

6.1. Айлд мал маллаж буй хүүхдүүдийн хөдөлмөр	76
6.2. Хурдан морь унаач хүүхдийн хөдөлмөр	77

ДОЛОО. САНАЛ, ЗӨВЛӨМЖ	80
------------------------------	-----------



МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙН
ТЭВЧИШГҮЙ ХЭЛБЭРҮҮД
СУДАЛГААНЫ ТАЙЛАН

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1. Судалгааны үндэслэл:

Монгол Улс зах зээлийн харилцаанд шилжих шилжилтийн явцад нийгмийн сөрөг үзэгдлүүд олонтоо гарч ирсний нэг нь хүүхдийн хөдөлмөрийн асуудал юм. Эдийн засгийн болон улс төрийн шинэчлэл нь гэнэтийн, таагүй үр дагаврыг авчирсан бөгөөд ядуурал, ажилгүйдэл, нийгмийн үйлчилгээний жигд бус хүртээмж, шилжилт хөдөлгөөн, хямд хүч ажиллуулах бизнесийн сонирхол, эмзэг бүлгийн хүмүүсийн гэр бүлийн орчин, тэдний өөртөө итгэх итгэл алдарсан байдал, эцэг эхийн хүүхдийн хөдөлмөрийн талаарх ойлголт хандлага буруу зэргээс үүдэн хүүхдүүд хөдөлмөр эрхлэх, ялангуяа эрүүл мэнд, бие бялдар, оюун ухааны хөгжилд сөрөг нөлөө үзүүлэхүйц тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхэлсээр байна. Монгол Улс ардчилал, зах зээлийн харилцаанд шилжиж буй сүүлийн 20 орчим жилийн хугацаанд шийдвэр гаргах түвшинд буюу хууль тогоох, бодлого боловсруулах эрх мэдэл бүхий Монгол Улсын Их Хурлаар хүүхдийн хөдөлмөр ялангуяа, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн асуудлаар хэлэлцэж тодорхой шийдвэр гаргаж байгаагүй байна.

Хүний Эрхийн Үндэсний Комисс (ХЭҮК) нь Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний тухай заалтын хэрэгжилтэнд хяналт тавьж, хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих, хүний эрхийн асуудлаар судалгаа явуулж, мэдээллээр хангах, санал, зөвлөмж гаргах хуулиар олгогдсон бүрэн эрхтэй байгууллага болохын хувьд Монгол Улс дахь хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг бууруулах, арилгах талаар анхаарлаа хандуулж ажилладаг.

Нөгөө талаас манай улсад эрхлэж буй хөдөлмөрөөсөө шалтгаалан эрх, эрх чөлөөгөө эдэлж чадахгүй байгаа хүүхэд, өсвөр үеийнхний тоо улам бүр өсөн нэмэгдэх хандлагатай байгаа тул хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг нэн даруй устгах тухай олон улсын гэрээ, конвенц болон Монгол Улсын хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар цогц судалгаа хийж, бодлогын санал зөвлөмж гаргах, хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Иймд ХЭҮК нь Олон улсын хөдөлмөрийн байгууллагын (ОУХБ) дэмжлэгтэйгээр “Монгол Улс дахь хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд” судалгааны ажлыг хэрэгжүүлж, хүүхдийн хөдөлмөрийн хэлбэрүүд, түүний дотор тэвчишгүй хөдөлмөрийн төрлүүдийг тодорхойлох, эдгээр нь хүүхэд эрх, эрх чөлөөгөө эдлэхэд нь хэрхэн нөлөөлж буйд дүгнэлт хийн, 2008 оны Хүний эрх, эрх чөлөөний талаарх илтгэлд тусгахаар төлөвлөсөн болно. Мөн уг асуудлаар судалгаа хийж, санал, дүгнэлт боловсруулахын хамт хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах талаар олон нийтэд чиглэсэн олон тооны сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажил зохион байгуулсан болно.

Энэхүү судалгааны тайланд хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд, тэдгээрийн шалтгаан, нөхцөл байдал, үр дагаврыг тодорхойлж, цаашид бууруулах, таслан зогсоох арга замуудыг тодорхойлоход чиглэгдсэн болно.

1.2. Судалгааны зорилго, зорилт, арга зүй:

Уг судалгаа нь хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, ялангуяа хүүхдийн эрүүл мэнд, бие махбодь, сэтгэл санааны хувьд сөрөг үр дагавар бүхий тэвчишгүй, хүнд хөдөлмөр эрхлэж буй шалтгаан, нөхцөл байдал, үр дагаврыг тодорхойлж, тэдгээрийг бууруулах, таслан зогсоох арга замуудыг тодорхойлох зорилго дэвшүүлсэн. Уг зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлсэн болно. Үүнд:

- Хүүхдийн хөдөлмөр, ялангуяа тэвчишгүй, хүнд хэлбэрийн хөдөлмөр эрхлэлтийн талаар бодит байдалтай танилцах, нэгдсэн мэдээлэл судалгааны сан бүрдүүлэх,
- Уул уурхайн салбар дахь хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн нөхцөл байдлын талаар сонгон авсан аймаг, орон нутгийн хэмжээнд судалгаа, дүн шинжилгээ хийх
- Тухайн салбар дахь хүүхдийн хөдөлмөртэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилт, хүүхэд хамгааллын чиглэлээр ажиллаж буй төрийн болон төрийн бус байгууллагын үйл ажиллагаатай танилцах
- Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн хор уршиг, үр дагаврын талаар олон нийтийн анхаарлыг хандуулах, сурталчилгаа мэдээлэл, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах зэрэг болно.

Судалгааны зорилтот бүлэг:

Судалгааны зорилтот бүлэг нь хүнд, тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүд, тэдний эцэг, эх, ажил олгогчид болон хүүхэд хөгжил, хамгаалал болон хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн ба төрийн бус байгууллагын ажилтан, албан тушаалтнууд, шийдвэр гаргагчид, орон нутгийн иргэд байна.

1.3. Судалгааны арга зүй:

Уг судалгааны ажлын хүрээнд дараах аргазүйг хэрэглэв. Үүнд:

Бичиг баримтын судалгаа:

Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн талаарх олон улсын болон дотоодын холбогдох хууль, эрх зүйн актууд, баримт бичгүүдийг судлах, дүн шинжилгээ хийх замаар тухайн асуудлын онол арга зүйн үндэслэлийг тодорхойлно. Үүнд:

- ❖ Хүүхдийн хөдөлмөрийн асуудалд холбогдох олон улсын гэрээ, конвенц, баримт бичгүүд, олон улсын хүний эрхийн хэм хэмжээ, стандарт
- ❖ Хүүхдийн хөдөлмөрийн асуудалд холбогдох хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, эрхзүн актууд, бодлогын баримт бичгүүд /хөтөлбөр, төлөвлөгөө, тайлан/;
- ❖ Уг асуудлаар яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын гаргасан бүх нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам;
- ❖ Хүүхдийн хөдөлмөрийн асуудлаар бусад байгууллага, судлаачдын хийсэн судалгааны тайлан, мэдээлэл;
- ❖ Статистикийн мэдээ;
- ❖ Судалгаанд хамрагдах байгууллагын мэдээллийн сан

Тоон судалгаа:

- Анкетын судалгаа: Үүнд:

Хүүхдийн хөдөлмөрийн нөхцөл байдал, хөдөлмөр эрхлэх шалтгаан, хөдөлмөр эрхлэлтийн эерэг ба сөрөг тал, ажлын байрны нөхцөл, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал, эрүүл мэндийн ба боловсролын үйлчилгээ зэрэг асуудлыг тусгасан 25 асуулт бүхий анкетаар судалгаа авав.

Чанарын судалгаа:

Чанарын судалгаа нь анкетын судалгааны стандартчлагдсан асуулгад үндэслэсэн боловсруулсан удирдамжийн дагуу ярилцлага, ажиглалтын аргын хэлбэрээр зохион байгуулагдсан.

- Ярилцлага:

Ярилцлагын асуултуудыг ярилцлага хийх удирдамжийн хамт тусгайлан боловсруулсан бөгөөд ганцаарчилсан, бүлгийн, экспертүүдийн ярилцлага зэрэг хэлбэртэй байв. Ярилцлагад хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүд, тэдний эцэг, эх, ажил олгогчид, засаг захиргааны болон удирдах албан тушаалтан, ажил олгогч, цагдаа, нийгмийн ажилтан зэрэг хүмүүс хамрагдсан юм.

Бүлгийн ярилцлагаар хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн талаарх олон нийтийн үзэл бодлыг тодорхойлох, тэдний ажлын нөхцөл, сургуульд хамрагдалт, хөдөлмөр зохицуулалт, энэ талаар хэрэгжүүлж буй арга хэмжээг тодруулах зорилготой байлаа.

- Ажиглалтын судалгаа:

Албан бус уул, уурхайн салбар, түүнийг дагалдсан үйлчилгээний салбар дахь хүүхдийн тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөрт татагдан орсон хүүхдүүд, тэдгээрийн эцэг эхийн сэдэл, амьдралын нөхцөл байдал, хөдөлмөрийн нөхцөл байдал, хөдөлмөр хамгаалал, эрүүл мэнд, байгаль цаг уурын нөхцөл, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ зэрэг цогц асуудлуудад ажиглалтын судалгаа хийсэн болно.

Судалгааны мэдээллийг социологийн судалгааны түгээмэл аргуудыг (анкетын, ярилцлагын, ажиглалтын) хослуулан хэрэглэж цуглуулсан бөгөөд энэ чиглэлээр өмнө нь хийгдсэн судалгааны материал, эх сурвалжид дүн шинжилгээ хийх, харьцуулах замаар судалгааны дүнг гаргасан болно. Чанарын судалгааны мэдээллийг энгийн нэгтгэлийн аргаар боловсруулж, судалгааны тайланд шигтгээ хэлбэрээр оруулав.

1.4. Судалгааны нэр томъёо:

“Монгол Улс дахь хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд” судалгааны ажлын хүрээнд дараах үндсэн ойлголт нэр томъёог баримтлан ажиллав. Үүнд:

Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 182 дугаар конвенцийн 3 дугаар зүйлд заасанчлан:

“хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр” гэдэгт:

- a) боолчлолын бүх хэлбэр болон хүүхдийг худалдах, дамжуулан худалдах, өрийн төлөөс, хамжлагын албат болгох, хүчээр буюу албадан хөдөлмөрлүүлэх, түүний дотор зэвсэгт мөргөлдөөнд ашиглах зорилгоор хүчээр буюу албадан оролцуулах зэрэг боолчлолтой төстэй дараахь үйл ажиллагаа хамаарна:
- b) хүүхдийг биеэ үнэлэх, садар самуун сурталчилгааны үйлдвэрлэл буюу садар самуун үзүүлбэрт ашиглах, зуучлах, санал болгох;
- c) олон улсын холбогдох гэрээнд тодорхойлсноор хүүхдийг мансууруулах бодис үйлдвэрлэх, хил дамжуулан худалдах зэрэг хууль бус үйл ажиллагаанд ашиглах, зуучлах, санал болгох;

- d) ажлын шинж чанар, түүнийг гүйцэтгэх нөхцөл нь хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд хор нөлөө үзүүлэх ажил, мөн

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн тухай 190-р зөвлөмжид заасанчлан:

- Хүүхдийг бие бялдрын, сэтгэл зүйн болон бэлгийн хүчирхийлэлд өртүүлж буй ажил
- Газрын дор, усны гүнд болон аюултай өндөрт эсвэл хэтэрхий давчуу орон зайд хийгдэж буй ажил
- Аюултай машин механизм, тоног төхөөрөмж, багаж зэвсэгтэй харьцаж буй ажил, түүнчлэн хүнд ачааг гараар өргөж зөөх болон тээвэрлэх биеийн хүчний ажил
- Эрүүл бус орчинд, тухайлбал, хүүхдийг аюултай бодис, урвалжтай харьцах, хүүхдийн эрүүл мэндийг хохироож болох агаарын хэм, дуу чимээ эсвэл чичиргээн бүхий нөхцөлд хийж буй ажил
- Тодорхой хүнд нөхцөлд хийгдэж буй ажил, тухайлбал уртасгасан цагаар, шөнийн цагаар хийж буй ажил, эсвэл ажил олгогчийн ажлын байранд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хийгдэж буй ажил зэргийг хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй, хүнд хэлбэрийн хөдөлмөрт тооцдог байна.

Монгол Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлд “Байгалийн гамшиг, гоц халдварт өвчин, нийтийг хамарсан гэнэтийн осол, зэвсэгт мөргөлдөөнд өртсөн хүүхдийг онцгой нөхцөлд байгаа хүүхэд; харин бүтэн өнчин, тахир дутуу, нэн ядуу, хараа хяналтгүй, садар самуун, хүчирхийлэл, доромжлолын улмаас сэтгэл санааны болон бие махбодийн хохирол хүлээсэн, эрүүл мэнд, амь насанд нь аюул учруулах хөдөлмөр эрхэлж буй хүүхдийг хүнд нөхцөлд байгаа хүүхэд” гэж тодорхойлсон байна¹.

Судалгааны явцад ихэнх хүүхдүүд ямар нэгэн хэмжээгээр гэрийн болон үйлчилгээний шинжтэй ажилд байнга оролцон тусладаг нь харагдаж байна. Хүүхэд олон төрлийн ажил хийдэг боловч хамгийн түгээмэл хэлбэрүүд нь хоол цай хийх, дэлгүүр, зоогийн газар, тоглоомын газар зэрэгт үйлчлэх, ус авах, түлээ түлш бэлтгэх зэрэг ажлууд байна. Гэвч эдгээр нь хөнгөн хэлбэрийн ажил, нөгөө талаас эцэг эх, асран хамгаалагчийн хяналтын дор өрхийн аж ахуйд туслах зорилгоор хийж буй тул энэхүү “Монгол Улс дахь хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд” судалгааны ажлын хүрээнд гүнзгийрүүлэн судлаагүй болно.

1.5. Судалгааны хамрах хүрээ:

Судалгааны ажлын хүрээнд хүүхдийн тэвчишгүй хөдөлмөртэй холбоотой дараах асуудлууд, хөдөлмөрийн төрөл хэлбэрүүдийг судласан болно. Үүнд:

- Хүүхдийн хөдөлмөрийн талаарх олон улсын гэрээ конвенц
- Хүүхдийн хөдөлмөрийн талаарх үндэсний хууль тогтоомж, эрх зүйн зохицуулалт
- Уул уурхайн салбар дахь хүүхдийн хөдөлмөр
- Хот суурин газар дахь хүүхдийн хөдөлмөр
- Хөдөө, аж ахуйн салбар дахь хүүхдийн хөдөлмөр
- Хүүхдийг худалдаалах буюу бэлгийн мөлжлөгт ашиглах, албадан хөдөлмөрлүүлэх зэрэг гэмт хэргийн нөхцөл байдал
- Хүүхдийн хөдөлмөрийн бусад нуугдмал хэлбэрүүд

¹ Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, 1996 он 15 дугаар зүйлийн 15.1, 15.2 заалт

- Хүүхдийн хөдөлмөрийн талаарх санал зөвлөмжүүд

Судалгааны ажлыг ХЭҮК-ын гишүүн Ж.Дашдоржийн ахласан судалгааны баг 2007 оны 6 дугаар сараас 2007 оны 12 дугаар сарыг хүртэл нийт 7 сарын хугацаанд хийв. Судалгааг Өвөрхангай, Баянхонгор, Өмнөговь, Дундговь, Дархан-Уул, Дорноговь, Сэлэнгэ, Төв аймгууд болон Улаанбаатар хотын Сонгинохайрхан, Баянзүрх, Баянгол, Налайх дүүргүүдэд хийв.

Судалгаа хийсэн газар, орон нутгийн товч мэдээлэл:

Өвөрхангай аймаг:

Өвөрхангай аймаг нь 19 сум, 103 багтай. 2005 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд нийт 28865 өрхөд 108235² хүн ам амьдарч байгаагийн 49% эрэгтэй, 51% эмэгтэй байна. Нийт хүн амын 59,3 хувь нь хөдөлмөрийн насны хүн ам, 34,4 хувь нь 16 хүртэлх насны хүүхэд, 6,2 хувь нь 60-аас дээш насны хүн ам эзэлж байна.

Аймгийн хэмжээнд 0-18 насны 45279³ хүүхэд байгаа бөгөөд хүүхдийн хөдөлмөрийн талаар аймагт хийсэн судалгаануудын нэгдсэн дүнгээр, бүрэн бус мэдээгээр нийт 1300 орчим хүүхэд хөдөлмөр эрхэлж байна гэсэн тооцоо гаргажээ.

Уянга, Бат-Өлзий зэрэг 5 сумдад томоохон алтны уурхайг түшиглэсэн иргэдийн албан бус алт олборлолт түгээмэл байна.

Баянхонгор аймаг:

115978 ам.км² нутагтай. Нийт 21000 өрхийн 82229 хүн амтай. Мал аж ахуй сайн хөгжсөн бөгөөд малынхаа тоогоор улсад эхний 3 байрыг эзэлдэг. Баянхонгор аймгийн хэмжээнд 2000 оны хүн амын тооллогоор нийт 33678 хүн хөдөлмөр эрхэлж байгаагийн 11,7 хувь нь төсвийн газарт, бусад салбарт 88,3 хувь нь ажиллаж байна.

Аймгийн хэмжээгээр иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн байдалд албан бус хөдөлмөр, ялангуяа гар аргаар алт олборлох явдал ихээхэн хувь эзлэх болжээ. Аймгийн хэмжээнд 0-18 насны 39000 хүүхэд байгаагийн 80 орчим хувь нь албан боловсролд хамрагддаг байна. Гэвч 2005-2006 оны хичээлийн жилийн байдлаар 5009 хүүхэд сургуулийн гадна байна. Баянхонгор аймагт албан бус алтны уурхайн хамгийн төвлөрөлтэй сумд нь Баян-Овоо, Бөмбөгөр юм.

Өмнөговь аймаг:

Өмнөговь аймаг нь засаг захиргааны нэгжийн хувьд 15 сум, 53 багтай, нутаг дэвсгэр нь 165.0 мян. м², хүн ам нь 46342, үүнээс 16833 буюу 36% нь 0-18 насны хүүхэд байна. Өмнөговь нь Оюу толгой, Нарийн сухайт, Таван толгой зэрэг стратегийн ач холбогдол бүхий орд газруудтай, байгалийн баялаг ихтэй, уул уурхай, аялал, жуулчлалын салбараар хөгжиж байгаа аймаг юм.

Өмнөговь аймагт хийсэн судалгааны маршрутад Баян-Овоо, Ханбогд сумын “Цагаан чулуут”, Ханбогд, Оюу толгой, Даланзадгад, Ёлын ам, Баяндалай, Зөөлөн уул /Сэврэй

² өвөрхангай аймгийн Статистикийн эмхэтгэл 2005 он

³ өвөрхангай аймгийн Статистикийн эмхэтгэл 2005 он

сумын нутагт оршдог, Улсын тусгай хамгаалалттай газар нутагт багтдаг/, Сэрвэй, Гурван тэс, Цогт-Овоо сумууд хамрагдсан.

Дорноговь аймаг:

Дорноговь аймаг Монгол орны баруун өмнөт хязгаарт 109,0 мянган кв км нутаг дэвсгэрийг эзлэн оршдог. Өмнөговь, Дундговь, Говьсүмбэр, Хэнтий, Сүхбаатар аймгууд болон БНХАУ-тай хиллэдэг. Аймгийн төв Сайншанд хот.

Дорноговь аймаг нь 14 сум, 75 багтай. 2006 оны байдлаар аймгийн хэмжээнд нийт 17856 өрхөд 54023⁴ хүн ам амьдарч байна. Нутаг дэвсгэр бүхэлдээ говь, тал хээрийн бүсэд хамаарагддаг. Зэс, хайлуур жонш, чулуун нүүрс, өнгөт металл, шохойн чулуу, алт, мөнгө зэрэг 38 төрлийн ашигт малтмалын 73 орд, 440 орчим илэрлүүд тогтоогдсон. Хойд, урд хоёр гүрнийг холбосон төмөр зам дайран өнгөрдөг тул аймгийн бүх сумын 42,8 хувь, хүн амын 54,8 хувь нь төмөр замын дагуу оршдог тул төв суурин газар ачаа зөөх, тэрэг түрэх болон жоншны үйлдвэрлэл нилээд хөгжсөн байна. Дорноговь аймагт хийсэн судалгааны маршрутад Сайншанд, Замын-Үүд, айраг, Даланжаргалан, Иххэт зэрэг сумууд хамрагдсан.

Дундговь аймаг:

Дундговь аймаг нь засаг захиргааны нэгжийн хувьд 15 сум, 65 багтай, хүн ам нь 49406 үүнээс 19453 буюу 42% нь 0-18 насны хүүхэд байна.

Ашигт малтмалын нөөц ихтэй, <http://gate1.pmis.gov.mn/dundgobi/image/pic/chuluu1.gif> чулуун ба хүрэн нүүрс, хайлуур жонш, цагаан тугалга, цайр, гөлтгөнө, төмөр, алт, мөнгө, уран, байгалийн будаг зэрэг 33 нэр төрлийн ашигт малтмалын 81 орд, 149 илэрц олдож судлагдсан байна. Тус аймагт хийсэн судалгааны маршрутад Мандалговь хот, Өлзийт сум хамрагдсан.

Сэлэнгэ аймаг:

Сэлэнгэ аймаг нь нийт 80 мянга орчим хүн ам, 43 мян. м² нутаг дэвсгэртэй, бүх нутгийн 42% ой мод, 47% бэлчээр, 7% хадлангийн талбай эзэлдэг. Тус аймгийн Мандал, Ерөө сумуудад гар аргаар алт олборлогч ихтэй, тэдгээрийг дагаж хүүхдүүд хөдөлмөр эрхэлдэг хэдий ч тодорхой тоо баримт, статистик мэдээ байхгүй байна. Харин Зүүнхараад төмөр зам, модны үйлдвэр үйл ажиллагаатай холбоотой хөрөө рам дээр мод бэлтгэдэг, цемент, нүүрс зөөдөг, вокзал дээр худалдаа хийдэг, айлд мал малладаг, тоосгон дээр ажилладаг хүүхдүүд байдаг.

Дархан-Уул аймаг:

Дархан-Уул аймаг нь засаг захиргааны нэгжийн хувьд 4 сум, 24 багтай. Судалгаа хийгдсэн Шарын гол сум 9000 гаруй хүн амтай, 16.0 га газар нутагтай. Шарын гол сумд хүүхдүүд төмөр түүх, ундааны шил сав цуглуулах, уурхайгаас нүүрс зөөх, түлээ бэлтгэх, алт олборлох, айлд хөлсөөр мал хариулах зэрэг хөдөлмөр эрхэлдэг байна.

Хоёр: Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн талаарх олон улсын баримт бичиг ба үндэсний хууль тогтоомж

⁴ есвэрхангай аймгийн Статистикийн эмхэтгэл 2005 он

Монгол Улс хүүхдийн хөдөлмөрийн асуудлаар НҮБ болон Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-аас батлан гаргасан олон тооны гэрээ конвенцид нэгдэн орж, түүнийг хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээжээ.

Монгол Улс Аж үйлдвэрийн салбарт ажилд авах насны доод хязгаарын тухай 59 дүгээр конвенцид 1969 онд, Газар дор болон уурхайд ажиллагсдын насны доод хязгаарын тухай ОУХБ-ын 123 дугаар конвенцид 1981 онд, Хүүхдийн эрхийн тухай конвенцид 2000 онд, Хүүхдийг хамгаалах болон улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай Гаагийн 33 дугаар конвенцид 2000 онд, Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг нэн даруй устгах, хориглох тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 182 дугаар конвенцид 2001 онд, Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн нэмэлт протоколд 2002 онд, Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 138 дугаар конвенцид 2002 онд, Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенцийн нэмэлт протоколд 2003 онд, Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцийн нэмэлт протоколд 2004 онд тус тус нэгдэн орсон байна.

Эдгээр олон улсын гэрээ, конвенцид нэгдэн орж, соёрхон баталснаар Монгол Улс эдгээр гэрээ, конвенцийн заалтыг хэрэгжүүлэх, үндэсний хууль тогтоомжоо тэдгээрт нийцүүлэх, шаардлагатай бүтэц механизмыг бий болгох, холбогдох дүрэм журмыг гаргах, эдгээр баримт бичгийг албан тушаалтнууд болон иргэдэд тайлбарлан таниулах, сурталчлах, сургалт зохион байгуулах, биелэлтийг тооцох тайлагнах гэх мэт өргөн үүрэг хариуцлага үүсдэг. Иймээс хүүхдийн хөдөлмөртэй холбоотой баримт бичгийг үндэсний хууль тогтоомжтойгоо нийцүүлэх, хэрэгжүүлэх асуудлыг судалж дүгнэлт хийх нь нэн чухал ач холбогдолтой юм.

Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 19, 32, 33, 34 дүгээр зүйлүүдэд "Оролцогч улсууд нь хүүхдийг худалдах, хил дамжуулан худалдах, хүүхдийг бэлгийн замаар ашиглан мөлжих, хүүхдийг садар самууны үзүүлбэр, сурталчилгаанд ашиглах, хүүхдийг албадан хөдөлмөрлүүлэх буюу бэлгийн хүчирхийлэл, эдийн засгийн мөлжлөгөөс хамгаалах, хүүхдийн эрүүл мэнд, бие бялдар, оюун ухаан, ёс суртахуун, боловсрол эзэмшихэд нь саад болох аюултай ажил эрхлэхээс хамгаалуулах эрхийг нь хүлээн зөвшөөрч, ажилд авах насны доод хязгаарыг тогтоох, ажлын цаг болон хөдөлмөрийн нөхцлийг нь зохистой зохицуулж энэ зорилгоор хууль тогтоох, захиргааны, нийгмийн болон гэгээрлийн бүхий л шаардлагатай арга хэмжээг авна" гэж заасан нь хүүхдийн хөдөлмөртэй холбоотой суурь зарчмууд бөгөөд эдгээр зарчмуудыг улам бүр дэлгэрэнгүй болгон нарийвчилж заалт тус бүрээр нь дагнасан Конвенц, нэмэлт протоколууд, зөвлөмжүүд гарсан нь оролцогч улсуудын хүлээх үүрэг, хийх ёстой ажлыг улам бүр тодорхой болгосон байна.

Хүүхдийг ажилд авах насны доод хязгаарын тухай асуудал нь дээрх баримт бичгүүдийн адил чухал ач холбогдолтой зарчим байдаг.

Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 123 дугаар конвенцид "Газар дор болон уурхайд ажиллагсдыг ажилд авах насны доод хязгаарыг 15 нас" гэж, Аж үйлдвэрийн салбарт ажилд авах насны доод хязгаарын тухай 59 дүгээр конвенцид "16 нас" гэж, Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 138 дугаар конвенцид "Хөдөлмөр эрхлэх насны доод хязгаар нь бүрэн бус дунд боловсрол эзэмших нас байх бөгөөд ямарч тохиолдолд 15 наснаас доошгүй, өсвөр үеийнхний эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй ажлын хувьд 18 наснаас доошгүй байна" гэж тус тус заасан байна.

Ажилд авах насны доод хязгаарыг хэрхэн тусгасныг авч үзье. (ОУХБ-ын 59, 123 дугаар конвенцид заасан ажлыг аюултай ажил гэж тооцсон бол 138 дугаар конвенцид нэгдсэн орны хувьд өмнөх 2 конвенцийг нэн даруй цуцалсанд тооцдог)

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлд:

- мэргэжлийн баримжаа, ажлын дадлага олгох зорилгоор 14 насанд хүрсэн хүнтэй эцэг, эх, асран хамгаалагч болон төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлтэйгээр хөдөлмөрийн гэрээ байгуулах эрхтэй;
- 15 насанд хүрсэн хүн эцэг эх, харгалзан дэмжигчийн зөвшөөрөлтэйгээр хөдөлмөрийн гэрээ байгуулах эрхтэй; (зөвхөн хуулиар хориглоогүй ажлын байранд)
- 16 насанд хүрсэн хүн хөдөлмөрийн гэрээ байгуулах эрхтэй;
- насанд хүрээгүй хүний оюун ухааны хөгжил, эрүүл мэндэд нь харшлах насанд хүрээгүй ажилтныг ажиллуулахыг хориглох ажлын байрны жагсаалтыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална;
- 7 хоногийн ажлын цаг нь 14-15 насны ажилтанд 30 цаг хүртэл, 16 насны ажилтанд 36 цаг хүртэл байна гэж заажээ.

Үүнээс харвал манай улсын дотоодын хууль тогтоомжид заасан хүүхдийн хөдөлмөр эрхлэх насны доод хязгаар нэгдэн орсон гэрээ конвенцийн заалттай зарим талаараа зөрчилдөж байна. Түүнчлэн, хөдөлмөрийн тухай хуулиар “14-15 настай хүн хөдөлмөр эрхэлж болно” гэж заасан нь 138 дугаар конвенцийн ажилд авах насны доод хязгаар 15 наснаас доошгүй гэж заасантай зөрчилдөж байна.

Боловсролын тухай хууль тогтоомжуудад Монгол Улсын иргэн суурь боловсролыг заавал эзэмших үүрэгтэй гэж заагаад бага боловсролыг 6, суурь боловсролыг 9, бүрэн дунд боловсролыг 12 жилд эзэмшүүлж, 2007-2009 оны хичээлийн жилээс хүүхдийг 6 наснаас нь эхлэн сургуульд хамруулах тогтолцоонд шилжих болсон байна. Боловсролын тухай хуулийн эдгээр заалтаас үзвэл хүүхэд суурь боловсролыг 15 насандаа эзэмшихээр харагдаж байна.

Хөдөлмөрийн тухай хуульд 14-15 настай хүүхэд 7 хоногт 30 хүртэл цаг ажиллаж болох бөгөөд 7 хоногт ажлын 5 өдөртэй өнөөгийн нөхцөлд хүүхэд өдөр дутам 6 хүртэл цаг ажиллаж болохоор байх тул тухайн хүүхэд сургуульд суралцах ямарч боломжгүй гэсэн үг юм. ХНДХ-ын тухай ОУХБ-ын 138 дугаар конвенцид хөдөлмөр эрхлэх насны доод хязгаар нь бүрэн бус дунд боловсрол эзэмших нас байх бөгөөд ямарч тохиолдолд 15 наснаас доош байж болохгүй гэж заасан тул манай хуулиар 14-15 насны хүүхдийг 7 хоногт 30 цаг хөдөлмөр эрхлүүлж болохоор заасан нь дээрхи конвенцийн заалттай зөрчилдөж байна гэж үзэх үндэстэй байна.

Тэгээд ч эцэг эхчүүдийн хүүхдийн хөдөлмөрийн талаарх ойлголт төлөвшөөгүй, ажилгүйдэл, ядуурал, ажлын байрны хомсдол ихтэй байгаа өнөөгийн нөхцөлд 14-15 насны хүүхэдтэй эцэг эхийнх нь зөвшөөрлөөр хөдөлмөрийн гэрээ байгуулж, хөдөлмөр эрхлүүлж болохоор хуульчилсныг хүүхдийн эрхийн тааламжтай хамгаалалт гэж үзэх боломжгүй байна. Иймд хөдөлмөрийн тухай хуульд хүүхэд хөдөлмөр эрхлэх насны хэмжээтэй холбоотой заалтуудыг хянан үзэж зохицуулах шаардлагатай байна.

ХНДХ-ын тухай 138, Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай ОУХБ-ын 182-р конвенцуудад “Мөн чанар эсвэл хөдөлмөрийн нөхцлөөрөө хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд сөрөг нөлөө үзүүлэхүйц ажлыг хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрт хамруулж, ийм ажлын төрлийг үндэсний хууль тогтоомжоор эсхүл ажил олгогч, ажилчдын байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр

эрх бүхий байгууллагаас тогтооно” гэж заасан бөгөөд ийм ажлын хувьд ажилд авах насны доод хязгаар 18 нас байхаар тогтоожээ.

Манай улсын хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлд ”Насанд хүрээгүй хүнээр оюун ухааны хөгжил, эрүүл мэндэд нь харшлах хөдөлмөр эрхлүүлэхийг хориглож, насанд хүрээгүй хүүхдийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтыг хөдөлмөрийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн батална” гэж заажээ. ОУХБ-ын холбогдох баримт бичгүүдэд хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд сөрөг нөлөө үзүүлж болохуйц гэсэн 3 шалгуурыг тавьсан байхад манай хуульд зөвхөн оюун ухааны хөгжил, эрүүл мэнд гэсэн шалгуурыг авч “аюулгүй байдал, ёс суртахуун” гэсэн шалгууруудыг орхигдуулсан байна.

Харин Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т “Иргэн, аж ахуйн нэгж хүүхдийг албадан ажиллуулах, ёс суртахуун, эрүүл мэнд, амь насанд нь аюул учруулах хөдөлмөр эрхлүүлэх, хүүхдийн хөдөлмөрийг мөлжлөгийн хэлбэрээр ашиглах, тэдний хөдөлмөрийг шударга бусаар тооцон олгох, гуйлга гуйлгахыг хориглосон” байна. Аж ахуйн нэгж, байгууллагын албан тушаалтнууд Хөдөлмөрийн тухай хуулийг ихэвчлэн судалж, өдөр тутмынхаа үйл ажиллагаанд хэрэглэхгүй байгаагаас Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийг тэр бүр мэддэггүй. Энэ мэтээр нэг асуудлыг өөр өөрөөр зохицуулсныг нэг мөр болгох ёстой.

Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлд заасны дагуу Эрүүл мэнд нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар насанд хүрээгүй хүн ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтыг баталсан байна. Энэ жагсаалтаар 17 төрлийн 300 гаруй төрлийн ажлын байрыг насанд хүрээгүй хүн ажиллуулж болохгүй ажлын байр гэж үзсэн байна. Энэ жагсаалтаар нилээд өргөн хүрээний ажлыг хамруулсан нь сайшаалтай боловч аюулгүй байдал, ёс суртахуунд нь сөрөг нөлөө үзүүлж болох ажлыг бүрэн хамруулаагүй, цаг хугацааны хувьд харьцангуй хоцрогдсон, Засгийн газрын бүтэц өөрчлөгдөж хөдөлмөрийн асуудал хариуцсан бие даасан яамтай болсон зэргээс үндэслэн конвенцийн заалтанд нийцүүлэн уг жагсаалтыг дахин хянан үзэж өөрчлөх шаардлагатай байна.

Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай 182 дугаар конвенцид “улс орнууд хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн жагсаалтыг гаргаад зогсохгүй, эдгээр жагсаалтыг байнга хянан өөрчилж, ийм төрлийн хөдөлмөр оршин байгаа газрыг тогтоож, түүнийг устгах, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ” хэмээн заасан байна. Манай улсын тухайд хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр байгаа газрыг тогтоосон, түүнийг хэрхэн устгах, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр үндэсний хэмжээнд дагнан гарсан үйл ажиллагааны хөтөлбөр одоогоор байхгүй байна.

Харин Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 254 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар 2002-2010 онд хэрэгжүүлэх ”Хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах Үндэсний хөтөлбөр”-ийг баталсан. Уг хөтөлбөрт Монгол Улсад хүүхдийн хөдөлмөрийн талаар үндэсний хэмжээний судалгаа хийгдээгүй, энэ талаарх тоо мэдээлэл хангалтгүй, сургуулиас гадуур байгаа хүүхэд хөдөлмөр эрхэлж, ядуу өрхийн хүүхэд тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхлэх эрсдэл өндөр, насанд хүрээгүй охидыг биеэ үнэлэх ажилд татан оролцуулах явдал түгээмэл болох төлөвтэй байгаа, 5-14 насны хүүхдийн 1.4 хувь нь хөдөлмөр эрхэлж байгааг цохон тэмдэглэсэн байна.

Хөтөлбөрийн зорилт 13-ын хүрээнд ”Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах ажлыг эрчимтэй зохион байгуулж, хүүхэд хууль бусаар ажиллах явдал багассан, хөдөлмөр эрхэлдэг хүүхдийн тоо буурсан, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд устгах нөхцөл бүрдсэн байх зорилтыг дэвшүүлж, хүүхдийн хөдөлмөрийн талаарх олон нийтийн ойлголтыг дээшлүүлж, хөдөлмөр эрхэлдэг хүүхдийн тоог хязгаарлах чиглэлээр өрхийн амьжиргааг дэмжиж, үндэсний хэмжээний судалгаа хийж, уул уурхай дахь хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг нэн даруй таслан зогсооно” гэж заасан байна.

Түүнчлэн, Монгол Улсын Их хурлаас 2004 онд баталсан ”Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого”, 2006 онд баталсан ”Төрөөс албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого” зэрэгт хүүхдийн тэвчишгүй хэлбэрийг устгах зорилтыг тусгасан байна.

ОУХБ-ын 182 дугаар конвенцид ”Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг нэн даруй устгах ёстой” гэж заасан байхад дээрх хөтөлбөрт ”2002-2010 онд тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөрийг устгах нөхцлийг бүрдүүлсэн байна” гэж заасан нь ийм хэлбэрийн хөдөлмөрийг тодорхой хугацаанд байж болохоор зөвшөөрсөн шинжтэй болжээ. Харин энэхүү хөтөлбөрийн хэрэгжилт ямар байгаа нь анхаарал татсан асуудал хэвээр байна. Засгийн газрын 2006 оны 4 дүгээр тогтоолоор Хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийн зорилтыг хангах хоёр дахь шатны үйл ажиллагааны чиглэлийг баталж, 2006-2007 онд насанд хүрээгүй хүн ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтыг баталж, хүүхдийн хөдөлмөрийн талаар үндэсний хэмжээний судалгаа хийнэ гэж төлөвлөсөн боловч одоогийн байдлаар хүүхдийн хөдөлмөрийн асуудлаар үндэсний хэмжээний судалгаа хийгдээгүй, насанд хүрээгүй хүн ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтыг шинэчлэн гаргаагүй, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр бүрмөсөн устгах нөхцөл бүрдээгүй, хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад үнэлгээ хийгдээгүй байна.

Үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах чиглэлээ тодорхойлж, 2015 он гэхэд уул уурхайн салбарт хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах гурван талт уриалгад гарын үсэг зурж, Баянхонгор, Өвөрхангай, Дорноговь, Төв, Дорнод аймгууд хүүхдийн хөдөлмөрийг устгах орон нутгийн үйл ажиллагааны хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлж эхэлсэн байна. Түүнчлэн Хүүхдийн төлөө Үндэсний зөвлөлөөс “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах нөлөөллийн стратеги”- ийг баталж хэрэгжүүлж эхэлсэн нь зарчмын ач холбогдолтой арга хэмжээ болсон. Нийгмийн түншлэлийн байгууллагууд болон орон нутгаас гарсан дээрх санаачлагуудыг Засгийн газар анхааралдаа авч дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна.

2005 оны 11 сард Засгийн газрын 234 дүгээр тогтоолоор “Хүн худалдах ялангуяа хүүхэд эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийг батлан гаргасан байна. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, тэмцэхтэй холбоотой эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хууль хяналтын байгууллагууд болон тэдгээрт ажиллагсдын мэдлэгийг дээшлүүлэх, олон нийтийн сургалт сурталчилгааны ажлыг үр өгөөжтэй зохион байгуулах, хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахын эсрэг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний дагуу хүлээсэн үүрэг, баримт бичигт туссан үйл ажиллагааг үндэсний түвшинд хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байна. Үндэсний хөтөлбөрийг 2006-2007 онд хэрэгжүүлэх ажлын чиглэл, төлөвлөгөөг гаргасан боловч төлөвлөсөн ажлын хэрэгжилт, үр дүн хангалтгүй байна.

ОУХБ-ын 182 дугаар конвенцийг хэрэгжүүлэх зорилгоор мөн байгууллагаас гаргасан 190 дүгээр зөвлөмжийн гуравдугаар хэсгийн 11 дүгээр зүйлд оролцогч улсууд хүүхдийн хөдөлмөрийн дараах тэвчишгүй хэлбэрүүдийг гэмт хэрэг гэж үзэж эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ гэж заажээ. Үүнийг манай улсын хуулиар хэрхэн зохицуулсныг авч үзье.

а/ Боолчлолын бүх хэлбэрүүд болон хүүхдийг хүчээр болон албадан хөдөлмөрлүүлэх.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 121 дүгээр зүйлээр хүүхдийг албадан болон хүчээр хөдөлмөрлүүлхийг гэмт хэрэг гэж үзэж, торгох болон 4 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан байна. Энэ зүйл ангиар ял төлөвлөж шүүхээр ял шийтгүүлсэн тохиолдол хуулийн практикт ганц ч удаа гараагүй байна. Гэвч боолчлолын аливаа хэлбэрийг гэмт хэрэгт тооцох тухай заалт байхгүй байна.

б/ Хүүхдийг худалдах, хил дамжуулан худалдах, өрийн төлөөс, хамжлагын албат болгох.

2002 онд батлагдсан Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлээр хүн худалдах, худалдан авахыг гэмт хэрэгт тооцож, харин хүүхдийг худалдах, худалдан авахыг тухайн зүйл ангиар хүндрүүлэн зүйлчлэхээр тогтоосон байжээ. 2008 онд УИХ-аас батлан гаргасан Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр дээрхи зүйлийг хүн худалдаалах гэмт хэрэг гэж өөрчилж, хүүхдийг худалдсан бол хүндрүүлэн зүйлчлэхээр тогтоосон байна. Эрүүгийн хуулийн шинэ өөрчлөлтөөс үзвэл манай улсад зөвхөн хүн /хүүхэд/ худалдсан этгээд л эрүүгийн хариуцлага хүлээх, худалдан авсан этгээд нь эрүүгийн хариуцлага хүлээхээргүй болсон харагдаж байна. Хүүхдийг худалдсан мөнгө авсан, худалдаж авсан мөнгө төлсөн аль аль нь адилхан буруутай бөгөөд хариуцлага хүлээх учиртай.

Авлига өгсөн авсныг аль алиныг нь шийтгэдэгтэй нэгэн адил асуудал тул хуулийн энэ өөрчлөлтийг оновчтой болсон гэж үзэх боломжгүй байна. Энэ зүйл ангийг дээрх маягаар өөрчилсөн нь хүн худалдах гэмт хэрэг нь ихэвчлэн хил дамжин үйлдэгддэг тул худалдан авсан этгээдийг илрүүлэх боломжгүй болж энэ хэрэг шийдэгддэггүй гэсэн хуулийн байгууллагын ажилтнуудын тайлбар, дүгнэлттэй холбоотой гэнэ. Тэгээд ч хүн худалдсан, худалдан авсан этгээдүүд манай улсын иргэд, энд амьдарч буй гадаадын иргэд байхыг үгүйсгэх аргагүй.

Манай улсын хууль тогтоомжоор хүүхдийг өрийн төлөөс, хамжлагын албат болгох асуудлыг гэмт хэрэгт тооцоогүй байна. Ийм үйлдлүүдийг урьд өмнө нь ч гэмт хэрэг гэж хуульд тусгаж байгаагүй. Ажилгүйдэл, ядуурал ихтэй өнөөгийн нөхцөлд бусдад өгөх өр, төлбөртөө өөрийн хүүхдээ өрийн төлөөс болгон өгөхийг үгүйсгэх аргагүй. Аливаа гэмт үйлдлийг гарсных нь дараа бус харин гарахаас нь урьдчилан сэргийлэх, гарсан тохиолдолд хариуцлага хүлээлгэхээр гэмт хэрэгт тооцож хуульчилдаг тул эдгээр үйлдлүүдийг гэмт хэрэг гэж Эрүүгийн хуульд тусгах шаардлагатай.

в/ Хүүхдийг биеэ үнэлэх үйл ажиллагаа, садар самууны сурталчилгаа, үзүүлбэрт ашиглах, татан оролцуулах.

Эрүүгийн хуулийн 123 дугаар зүйлд садар самууныг сурталчилсан ном, хэвлэл, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг бэлтгэх, тараах, борлуулах, нийтэд үзүүлэх, хилээр оруулж ирэхийг гэмт хэрэг гэж үзжээ. Харин энэ хэрэгт 16 насанд хүрээгүй хүнийг татан оролцуулсан болон насанд хүрээгүй хүнд хүч хэрэглэж татан оролцуулсан бол хүндрүүлэн зүйлчлэхээр тогтоожээ. Хуулийн энэ заалтаас харвал 16-17 насны хүүхдүүдийг хүч хэрэглэхгүйгээр садар самууны үйлдвэрлэл, сурталчилгаа, борлуулалтанд татан оролцуулсан тохиолдолд уг үйлдлийг хүндрүүлэн зүйлчлэхээргүй байгаа нь ОУХБ-ын 190 дүгээр зөвлөмжийн “18 насанд хүрээгүй

хүнийг” садар самууны үйлдвэрлэл, сурталчилгаа, үзүүлбэрт ашиглахыг гэмт хэрэг гэж үзнэ гэсэн заалттай зөрчилдөж байна. Харин садар самуунтай тэмцэх тухай хуулиар эротик ном, хэвлэл, дүрс бичлэгийг насанд хүрээгүй хүнд худалдах, түүгээр худалдуулахыг, 18 насанд хүрээгүй хүнийг шөнийн цэнгээний газарт оруулах, эротик тоглолтод оролцуулахыг хориглосон байна. Хуулийн эдгээр журмыг зөрчвөл захиргааны хариуцлага хүлээлгэхээр тогтоожээ.

Харин насанд хүрээгүй хүнийг согтуурал, мансуурал, тэнүүчлэл, гуйланчлал болон биеэ үнэлэх үйл ажиллагаанд татан оролцуулах (эрүүгийн хуулийн 115 дугаар зүйл)-ыг бие даасан гэмт хэрэг болгон авч үзэж, энэ гэмт хэргийг хүүхэд хүмүүжүүлэх үүрэг бүхий эцэг, эх, сурган хүмүүжүүлэгч, харгалзан дэмжигч үйлдсэн буюу энэ гэмт хэргийг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж үйлдсэн бол хүндрүүлж зүйлчлэхээр тогтоожээ. Түүнчлэн, биеэ үнэлэх газар байгуулсан, санхүүжүүлсэн, биеэ үнэлэхэд зуучилсан, тээврийн хэрэгсэл, орон байр, бусад зүйлээр тусалсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр Эрүүгийн хуулийн 124 дугаар зүйлд заажээ. Иймээс насанд хүрээгүй хүнийг биеэ үнэлэхэд татан оролцуулсан буруутай хүмүүст хүлээлгэх хариуцлагыг хууль тогтоомжийн хүрээнд сайтар зохицуулсан гэж үзэхээр байна.

г/ Мансууруулах бодис үйлдвэрлэх, наймаалахад насанд хүрээгүй хүнийг татан оролцуулах.

Эрүүгийн хуулийн 192 дугаар зүйлээр мансууруулах бодис хууль бусаар бэлтгэсэн олж авсан, хадгалсан, тээвэрлэсэн, борлуулсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр тооцож, энэ гэмт хэрэгт насанд хүрээгүй хүнийг татан оролцуулсан бол ял шийтгэлийг хүндрүүлж үзэхээр тогтоосон байна. ОУХБ-ын баримт бичгүүдэд дотоодын хууль тогтоомжоороо гэмт хэрэг гэж тооцохыг зөвлөсөн хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг манай хууль тогтоомжоор хэрхэн шийдвэрлэснийг авч үзэхэд ийм байна.

Хууль тогтоомжоороо эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан хэдий ч ийм төрлийн хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах, шийдвэрлэх хуулийн практикийг тогтоох, ялангуяа хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэртэй холбоотой хууль (эрүүгийн) тогтоомжийг тайлбарлах, сургалт зохион байгуулах нь чухал ач холбогдолтой. Дээр дурдсан гэмт хэргүүдийн талаар Улсын дээд шүүхээс албан ёсны тайлбар гараагүй байгаа нь анхаарал татаж байна.

ОУХБ-ын 190 дүгээр зөвлөмжид гишүүн орнууд хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг хориглох, устгахад чиглэгдсэн хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх эрүүгийн, иргэний, захиргааны бусад хариуцлагыг нэн даруй тодорхойлхын зэрэгцээ урьд нь хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг ашиглаж байсан үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагад тусгай хяналт тавьж, хууль тогтоомжийг зөрчсөн хэвээр байвал тухайн байгууллагын үйл ажиллагааг түр болон бүрмөсөн зогсоох хүртэл арга хэмжээ авах хэрэгтэй гэж заажээ.

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуульд насанд хүрээгүй хүмүүсийн хөдөлмөрийн тухай асуудлыг тусгайлан авч үзэж, насанд хүрээгүй хүнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах журам, ажлын цаг, эрүүл мэндийг нь хамгаалах асуудлыг зохицуулж, насанд хүрээгүй хүнийг шөнийн буюу илүү цагаар амралт, байр ёслолын үеэр ажиллуулах, насанд хүрээгүй хүн ажиллуулахыг хориглосон буюу хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлтэй ажилд ажиллуулахыг хориглосон байна. Хөдөлмөрийн тухай хуулиар насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажил гүйцэтгүүлсэн, зөвшөөрөгдсөн хэмжээнээс илүү хүнд ачааг өргүүлсэн, насанд хүрээгүй хүнийг хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлтэй болон түүний оюун ухааны хөгжил, эрүүл мэндэд нь харшлах ажлын

байранд, эсхүл шөнийн цагаар буюу илүү цагаар ажиллуулсан албан тушаалтныг арван таваас гучин мянган төгрөгөөр торгохоор заасан байна. Насанд хүрээгүй хүний хөдөлмөрийн харилцааг зохицуулсан Хөдөлмөрийн тухай хуулийн заалтыг зөрчсөн албан тушаалтанд хүлээлгэх хариуцлага (торгууль)-ын хэмжээ нь бусад заалтыг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагаас харьцангуй доогуур байгаа нь хүүхдийн эрхийн асуудалд илүү анхаарал хандуулах ёстой гэсэн Хүүхдийн эрхийн тухай конвенцийн ерөнхий зарчимд нийцэхгүй байна.

Харин насанд хүрээгүй хүний хөдөлмөртэй ялангуяа хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэртэй холбоотой хууль тогтоомжийг зөрчсөн байгууллага, аж ахуйн нэгжид хариуцлага хүлээлгэх, нөхөн төлбөр оногдуулах, түүний үйл ажиллагааг зогсоох тухай асуудал ямар ч хууль тогтоомжид тусгалаа олоогүй байна.

Эрүүгийн хуулийн 138 дүгээр зүйлд хөдөлмөрийн хууль тогтоомж зөрчих буюу хөдөлмөр хамгааллын хэрэг гэж нэршсэн гэмт хэргийн бүрэлдэхүүнийг тодорхойлжээ. Энэ зүйлд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн журмыг сахин хангуулах үүрэг бүхий этгээд энэ үүргээ хангалтгүй биелүүлснээс хүний бие махбодид хүндэвтэр буюу хүнд гэмтэл учирсан, хүний амь хохирсон бол гэмт хэрэг гэж үзэхээр зааж хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн журмыг сахин хангуулах үүрэг бүхий этгээд энэ үүргээ биелүүлээгүйгээс бусдын бие махбодид хүндэвтэр, хүнд гэмтэл учирсан, хүний амь хохирсон, хүнд хор уршиг учирсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заажээ. Үүнээс өөр хөдөлмөрийн тухай хууль тогоомжийг зөрчсөн үйлдлийг гэмт хэрэгт тооцох заалт байхгүй байна.

Насанд хүрээгүй хүний хөдөлмөртэй холбоотой хууль тогтоомж, ялангуяа хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэртэй холбоотой хөдөлмөрийн хууль тогтоомжийг зөрчиж, хүүхдийн эрх ашигт ноцтой хохирол учруулсан гэм буруутай албан тушаалтанд эрүүгийн хариуцлага тооцох тухай заалтыг эрүүгийн хуульд оруулах шаардлагатай байна.

Гурав: Хүүхдийг наймаалах, бэлгийн мөлжлөг, садар самууны сурталчилгаанд ашиглах, мансууруулах бодис үйлдвэрлэх борлуулахад татан оролцуулах, хүчээр хөдөлмөрлүүлэх зэрэг гэмт хэргийн нөхцөл байдал

3.1. Насанд хүрээгүй хүмүүсийг бэлгийн мөлжлөгт ашиглах гэмт хэрэг.

Хүүхдийг биеэ үнэлэх үйл ажиллагаа, садар самууны үйлдвэрлэл, сурталчилгаанд ашиглахыг хүүхдийн эсрэг ноцтой гэмт хэрэг гэж үздэг тул энэ гэмт хэргийн нөхцөл байдлыг судлан тогтоох нь түүнээс урьдчилан сэргийлэх гол нөхцөл мөн. Эрүүгийн хуулийн 115-р зүйлд насанд хүрээгүй хүнийг биеэ үнэлэхэд татан оролцуулсан бол торгох, албадан ажил хийлгэх, 3 сар хүртэл баривчлах ял оноохоор заажээ. Харин энэ хэргийг хүүхэд хүмүүжүүлэх үүрэг бүхий этгээд, эцэг эх, асран хамгаалагч үйлдсэн, эсвэл хүч хэрэглэж, давтан үйлдсэн бол ял шийтгэлийг хүндрүүлж оногдуулхаар заасан. Шүүхийн байгууллагын статистик мэдээгээр сүүлийн 3 жилд эрүүгийн хуулийн 15-р зүйлд зааснаар насанд хүрээгүй хүнийг биеэ үнэлэхэд татан оролцуулсан хэрэгт 2005 онд 1 хүн, 2006 онд 1 хүн ял шийтгүүлсэн байна. Дархан-уул аймгийн иргэн Б.Ариунзаяа 1998 оноос хойш насанд хүрээгүй охидуудын биеийг үнэлүүлж байсан хэрэгт 2005 онд нэрүүгийн хуулийн 115-р зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар ял шийтгүүлжээ. 2006 онд Дорноговь аймгийн Замын-үүд сумын иргэн Г.Даваасүрэн иргэн Э-г насанд хүрээгүй Г-ийн хамт хуурч мэхлэн улсын хилээр гарган БНХАУ-д биеийг үнэлүүлсэн, зуучилсан хэрэгт Эрүүгийн хуулийн 115-р зүйлийн 1 дэх хэсгээр ял шийтгүүлсэн байна.

Хуулийн байгууллагуудаас гаргасан баримжаа тоогоор гудамж талбайд биеэ үнэлдэг 1600 орчим, гадаад улс оронд биеэ үнэлдэг 1000 орчим, караокед биеэ үнэлдэг 400 орчим, саун, массажны газар биеэ үнэлдэг 200 гаруй буюу давхардсан тоогоор 2300 орчим биеэ үнэлдэг эмэгтэйчүүд байдаг гэж тооцсон байна.

Нийслэлийн цагдаагийн газрын олон нийтийн харилцааны хэлтсээс гаргасан мэдээгээр хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд буюу нэгдсэн арга хэмжээгээр биеэ үнэлдэг нь тогтоогдсон, хүүхдийн байцаагчийн хяналтанд байдаг насанд хүрээгүй охидын тоо 2005 онд 93, 2006 онд 156, 2007 оны эхний 9 сарын байдаар 127 гэж гарсан байна.

Эрүүгийн цагдаагийн газраас гаргасан мэдээгээр улсын хэмжээнд биеэ үнэлсэн гэсэн үндэслэлээр захиргааны арга хэмжээ авагдсан насанд хүрээгүй хүүхдүүд 2005 онд 380, 2006 онд 412, 2007 онд 426 /давхардсан тоогоор/ болж өссөн байна. Энэ тоо мэдээнээс харвал биеэ үнэлдэг насанд хүрээгүй хүүхдийн тоо сүүлийн жилүүдэд буураагүй байна.

Улаанбаатар хотод 200 орчим зочид буудал, 700 орчим баар цэнгээний газар, 130 орчим саун массажны газар, 50 орчим караоке үйл ажиллагаа явуулж, тэднийг ажиллуулж буй хүмүүс ашиг орлого олохын тулд биеэ үнэлэгчидтэй хамтарч ажилладаг, тийм үйл ажиллагааг хөхиүлэн дэмждэг тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр ихээхэн яригдах болсон нь оргүй зүйл биш. Зарим зочид буудал, баар, саун биеэ үнэлэх үйл ажиллагааг зохион байгуулж байсан тухай мэдээлэл шалгагдаж байсан байна.

2002-2008 онд бусдыг биеэ үнэлэхийг зохион байгуулсан гэсэн үндэслэлээр 54 эрүүгийн хэрэг үүсгэгдэн шалгагдсанаас сүүлийн 3 жилд 26 хүнийг энэ төрлийн гэмт

хэрэгт холбогдуулан шалгажээ. Эдгээр тоо баримтууд нь хүүхдийг бэлгийн мөлжлөгт ашиглагдах нөхцөл боломж аль хэдийн бүрдсэнийг харуулж байна.

Манай улсын хувьд биеэ үнэлэгч болон бэлгийн мөлжлөгт хамрагдаж байгаа охидын судалгааг төрийн болон төрийн бус байгууллагын зүгээс нилээдгүй хийсэн байна. Охидуудын бэлгийн харьцаанд орж байгаа насны дундажийг 14.4 гэж судалгаагаар тогтоосон боловч зарим тохиолдолд 8 настайдаа ч бэлгийн харьцаанд орсон тухай зарим судалгаанд дурдсан нь анхаарал татаж байна. Насанд хүрээгүй охидын анх бэлгийн харьцаанд орсон байдлыг судалж үзэхэд найз, үе тэнгийнхэнтэйгээ гэж 45.5 хувь нь, хойд эцэг, дагавар хүүхэдтэй нь гэж 36.1 хувь нь, тэнэмэл хүмүүс, танихгүй хүнтэй гэж 18.2 хувь нь, мөнгөтэй болохын тулд өөрийн хүсэлтээр гэж 16.4 хувь нь тус тус хариулсан байна.

Олон жил тэнэмэл амьдралаар амьдарсан, айлд амьдардаг, халамжийн төв дамжин амьдардаг, орон нутгийн шилжилт хөдөлгөөнөөр хөдөө орон нутгаас нийслэл хотод нүүн ирж амьдарч буй өрхийн, ядуу өрхийн, сургууль завсардсан, гэр бүлийн хүчирхийлэлд өртдөг, зах дээр хөдөлмөр эрхэлдэг, эцэг эх нь салсан, хойд эцэгтэй гэр бүлийн охидууд бэлгийн мөлжлөгт илүү ихээр өртдөг байна.

Э охин 15 настай. Хотын захын нэгэн хороололд хойд эцэг, эхийн хамт амьдардаг. Эхийг нь төрсөн нутаг руугаа яваад ирэх хооронд тийний хойд эцэг хич тирэмгийлэн хичиндсэн байна. Энэ явдал хойд эцгээр нь зогсоогий эцгийнх нь дагавар хий бас тийнийг хичиндсэн байна. Тийний дараа тэрээр гудамжинд тэнэмэл амьдралаар амьдарч байгаад одоо ЦЕГ-ын хийхдийн албанд хандан “Хийхдийн хаяг тогтоох, халамж ийлчилгээний төв”-д амьдарч байна.

“Есвэр іе хөгжил төв” ТББ-ын судалгаанаас...

Хүүхдийг бэлгийн мөлжлөгт бэлгийн дур хүслээ хангах зорилгоор ашиглагчдын хүрээнд бүх насны эрэгтэйчүүд, зах дээр хувиараа хөдөлмөр эрхлэгч нар, гудамжны тэнэмэл амьдралтай насанд хүрсэн эрчүүд, гудамжны үе тэнгийн хөвгүүд, архинд донтогсод, бэлгийн гаж донтой хүмүүс, хөдөө орон нутгаас бизнес хийгчид, хятад ажилчид илүүтэйгээр хамрагддаг байна.

Ц охин 14 настай. халамжийн төвд амьдардаг. Ээж нь бага насанд нь нас барсан. Эцэгтэйгээ хамт амьдардаг. Ядуу учраас аавынх нь найз “Г” гэгч тэднийхээр байнга орж гардаг байсан. Ц-ийн эцэг нь найз Г-ийн хамт гэртээ ирж архидсан бөгөөд энэ хооронд миний тусламж байхгүй бол танайх амьдрал байхгүй, тиймээс чи надтай унтах ёстой хэмээн сїрдїїлж байгаад хичиндсэн байна. Іїнээс хойш эцгийг нь байхгүй хооронд энэ явдал байнга давтагдах болсон байна. Ц охин тїїнээс зугатаан гудамжинд тэнэдэг болсон бөгөөд Цагдаагийн хийхдийн албанд баригдан одоогийн байдлаар “Хийхдийн хаяг тогтоох халамж ийлчилгээний төв”-д амьдарч байна.

“Есвэр іе хөгжил төв” ТББ-ын судалгаанаас

Хүүхэд бэлгийн мөлжлөгт өртөх боломж олгодог газрууд нь зочид буудал, дэн буудлын газрууд, хотын захын гэр хороололд үйл ажиллагаа явуулдаг гэр буудлууд, хөлсний байрууд, траншейнууд, захын ойролцоох нууц газрууд, шөнийн зогсоолууд, саун массажны газрууд, бар цэнгээний газрууд, хятад ажилчдын ажилладаг болон амьдардаг байрууд, байгууллагын болон барилгын харуул, сахиулуудын байрууд болдог байна.

Охидыг бэлгийн мөлжлөгт татан оролцуулдаг, зуучилдаг хүмүүст биеэ үнэлэгч насанд хүрсэн эмэгтэйчүүд, өмнө нь биеэ үнэлж байгаад больсон эмэгтэйчүүд, траншейнд амьдардаг үе тэнгийн хөвгүүд, үе тэнгийн биеэ үнэлэгч охидууд, цагаан утасны үйлчлэгчид, зочид буудлын үйлчлэгч, хүлээн авагчид, таксины жолооч нар, бар шөнийн цэнгээний газрын үйлчлэгчид, үйлчилгээний газрын хамгаалагч нар хамрагддаг байна.

2008 онд УМБГ-аас саун массажны газруудад хийсэн нэг удаагийн шалгалтаар насанд хүрсэн “Б” гэгч нь охид, бүсгүйчүүдийг биеэ үнэлэхийг зохион байгуулж, энэ үйл ажиллагаандаа 17 настай “Н”-ийг татан оролцуулж, тэдгээр охид, бүсгүйчүүдээс мөнгө хураадаг ажлыг хийлгэдэг байсныг илрүүлж, эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байна.

Охидуудыг бэлгийн мөлжлөгт ашиглагдах, биеэ үнэлэх, бэлгийн хүчирхийлэлд өртөхөд хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгэж байгаа зар, сурталчилгаанууд ихээхэн нөлөөлж, боломж олгодог гэж үзсэн байна. Тухайлбал интернет дахь нийтлэл, порно үзүүлбэрүүд, ТВ-ийн дуу хөгжим, клиптэй зар сурталчилгаанууд, TV чатууд, FM радиогоор цацагдаж байгаа зарууд нь гэмт этгээдүүд дээрх үйл ажиллагаагаа явуулахад нь боломж олгодог, бас дэмжлэг үзүүлдэг байна.

2007 онд “Монголын Эмэгтэйчүүдийн сан” төрийн бус байгууллага, МУИС-ийн Социологи, нийгмийн ажлын тэнхимтэй хамтран “Хэвлэл мэдээллийн хэрэгслээр садар самууныг сурталчилж буй өнөөгийн байдал” сэдэвт тандалтын судалгаа явуулж, өдөр тутмын 1 сонин, чөлөөт хэвлэлээс 2 сонин, орон даяар нэвтрүүлгээ цацдаг МҮОНТВ ба зөвхөн УБ хотод нэвтрүүлгээ цацдаг С1, TV8 телевизүүдийн tv чат сувгийг сонгон авч зар сурталчилгааны байдалд нь судалгаа хийжээ.

Энэ судалгаагаар С1 телевиз садар самуунтай холбоотой мэдээлэл нь 1680 минут буюу нийт нэвтрүүлгийн 11.02% байсан бол TV8 телевиз нь 13560 минут буюу нийт нэвтрүүлгийн 88.97% байсан байна. ТВ-чат нэвтрүүлэгт оролцогчдын насны байдлаар авч үзвэл 14-24 насныхан нийт оролцогчдын 50 гаруй хувийг эзэлж байсан байна.

/Монголын эмэгтэйчүүдийн сан МУИС-ын хамтарсан судалгаанаас/

2005 онд МУИС-ын Хүн ам зүй, сургалт судалгааны төв, Хүйсийн тэгш эрхийн төв зэрэг төрийн бус байгууллага хамтран Улаанбаатар хот, Дархан-Уул, Дорноговь аймгийн Замын-Үүд, Дорнод аймгийн Хавиргын боомтод амьдарч биеэ үнэлэж байгаа 91 охид, эмэгтэйчүүдийн дунд судалгаа хийжээ. Судалгаагаар 16-17 насны охидууд санхүүгийн болон гэр бүлийн амьдралын тааламжгүй байдал, сургууль завсардалт, олон хүүхэдтэй, эцэг эх нь салсан, дахин гэрлэсэн, гэр бүлийнхний дарамт шахалт,

хүчирхийлэл, найзуудтайгаа болон ганцаараа амьдардаг, үйлчилгээний салбарт урьд ажиллаж байсан, өмнө нь бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан зэрэг нь биеэ үнэлэх зам руу орох шалтгаан болсон гэж гарсан байна.

Нийт судалгаанд хамрагдсан охидуудын хамгийн бага нь 12 настай байсан ба 60 гаруй хувь нь 18 ба түүнээс доош насандаа бэлгийн харьцаанд орж биеэ үнэлж эхэлсэн байна. Эдгээр хүмүүсийн биеэ үнэлж байгаа нөхцөл байдлыг харахад бараг тал хувь нь гудамжинд зогсож биеэ үнэлдэг, гуравны нэг нь зочид буудал, баар сауны газраар явдаг байна. 14-15 насны охидын хувьд 46 хувь нь гудамжинд, 8 орчим хувь нь шөнийн цэнгээний газруудаар явж биеэ үнэлдэг. Олсон орлогын хувьд 63.7 хувь нь орлогоо шууд өөрөө авдаг бол 14-15 насны охидын 84.6 хувь нь зуучлагч төлбөрийг нь авдаг гэсэн хариултыг өгсөн байна.

Ер нь биеэ үнэлэгч насанд хүрээгүй охидын хувьд өөрөө бие даан биеэ үнэлэх явдал бараг байдаггүй бөгөөд ихэвчлэн зуучлагчаар дамжуулан үйлчлүүлэгчээ сонгодог, орлогоо зуучлагчаараа дамжуулан авдаг нь илт байна. 14-15 насны бүх охид, 16-18 насны охидын 53.6 хувь нь зуучлагчаар дамжуулан үйлчлүүлэгчээ олж биеэ үнэлдэг байна. Тэгвэл үйлчлүүлэгчийн насны байдлыг үзэхэд үйлчлүүлэгчийн дундаж нас 33.3 бөгөөд хамгийн залуу нь 14-тэй, хамгийн ахмад нь 60 настай хүн байжээ.

Улсын хэмжээнд гарч байгаа гэмт хэргийн нөхцөл байдалд судалгаа хийж үзэхэд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 124 дүгээр зүйлд заасан биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг 2004-2007 оны эхний 9 сарын байдлаар гэхэд 12 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэснээс 7 хэргийг хэрэгсэхгүй болгож 5 хэрэгт яллах дүгнэлт үйлдүүлэхээр прокурорын байгууллагад шилжүүлсэн байна. 2007 оны 12 дугаар сард насанд хүрээгүй охидтой танилцаж, эрэлт хэрэгцээг нь судалж, зохион байгуулалттайгаар биеийг нь үнэлүүлдэг иргэн П-г цагдаагийн байгууллага эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байна.

2007 оны 12 сард 15 настай охин М насанд хірсэн иргэн П-тэй танилцсан бөгөөд 1 сарын дараанаас эхлэн охины биеийг нь бусдад албан хичээр інэліілэх болсон байна. Цагийн 15.000 төгрөгээр бусдад інэлдэг болсон.

/Эрїігийн хавтаст хэргээс/

Насанд хүрээгүй охид хүчингийн гэмт хэргийн хохирогч болох нь тэдгээр охид цаашдаа биеэ үнэлэх, биеэ үнэлэхэд бусдад уруу татагдахад зохих хэмжээгээр нөлөөлж байна гэсэн дүгнэлт гарсан байна. Насанд хүрээгүй хүүхдийг хүчиндэх /Эрүүгийн хуулийн тусгай ангийн 126 дугаар зүйлийн 126.2.4, 126.3 дэх хэсэг/ гэмт хэргийн тоо өсөх хандлагатай байна.

Шүүхээр 14 насанд хүрээгүй хүнийг хүчиндсэн хэрэгт /эрүүгийн хуулийн 126.3/ 2006 онд 41 хэрэгт 46 хүн, 2007 онд 54 хэрэгт 61 хүн, насанд хүрээгүй хүнийг хүчиндсэн /эрүүгийн хуулийн 126.2.4/ хэрэгт 2006 онд 34 хэрэгт 36 хүн, 2007 онд 26 хэрэгт 32 хүн тус тус ял шийтгүүлжээ.

У 15 настай , Хичит шонхор зах дээр лангуу угаадаг. Ээж ах 2-ын хамт амьдардаг ба ээж нь бие муутай, ах нь одоохондоо ажилгүй байгаа. У едөржин ажиллаад дээд тал нь 1500 төг олдог. Зах дээр ажил хийж байхад нь 3 залуу хйрч ирээд "Хэрвээ чи бид 3-тай унтвал чамд утас авч өгнө" гэхэд нь У зөвшөөрөөд тэр гуравтай унтсан. Охидын эмчид ізілэхэд БЗХС –тэй гэсэн онош гарсан .

2007 оны байдлаар УМБГ-ын онц хүнд, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс дээр эрүүгийн хуулийн тусгай ангийн 124 дүгээр зүйлийн 124-ийн 2-т заасан гэмт хэргийг үйлдсэн гэх иргэн М, П нарт холбогдох 2 хавтаст хэргийг шалгаж байна. Эдгээр хэргээс харахад 16-17 насны орон гэргүй, ядуу амьдралтай өрхийн 4-5 охидыг дарамтлан сэтгэл санааны дарамтанд оруулан тусгай оромжинд байлган хүчээр биеийг нь үнэлүүлж байсан байна. Эдгээр 2 хэргийн нэгийг прокурорт яллах дүгнэлт үйлдүүлэхээр шилжүүлсэн бөгөөд нөгөө нь мөрдөн байцаалтын шатанд шалгагдаж байна.

Эрүүгийн цагдаагийн газраас авсан мэдээллээр насанд хүрээгүй хүмүүс насанд хүрэгчдэд уруу татагдаж биеэ үнэлхийн зэрэгцээгээр насанд хүрээгүй хүмүүс /охид/-ч биеэ үнэлэх асуудлыг зохион байгуулдаг, бусад насанд хүрээгүй хүмүүсийг энэ хэрэгт татан оролцуулах болсон нь энэ гэмт хэрэг багагүй газар авсныг харуулж байна. 2007 онд насанд хүрээгүй байхдаа бусдыг биеэ үнэлэхэд татан оролцуулсан, биеэ үнэлэхийг зохион байгуулсан хэрэгт насанд хүрээгүй 4 хүүхэд татагдан шалгагдаж байна. Энэ баримт бол үнэхээр сэтгэл түгшээсэн маш ноцтой асуудал мөн. Насанд хүрээгүй хүмүүс бусдад уруу татагдаад зогсохгүй үе тэнгийнхнийгээ биеэ үнэлэхэд татан оролцуулах болсон хор уршиг, үр дагаврын хувьд илүү ноцтой байх болно.

3.2. Хүүхэд худалдаалах, хил дамжуулан худалдаалах гэмт хэрэг

Манай улс дахь ажилгүйдэл, ядуурал, эмэгтэйчүүдийн биеэ үнэлэх явдал газар авсан, иргэд олноороо гадаадад гарч цагаачлан хөдөлмөр эрхэлж, ажиллаж амьдрах болсон, гадагшаа чиглэсэн ажиллах хүчний том урсгал болон залуучуудын ямар аргаар ч болов гадаадад явах гэсэн хүсэл, эрмэлзлэлийг тойрсон урилга, визийн зөвшөөрөл, охид эмэгтэйчүүдийг гадаадын иргэнтэй гэрлүүлэх, зуучлах тухай зарлал мэдээлэл чөлөөтэй явагдаж, хууль бус залилан мэхлэх үйл ажиллагаа цэцэглэж байгаа нь эмэгтэйчүүд, хүүхдийг худалдах, хил дамжуулан худалдаалах, бэлгийн мөлжлөгт ашиглах гэмт хэрэг үйлдэгдэх таатай нөхцлийг бүрдүүлж байна хэмээн манай Комиссын 2003 оны илтгэлд тэмдэглэж, 2000 онд 2 эмэгтэйг Европын орнуудад аваачиж биеийг нь үнэлүүлж, улмаар худалдаж байсан хэргийн тухай дурьдаж, энэ асуудалд анхаарлаа хандуулах цаг болсныг сануулж байжээ. Тэр үеийн нөхцөл байдалтай өнөө үеийг харьцуулж үзэхэд нөхцөл байдал дээрдээгүй, улам бүр хүндэрч, нийгмийг хамарсан асуудал болсныг хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарч байгаа мэдээ мэдээлэл, төрийн болон төрийн бус байгууллагуудын байр суурьнаас харж болно.

Хүн худалдаалах гэмт хэрэгт өртөх эрсдэл ихтэй бүлгүүдийн тоонд биеэ үнэлэгчид, тэр тусмаа насанд хүрээгүй биеэ үнэлэгчид, хараа хяналтгүй орон гэргүй хүүхдүүд, гэр бүлийн хүчирхийлэл, дарамт шахалтанд байдаг хүүхдүүд, хүнд хүчир хөдөлмөр эрхэлдэг ядуу амьдралтай хүүхдүүд ордог. Тэд нарийн зохион байгуулалт бүхий гэмт бүлэглэлүүдийн ашиг олох хамгийн тохиромжтой, хямд төсөр объект нь болдог.

Манай улсын тухайд хүүхэд худалдаалах гэмт хэрэг гарах тааламжтай хөрс суурь бий болж байна гэдгийг судалгааны дараах үзүүлэлтүүд харуулж байна. Хүүхдийн хаяг тогтоох төв буюу Нийслэлийн цагдаагийн халамж үйлчилгээний төв нь орон гэргүй, хараа хяналтгүй, орц хонгил, захуудаар амьдардаг хүүхдийг тус төвд албадан авчирч 14 хүртэл хоногийн хугацаатай байлгаж, хаягийг нь тогтоож, эцэг эх, асран хамгаалагчид нь хүлээлгэж өгөх, асрамж халамжийн газар шилжүүлэх үйл ажиллагаа явуулж байна. Энэ төвд 2006 онд 03-16 насны 1128 хүүхэд /207 охид, 921 хөвгүүд/, 2007 онд 1067 хүүхэд /157 охид, 910 хөвгүүд/ хүргэгдэн ирж зохих газруудад нь шилжүүлжээ.

Нийслэл Улаанбаатар хотод хүүхдийн халамж үйлчилгээний 40 гаруй төвд энэ оны байдлаар 1450 орчим хүүхэд амьдарч байна.

Цагдаагийн байгууллагад огт хараа хяналтгүй хүүхэд 2005 онд 72, 2006 онд 58, 2007 онд 50 бүртгэгджээ. Улаанбаатар хотод траншейнд тогтмол амьдардаг 50-67 хүүхэд бүртгэлтэй байдаг бөгөөд улирлын байдлаас шалтгаалан тоо хэлбэлзэлтэй байдаг байна. Сүүлийн жилүүдэд орц, траншейнд амьдардаг тэнэмэл хүүхдийн тоо цөөрсөн нь эдгээр хүүхдүүд гадагш худалдагдаж байгаатай холбоотой гэж судалгааны явцад ярилцлагад орсон хүмүүс ярьж байна. Харин 2008 онд Нийслэлийн цагдаагийн олон нийтийн харилцааны хэлтэс, Хүүхдийн төлөө үндэсний газараас зохион байгуулсан “Халамж-2008” ар хэмжээний үеэр хараа хяналтгүй, дулааны цооног, орц, хонгил, худалдааны төвүүдээр хоноглож байсан 99 хүүхдийг судлан бүртгэсэн байна. /Өдрийн сонин 2008.0306.№54/

Нийслэл хотын хэмжээнд биеэ үнэлэгч охид 2005 онд 93, 2006 онд 47, 2007 онд 127 байгааг цагдаагийн байгууллага бүртгэжээ. Дээр дурьдсан тоо баримтуудаас харахад хараа хяналтгүй худалдаалагдах, гэмт үйлдлийн золиос болох магадлал өндөртэй олон тооны хүүхэд байгаа болох нь харагдаж байна. Иймд хараа хяналтгүй, орон гэргүй, хүчирхийлэл дарамтанд өртсөн, биеэ үнэлж буй хүүхдүүдийн бүртгэл, судалгааг сайжруулж, нэгдсэн бүртгэлийн сантай болгож, шилжилт хөдөлгөөнд нь хяналт тавих тогтолцоог бий болгох нь хүүхэд худалдаалагдахаас сэргийлэх нэн чухал нөхцөл болно.

Шүүхийн статистик мэдээгээр хүн худалдаалах гэмт хэрэгт 2006 онд 1 хэрэгт 1 хүн, 2007 онд 1 хэрэгт 3 хүн ял шийтгүүлжээ. Гэхдээ эдгээр хэргийн хохирогчид нь насанд хүрсэн хүмүүс байсан байна. Нас бие гүйцсэн хүмүүс худалдагдаж байхад насанд хүрээгүй хүмүүс худалдагдаагүй гэх баталгаа байхгүй. Түүнчлэн судалгааны явцад хүн, хүүхэд худалдаалах зарим гэмт хэрэг шалгагдаж байсан байна.

2007 оны 7 дугаар сард иргэн Б, Ц нарыг хуурч мэхлэн биеийг нь үнэлүүлэхээр хилээр авч гарсан хэрэгт Гомбын Гансүрэн гэгч сэжиглэгдэн одоогоор хэрэг мөрдөн байцаалтын шатанд шалгагдаж байна. Г.Гансүрэн нь мөрдөн байцаалтын шатанд өгсөн мэдүүлэгтээ эдгээр охидыг тус бүрийг нь 1500 юаниар хятадуудад зарах зорилготой явсан тухайгаа мэдүүлжээ.

2006 онд Сайншанд сумын иргэн У гэгч БНХАУ-ын иргэнтэй гэр бүл болж хүүхэд төрүүлсэн бөгөөд төрсөн хүүхдээ 15000 юаниар зарсан гэх хэрэгт сэжиглэгдэн шалгагдаж байгаа бөгөөд өөрөө мөрдөн байцаалтын шатнаас оргон зугатаж алга болсон байна.

БНХАУ-ын Хэ нань мужийн Джэнь хотноо Улаанбаатараас 45 хоногийн хугацаатай гоо сайхны курст суралцуулна гэсэн зарын дагуу нийт 5 хүн явсны дотор насанд хүрээгүй 17 настай Э явсан байна. Э-тэй утсаар холбоо барихад одоогийн байдлаар бидний биеийг үнэлүүлсэн асуудал байхгүй, харин албадлагын хөдөлмөр хийлгэж байнга зодож дарамталж байна. Анх ирэхэд паспорт, утас, батарей, мөнгө зэргийг хурааж авсан. Буцах гэхээр мөнгө байхгүй Хятадад байх хугацаа дууссан визний асуудал шийдэгдэхгүй, Жао Эрдэнэ гэдэг өвөрмонгол орчуулагчтай сайн ойлголцохгүй байгаагаас гадна Бээжин дэхь элчин сайдын яамныхантай холбоо барьж паспортоо олж авсан гэж байв.

“Эрүүгийн цагдаагийн газрын ажилтнууд БНХАУ-ын иргэн Ли Хуйг хамсаатных нь хамт баривчилж, УМБГ-т шилжүүлж өгөв. Тэрээр хэлмэрч болох Улаантуяа /өвөрмонгол/, манай улсын иргэн Ариунаа нарын хамт Малайзруу охид, эмэгтэйчүүдийг “Өндөр цалинтай ажилд оруулна” хэмээн авч яваад нилээд охидуудыг янхны газарт худалдсан нь тогтоогдсон байна” хэмээн Өнөөдөр сонины 2008 оны 3-р сарын 5-ны 52-р дугаарт нийтэлжээ.

Судалгааны явцад БНХАУ-ын Эрээн хотын консулын ажилтнуудтай уулзаж мэдээлэл солилцоход Монголын иргэдийг хурч мэхлэн Хятадруу гаргаж албадан хөдөлмөрлүүлсэн, биеийг үнэлүүлсэн, худалдаалахыг оролдсон, баримт бичгийг нь хураан авч барьцаалсан тухай мэдээлэл тус Консулын газарт багагүй ирдэг байна. Консулын ажилтнууд дараах мэдээллийг өгсөн болно.

- 2006 онд Улаанцав аймгийн хятад иргэнтэй гэр бүл болсон нэг монгол эмэгтэйн 17 настай охиныг хүнтэй суулгах нэрийдлээр хүнд зарсан. Тэр охин Өвөрмонголын Бугатаас өөрөө оргож ирсэн. 6-р ангийн боловсролтой хүүхэд байсан.
- Дорноговь аймгийн Сайншанд сумын харьяат нэг эмэгтэй Хятад иргэнтэй гэр бүл болж БНХАУ-ын Өвөрмонголын Бугатад амьдарч байснаа нөхрөөсөө салж нутагтаа ирсний дараа эцэг нь хүүхдээ хармаар байна гэсэн хүсэлтийн дагуу хадам ээж нь болох эмэгтэй нь хүүхдийг нь авч очтол өөрийн охиноо олж авчир хэмээн тэр эмэгтэйг барьцаанд авсан бөгөөд тэрээр өөрийн ачаа тэнд орхиод өөрөө зугтаж БНХАУ-ын Эрээн хот дахь Монгол улсын консул дээр очиж цагаан хуудас авч Монголын хил нэвтэрч орж ирсэн байна. Эдгээр тоо баримтаас харахад манай улсад хүн худалдаалах гэмт хэрэг анхаарал татах хэмжээнд хүрсэн нь харагдаж байна.

Сүүлийн жилүүдэд сураггүй алга болсон эрэн сурвалжлагдаж байгаа хүмүүсийн тухай хуулийн байгууллагын албаны эх сурвалжууд мэдээлж байна. Тэдний дунд насанд хүрээгүй хүмүүс ч байна. Эрүүгийн цагдаагийн газар, Нийслэлийн цагдаагийн газрын дарга нар 2008 оны телевизийн ярилцлагад оролцохдоо 2007-2008 онд 149 хүн сураггүй алга болсон тухай мэдээлэл ирснээс 141 хүнийг олсон, одоогоор 8 хүнийг олоогүй байна. Эдгээр хүмүүс нь 14-25 насныхан гэжээ. Шүүхийн болон цагдаагийн байгууллагын мэдээгээр хүүхэд худалдаалсан гэмт одоогоор бүртгэгдээгүй байгаа боловч алга боллоо, худалдаалагдлаа гэхэд араас эрж хайх хөөцөлдөх хүнгүй олон тооны хүүхэд байгаа, хүүхэд байтугай том худалдаалагдсан өнөөгийн нөхцөлд дээрх мэдээллийг 100 хувь үнэн гэх баталгаа алга.

Иймээс хүүхэд худалдаалагдах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар олон чиглэлээр ажиллах шаардлага урган гарч байна. Үүний нэг нь Монгол улсаас гадаадын иргэд хүүхэд үрчлэн авах тухай асуудал мөн. Сүүлийн жилүүдэд гадаадын иргэд манай улсаас хүүхэд үрчлэн авах асуудал ихэссэн нь анхаарал татаж байна.

1999-2007 он хүртэл 13 улсад 171 хүүхэд, ГИХАЭА байгуулагдсан буюу 2001 оны 5-р сарын 1-нээс 2007 оны 11 сар хүртэл 149 гэр бүлд 151 хүүхэд үрчлүүлсэн байна. Харин үрчлэгдсэн хүүхдийн хүйсийн харьцаа ерөнхийдөө адил байгаа боловч дээрх тооноос харахад гэр бүл нэгээс олон хүүхэд үрчлэн авсан ч тохиолдол байна. Үрчлэгдэж байгаа хүүхдийн 80 хувь нь олдмол буюу хаягдсан эцэг, эхгүй хүүхдүүд байдаг ба тэднийг хүүхдийн асрамж халамжийн төвөөс өргөж авдаг байна. Мөн үрчлэгдэж байгаа хүүхдийн хувьд 0-4 насны хүүхдийн үрчлэлт хамгийн их хийгддэг байна. Харин 7 наснаас дээш настай хүүхдийг үрчлэн авахдаа өөрийнх нь саналыг үндэслэн шийдвэрлэдэг ажээ.

Гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхэд үрчлүүлэх асуудлыг “Хүүхдийг хамгаалах ба улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай олон улсын конвенц” /Монгол Улс 1998 онд нэгдэн орсон/, Гэр бүлийн тухай хууль, Засгийн газрын 2001 оны 71 дүгээр тогтоолоор баталсан “Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаны дүрэм”, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2001 оны 100/32 тоот хамтарсан тушаалаар баталсан “Гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхэд үрчлүүлэх журам” зэрэг хууль тогтоомжийг үндэслэн шийдвэрлэдэг байна.

Үрчлэгч гадаадын иргэн нь үрчлэгч эцэг, эхийн талаарх нийгмийн ажилтны хийсэн гэр бүлийн судалгаа, гэмт хэрэг, хэв журмын зөрчилд орж байсан эсэх талаарх цагдаагийн байгууллагын тодорхойлолт, сэтгэц, удамшил болон гоц халдварт өвчингүй гэсэн эмнэлгийн бичиг, санхүүгийн бололцоотойг харуулсан эрх бүхий байгууллага болон ажлын газраас олгосон цалингийн тодорхойлолт, үрчлэгдсэн хүүхдийн өөрийн улсад орох болон оршин суух зөвшөөрөл олгох тухай эрх бүхий байгууллагын урьдчилсан тодорхойлолт, оршин суугаа хаягийн тодорхойлолт зэрэг баримт бичгийг бүрдүүлж, харьяалах улсынхаа төрийн захиргааны байгууллага болон төрийн захиргааны байгууллагаас улс хооронд хүүхэд үрчлэх зөвшөөрөл олгосон бүртгэлтэй төрийн бус байгууллагаар дамжуулж Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яаманд ирүүлдэг байна. Яам материалын бүрдлийг шалгаж гадаадын иргэнд үрчлэгдэх боломжтой хүүхдийн судалгаанд хамрагдсан хүүхдийг санал болгож үрчлэгч эцэг, эхэд зуучлагч байгууллагаар дамжуулан үрчлэгдэх боломжтой хүүхдийн судалгааг хүргүүлж зөвшөөрсөн тохиолдолд, хүүхдийн материалын бүрдлийг хангаж яамныхаа зөвлөлийн хурлаар оруулж санал, дүгнэлт гаргаж, нотариатаар батлуулсан материалын хуулбарын хамт гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албанд хүргүүлдэг байна. /Үрчлэгч эцэг, эх нь конвенцийн заалт ёсоор үрчлэн авах хүүхдээ түрүүлж сонгох ёсгүй болно/ Тус алба материалын бүрдлийг шалгаж шаардлага хангасан гэж үзвэл албаны зөвлөлийн хурлаар хэлэлцэн, үрчлүүлэх боломжтой гэж үзвэл даргын тушаал гаргаж эцэслэн шийдвэрлэдэг байна.

Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авсан гадаадын иргэн хүүхдийн хэвийн өсч бойжих, сурч боловсрох, эрхээ хамгаалуулах нөхцөлөөр хангах, хүүхдийн эх орон, шаардлагатай бол эцэг, эхийг мэдүүлэх, үрчлэн авсан хүүхдийн талаар 0-3 нас хүртэл хагас жил тутам, 4-8 нас хүртэл жил тутам, 9-16 нас хүртэл хасаг жил тутам ГИХАЭА-нд мэдээлэл ирүүлэх үүрэг хүлээдэг байна. Хүүхэд үрчлүүлэх журманд заасны дагуу үрчлэгдсэн хүүхэд болон үрчлэгч эцэг, эхийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг үрчлэгчийн харьяалах улсад суугаа Монголын ЭСЯ болон дипломат төлөөлөгчийн газарт албан ёсоор хүргүүлдэг байна. ЭСЯ-ны эрх бүхий албан тушаалтан, НХХЯ болон ГИХАЭА-ны ажилтнууд газар дээр нь очиж хүүхдийн нөхцөл байдалтай танилцах эрх үүрэгтэй байдаг.

Харамсалтай нь хөдөлмөр нийгэм хамгааллын яам, Гадаадын иргэд харьяатын асуудал эрхлэх алба нь “нууц” гэдэг нэрийн дор хүүхэд үрчлэлтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг өгөхөөс татгалзаж байгаа нь анхаарал татаж байна. Монгол улсын гэр бүлийн тухай хуулийн 60-р зүйлд үрчлэлтийн нууцыг мэдэж байгаа албан тушаалтан, бусад этгээд түүнийг хадгалах үүрэгтэй гэж заасан ба энэ нууцад чухам ямар мэдээлэл хамаарах нь ч тодорхой биш байна. Нөхцөл байдал ийм байгаагаас хүүхэд үрчлэн авсан гадаадын иргэд манай улсын хуулийн дагуу хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаа болон Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, ГИХАЭА, гадаад оронд суугаа ЭСЯ, дипломат төлөөлөгчийн газрууд гадаадад үрчлэгдсэн хүүхдийн талаар хэрхэн хяналт тавьж байгаа болон хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгааг дүгнэх боломж муу байна. Яам болон ГИХАЭА хүүхэд үрчлүүлэх асуудлыг тус бүр гучхан хоногийн дотор шийдвэрлэж байхаар журамласныг ч эргэж харах шаардлагатай байна. Хүүхэд үрчлэн авахыг хүссэн иргэдийн талаарх мэдээллийн үнэн зөвийг ЭСЯ болон дипломат төлөөлөгчийн газар зохих журмын дагуу лавладаг, үрчлэгдсэн хүүхдийн нөхцөл байдлыг тогтмол хяналтандаа байлгах зэрэг арга хэмжээг авч байх шаардлагатай байна.

Жил дутам олон арван мянган хүүхэд янз бүрийн шалтгаанаар гадаад орнуудад урт богино хугацаагаар зорчиж байна. Гэсэн хэдий ч хэдэн хүүхэд гадагшаа гарч хэд нь буцаж орж ирэв, хэд нь буцаж ирээгүй байна, энэ нь ямар учир шалтгаантай болохыг хянадаг шалгадаг, анхаарал тавьдаг тогтолцоо байхгүй байна.

Монгол улсын Хил хамгаалах Ерөнхий газраас гаргасан мэдээгээр 2005 онд Монгол улсын хилийн шалган нэвтрүүлэх боомтоор 2005 онд гадагшаа 23053 хүүхэд гарснаас 21668 хүүхэд буцаж орж ирж 1385 хүүхэд буцаж ирээгүй, 2006 онд 26118 хүүхэд хилээр гарснаас 22523 хүүхэд буцаж ирж, 3595 буцаж ирээгүй, 2007 онд 38054 хүүхэд хилээр гарснаас 36545 хүүхэд буцаж ирж, 1509 хүүхэд тус тус буцаж ирээгүй байна. Энэ тооноос харахад гадагшаа гарч байгаа хүүхдийн тоо жилээс жилд өссөн байна. Хэдийгээр хүүхдүүд гадаад оронд зорчих, суралцах нь хүүхдийн эрхийн асуудал хэдий ч үүний далбаан дор хүүхэд худалдаалагдах гэмт хэрэг явагдаж байхыг үгүйсгэх аргагүй. Эдгээр хүүхдүүд яагаад буцаж ирээгүй болхыг магадалдаг, авч гарсан насанд хүрэгсэдтэй нь зохих хариуцлагыг тооцдог, хянан шалгадаг тогтолцоог бий болгох шаардлагатай байна.

Харин манай улсын тухайд хүүхдийг хүчээр болон албадан хөдөлмөрлүүлсэн, боолчилсон, мансууруулах бодис бэлтгэх, худалдах борлуулах, садар самууны үйлдвэрлэл, сурталчилгаанд хүүхдийг татан оролцуулсан тухай мэдээлэл, шийдвэрлэсэн хэрэг материал одоогоор байхгүй байна. Гэхдээ ажилгүйдэл, ядуурал, хараа хяналтгүй хүүхэд ихтэй өнөөгийн нөхцөлд ийм гэмт хэрэг гарахгүй баталгаа байхгүй байна. Хуулийн байгууллагын ажилтнуудын эдгээр гэмт хэргийн талаарх мэдлэг, ойлголт хангалттай биш байна. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрт тооцогддог, эрүүгийн гэмт хэрэг гэж тооцохоор олон улсын гэрээ, зөвлөмжид тусгасан, эрүүгийн хуулинд заагдсан гэмт үйлдлүүдийг тайлбарлах, энэ талаарх хуулийн ажилтнуудын мэдлэг чадварыг дээшлүүлэх талаар анхаарал тавих нь чухал байна.

Дөрөв: Уул уурхайн салбар дахь хүүхдийн хөдөлмөр

4.1. Уул уурхай дахь хүүхдийн хөдөлмөрийн шалтгаан

Уул уурхайн салбар дахь хүүхдийн хөдөлмөрийн судалгаанд Өвөрхангай, Баянхонгор, Өмнөговь, Дундговь, Дархан-Уул, Дорноговь, Сэлэнгэ, Төв аймгуудын нутаг дэвсгэрт албан бус уурхайн хөдөлмөр эрхэлж буй 232 хүүхэд, 150 эцэг эх оролцов. Санал асуулгад оролцсон хүүхдүүдийн 36.3% нь 8-14 хүртлэх, 56.8% орчим нь 15-18 хүртлэх настай, мөн 7 настай 1 хүүхэд байв. Тэдгээр хүүхдүүдийн 85% нь эрэгтэй, үлдсэн 15% нь эмэгтэй хүүхэд байв.

Судалгааны үндсэн арга нь хүүхдийн хөдөлмөрийн нөхцөл байдал, хөдөлмөр эрхлэх шалтгаан, хөдөлмөр эрхлэлтийн эерэг ба сөрөг тал зэргийг тусгасан 28 асуулт бүхий анкетаар хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийн эцэг эхээс авсан судалгаа, ярилцлага байв. Тус судалгаанд оролцсон эцэг эхийн 64% нь эрэгтэй, бусад нь эмэгтэй бөгөөд 33.3% нь 35 хүртэлх насны, 60% нь 36-55 хүртэлх насны эцэг эхчүүд байв. Мөн тэдгээрийн 75 гаруй % нь хүүхдүүдтэйгээ хамт ажиллаж буй эцэг эхчүүд, 20% нь эмээ, өвөө нь байсан.

Албан бусаар алт болон жонш олборлож байгаа хүн амын насны бүтцийг харахад насанд хүрэгчид хүүхдүүдээс илүүтэй оролцож байна. Тухайн хүүхдүүдийн 75% нь 3-7 хүртэлх ам бүлтэй өрхөд амьдардаг бөгөөд 86% нь эцэг эхтэйгээ буюу тэдний хэн нэгэнтэй хамт амьдардаг байна. Тэдгээрээс цөөн хүүхдийн хувьд ах эгч эсвэл хамаатан садныдаа амьдарч, уг ажлыг хийдэг байна. Нэг л хүүхэд гэр бүлийн хамт майханд амьдардаг бөгөөд бусад нь бүгд монгол гэрт амьдардаг байна.

Албан бус хэлбэрээр алт, жонш, нүүрс зэрэг ашигт малтмалыг гар аргаар олборлогчид, түүний дотор насанд хүрээгүй хүмүүсийн тоо эрс өсөж байна. Үүний улмаас нилээд тооны хүүхэд тэвчишгүй хүнд хөдөлмөрт татагдан орж, эрхээ эдэлж чадахгүй байх нөхцөл байдал үүсээд байна. Ийнхүү хүүхдүүд албан бус, гар аргаар ашигт малтмал олборлож байгаад нилээд олон хүчин зүйлс нөлөөлж байна. Үүнд ядуурал, ажилгүйдэл, тэдгээрээс үүдсэн дотоод шилжилт хөдөлгөөн, хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүйгээс болон нийгмийн халамж, хүүхэд хамгааллын тогтолцоо сул байгаа зэргээс үүдэн гарч байна. Зарим тохиолдолд эцэг эхчүүд боловсролын үнэ цэнийг ойлгодоггүй, хүүхдийнхээ өмнө хариуцлага хүлээх чадваргүй байдал нөлөөлж байна. Эдгээрээс голлох зарим хүчин зүйлсийг товч авч үзье.

Ядуурал:

Монгол Улсын нийт хүн амд амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой хүн амын эзлэх хувь 1990 онд 36.3, 2000 онд 35.6, 2005 онд 36.1 байсан бол 2006 онд 32.2 хувь болж буурчээ⁵. Ядуурлын гүнзгийрэлт 2002-2003 онд 11.0, 2006 онд 10.1 хувь болсон нь ядуучуудын хэрэглээний дундаж түвшин ядуурлын шугамны дунджаас 10 хувиар доогуур байгааг харуулж байна. Ядуурлын түвшин хот, суурин газартай харьцуулахад хөдөөд илүү байна. Хотын ядуурлын хэмжээ 2003-2006 онд 30.3 хувиас 27.0 хувь, хөдөөгийн ядуурал 43.4 хувиас 37 хувь хүртэл буурчээ.

⁵ Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилт Үндэсний хоёрдахь илтгэл, Хураангуй 2007 4 хуудас

Монгол Улсын Хүний хөгжлийн индекс (ХХИ) 2006 оны байдлаар 0.6911 байгаа нь хүний хөгжлөөрөө дунд зэргийн гэсэн ангилалд хамрагдаж байна. Нэг хүнд ногдох ДНБ оны үнээр 1,440.7 мянган төгрөг (1221.4 ам.доллар)-г хүрчээ⁶.

Хүүхэд ядууралд өртөх нь эцэг эх, гэр бүлийн ядууралтай холбоотой байна. Ядуурал орлогын болон боломжийн гэсэн агуулгатай байна. Өрхийн орлогын ядуурал нь олон хүүхдийн хөгжлийн үр шимийг хүртэх боломжийг хязгаарлан тэднийг гудамжинд амьдрах, хүнд хүчир хөдөлмөр эрхлэх, биеэ үнэлэх, гэмт хэрэгт өртөх шалтгаан болсоор байна⁷.

Мөн хүүхэд хөдөлмөр эрхлэх явдалд дараах хүчин зүйлс түлхэц үзүүлдэг байна. Энэ нь сургуульд амжилттай суралцаж чадахгүй байгаа хүүхдүүд ажиллах замаар өөрийн гэр бүлийн амьжиргаанд хувь нэмэр оруулах шаардлагатай болдог. Ийнхүү зарим хүүхдүүд нь бусад ах, эгч дүүсийнхээ сурах нөхцлийг хангах үүднээс мөнгө олохын тулд сургуулиас гарах ёстой болдог байна⁸.

Шилжилт хөдөлгөөн:

Албан бусаар алт олборлогчдын 49.0 хувь, жонш олборлогчдын 75.8 хувь нь уурхайн орчимд буюу алт, жонш олборлож буй газарт буюу уурхайн орчимд амьдарч байна. Тиймээс эдгээр хүмүүсийн дунд шилжилт хөдөлгөөн нилээд түгээмэл байна. Албан бусаар алт, жонш олборлогчид голдуу өөрсдийн гэр бүлээрээ тодруулбал, эхнэр/нөхөр, хүүхдүүдтэйгээ хамт шилжих хөдөлгөөнд оролцсон байна.

Нийт хүүхдүүдийн 56.8% нь эцэг эхийн хамт өөр аймаг, орон нутгаас шилжин ирсэн байна. Судалгаанд хамрагдсан өрхүүдийн 76.6% нь тухайн орон нутгаас өөр бусад аймаг, суурин газруудаас ирсэн нь уг уурхайн орчимд хүн амын томоохон төвлөрөл бий болсныг харуулж байна. Улаанбаатар, Төв, Баянхонгор, Архангай, Өвөрхангай, Баянхонгор, Өмнөговь, Дундговь, Сэлэнгэ, Ховд, Увс зэрэг бүхий л аймаг, орон нутгаас хүүхдүүд эцэг эхээ даган ирж, ажиллаж байгаа нь дотоодын албан бус шилжих хөдөлгөөний томоохон илрэл болж байна. Мөн 2006 онд Төв аймгийн Заамар сумын нутаг дахь албан бус алтны уурхайнуудын үйл ажиллагааг цагдаагийн хүчээр хааснаас шалтгаалан, ялангуяа Өвөрхангай, Баянхонгор зэрэг бусад аймгуудад шилжилт хөдөлгөөний урсгал эрс нэмэгдсэн нь ажиглагдсан болно.

Уурхайн орчимд амьдардаг алт олборлож буй хүүхдүүд дунджаар 4-5 хүнтэй өрхөд (тухайн хүүхдийг оролцуулан) амьдардаг бөгөөд ам бүлийн гишүүдийн хоёр нь 18-аас доош насны хүүхдүүд байна. Харин жонш олборлож буй хүүхдүүд дунджаар 5-6 хүнтэй өрхөд амьдардаг бөгөөд эдгээр ам бүлийн гишүүдийн 2-3 нь 18-аас доош насны хүүхдүүд байна.

Шилжигчид ажил хийх, алт жонш олборлох шалтгаанаар шилжих хөдөлгөөнд илүүтэй оролцсон байна. Ажлын байрны хомсдолын улмаас алт, жонш олборлож амьжиргаагаа залгуулах нь шилжих хөдөлгөөний үндсэн шалтгаан болж байна. Албан бусаар алт олборлогчдын 29.7 хувь, жонш олборлогчдын 23.4 хувь нь өмнө нь алт, жонш олборлох ажил хийж байжээ.

⁶ Мөн тэнд,

⁷ Хүүхдийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын 3 ба 4 дигээр тайлан илтгэл, 2007 он 7 хуудас

⁸ МБХАН, Монгол дахь сургууль завсардалтын судалгаа, Тайлан 2006 он, 60 хуудас

Харамсалтай нь шилжин ирэгчдийн тэдний ердөө тал хувь нь л ажиллаж, амьдарч буй сум, орон нутагтаа бүртгүүлжээ. Алт, жонш олборлогчдын дунд цаашид ч шилжилт хөдөлгөөн хийгдэх магадлал нэн өндөр бөгөөд энэ нь тодорхой төлөвлөгөөт, болзмол зүйл биш байна. Байнга оршин суух төлөвлөгөөгүй хүмүүс бүртгэлийн асуудалд анхаарал тавьдаггүй гэдэг нь харагдаж байгаа бөгөөд бүртгэлгүй байдал нь тэдний боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ хүртэх боломжийг хязгаарлаж байгааг үгүйсгэх аргагүй юм.

“Манай суманд хиймийн төвлөрөл маш хичтэй явагдаж байна. Ганц жишээ хэлэхэд л зөвхөн Уянга суманд бэсний худалдааны 4 том сїлжээний салбар байна. Салбар бїр л долоо хоног тутамд том контейнераар бараа татаж ирээд, дуусчихдаг. Дээр нь маш олон жижиглэнгийн худалдаачид өөрсдөө бараа нийлїлж байгаа гэж бодохоор хїн ам ч их байна, хэрэглээ ч их байна гэсэн їг.

**Экспертийн ярилцлагын тэмдэглэлээс:
Сумын удирдах албан тушаалтан, Свєрхангай аймгийн Уянга сум.**

Албан бусаар алт олборлож буй уурхайн орчимд гэр дэлгүүр, жижиг зах, тээврийн үйлчилгээ, хоолны газар, тоглоомын газар, тэр ч байтугай зарим цэцэрлэг, эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх хувийн жижиг үйлчилгээ өргөнөөр дэлгэрч байгаа тул алт олборлогчдын жижиг суурингийн хэлбэр бий болох хандлагатай байна.

Эцэг эхчүүдийн хандлага:

Судалгаанд хамрагдсан эцэг эхчүүд хүүхдээ яагаад ийм төрлийн ажил хийлгэж байгаагаа доорх байдлаар тайлбарласан байна. Үүнд:

- гарцаагүй амьдралын шаардлагаар ажиллуулж байгаа гэж 56% нь
- өрхийн хэрэгцээнд нэмэр болдог тул гэж 26%
- Хүүхэд өөрт хэрэгцээтэй мөнгөө олж чаддаг байх 18% нь хариулжээ.

Тэдний олонх нь (58%) хүүхдүүд нь уг ажлыг хийх дургүй бөгөөд эцэг эхийн хувьд 76.6% нь хүүхэд уул уурхайн хөдөлмөр эрхлэх нь буруу гэж үздэг байна. Мөн эцэг эхийн 83% нь хүүхдээрээ энэ ажлыг цаашид үргэлжлүүлэн хийлгэх хүсэлгүй байгаагаа илэрхийлжээ. Уг ажлын байр нь хөдөлмөрийн аюулгүй байдал бүрэн хангагдсан гэж дөнгөж 4 хүн үзсэн бөгөөд бусад эцэг эхчүүд хөдөлмөрийн аюулгүй байдал хангагдаагүй гэж үзсэн байна. Тиймээс уг ажлаас болж хүүхдүүд байнга ядардаг (90%), биеийн эрүүл мэнд, өсөлт бойжилтонд сөрөг үр дагавар гарч байгаа (56.6%) үздэг байна. Тухайлбал, нүхрүү унасан, шороо чулуунд цохигдсон 11, томоохон осолд өртсөн 3, түлэгдсэн, хөлдсөн, химийн бодист хордсон тохиолдол гарсан гэж тус бүр нэг хүн хариулжээ.

Ажил олгогчдын байдал:

Албан бусаар алт олборлох үйл ажиллагаанд хүүхдүүд олноор татагдан орсон боловч тухайн хөдөлмөрийн төрөлд албан ёсны ажил олгогч, хөдөлмөрийн гэрээ хэлэлцээр, ажлын тогтвортой байр зэрэг зүйлс байхгүй байна. Олонх тохиолдолд гэр бүлээрээ нэг баг болон ажиллаж байгаа бөгөөд энэ тохиолдолд эцэг эх, хамаатан садан нь хүүхэд ажиллуулсныхаа төлөө шууд мөнгөн төлбөр төлдөггүй байна. Хүүхдүүдэд энэхүү алт, жонш олборлох ажлыг санал болгосон хүмүүсийг авч үзэхэд 16-17 нас хүүхдүүд ихэвчлэн өөрсдөө (алт олборлогч хүүхдүүдийн 45.8 хувь, жонш олборлогч хүүхдүүдийн 58.8 хувь) энэ ажлыг хийхээр шийдсэн, 12 хүртлэх насны хүүхдүүдэд

ихэвчлэн эцэг, эх, ах, эгч нь (алт олборлогч хүүхдүүдийн 51.6 хувь, жонш олборлогч хүүхдүүдийн 84.3 хувь) санал болгосон байна. Энэ нь уурхай дахь хүүхдийн хөдөлмөр эрхлэлтэд эцэг, эхчүүд ихээхэн нөлөөлдөг болохыг харуулж байна. Тиймээс ажил олгогч ба хүүхдүүдийн хооронд хөдөлмөрийн гэрээ, хэлцэл байгуулж, аюулгүйн ажиллагааны заавар журам зэргийг танилцуулсан тухай мэдээлэл байхгүй байна. Харин жонш олборлогчдын хувьд олонх тохиолдолд нилээд томоохон хэмжээний ажиллах хүчин бүрдүүлж, олборлох, худалдах, тэвэрлэх, бутлах ба ангилах зэргээр төрөлжсөн байв. Гэхдээ энэ хүнд хөдөлмөр учраас албан ёсоор хүүхэд ажиллуулж хөдөлмөрийн гэрээ хэлцэл хийсэн тухай мэдээлэл байхгүй байна.

4.2. Уул уурхай дахь хүүхдийн хөдөлмөрийн орчин, нөхцөл:

Хөдөлмөрийн нөхцөл

Албан бусаар алт, жонш олборлож буй хүмүүсийг олборлож буй ашигт малтмалын төрөл, хөдөлмөрийн нөхцлөөр нь дараах 4 бүлэгт хувааж болно.

1. Ил, шороон орд - Ил, шороон орд газарт алт угаах нь хамгийн нийтлэг, өргөн дэлгэрсэн, олон насанд хүрэгчид, хүүхдийг хамарсан хөдөлмөрийн төрөл юм.
2. Чулуун орд - Нэн, аюултай, эрсдэл өндөр хөдөлмөрийн төрөл бөгөөд энэхүү ихэнхи тохиолдолд албан ёсны зөвшөөрөлтэй томоохон уурхайнууд ажилладаг бөгөөд судалгааны явцад чулуун орд газарт хүүхэд ажиллаж байгаа тохиолдол гараагүй болно.
3. Жоншны орд – Говийн бүсийн аймгуудад нийтлэг тархсан жоншийг олборлох, бутлах, тэвэрлэх зэрэг хэлбэрүүдийг агуулсан хөдөлмөрийн төрөл.
4. Уурхайн орчин дахь бусад хөдөлмөр – уул уурхайн албан бус салбарыг даган бий болсон үйлчилгээний шинжтэй, харьцангуй хөнгөн хөдөлмөрийн төрлүүд болно.

Эдгээр хөдөлмөрийн төрлүүдээс ил, шороон ордод ажиллаж байгаа хүмүүс хамгийн нийтлэг бөгөөд хөдөлмөр эрхлэгч хүүхдүүд эцэг эх, бусад багийнхны хамт шороон ордууд дээр гар аргаар алт олборлох ажлыг тогтмол эрхэлж байна. Ил, шороон орд газар нь элсэрхэг, зөөлөн хөрстэй бөгөөд усны гарц ховор нөхцөлд байдаг. Иймээс алтны илэрц бүхий шороог усаар цохиулах, салхин үлээгүүрээр үлээлгэх зэрэг технологи хэрэглэн ялгадаг байна. Алт угаах үйл ажиллагаа нь төвлөрсөн байдлаар бус, харин гэр бүл, багаараа нийлэн таруу, саланги байдлаар ухдаг байна. Тиймээс хүүхдүүдийн хувьд ихэвчлэн шороо чулуу үүрэх, зөөх, алт шигшин ялгах үйл ажиллагаанд өргөн оролцдог байна.

Ил, шороон орд дахь албан бус алтны уурхайн хамгийн төвлөрөлтэй газар бол Өвөрхангай аймгийн Уянга сум байна. Уянга сум 10273 хүн амтай бөгөөд тус сумын нутагт дахь Өлтийн болон ойр орчмын алтны уурхайд зөвхөн нутгийн иргэд төдийгүй бусад сумдууд, Эрдэнэт, Улаанбаатар, Баянхонгор, Архангай, Дархан зэрэг олон аймгаас иргэд албан бусаар шилжин ирж ажилладаг байна. Ялангуяа урин дулаан, гарц сайтай үед тус суманд харьяалалгүй 30000 орчим хүн Өлтийн алтны уурхайд гар аргаар алт олборлон амьдардаг хэмээн орон нутгийн удирдлагууд тооцоолжээ. Мөн дээр дурдсан аймаг, орон нутгаас хүүхдүүд эцэг эхээ даган ирж, ажилладаг байна. Мөн 2006 онд Заамарын алтын уурхай хаагдсанаас шилжих ирэх урсгал ихээр нэмэгджээ.

Чулуун ордтой газар алтны тээрэм, мөнгөн ус, цианит натри, шороон ордтой газар алт мэдрэгч хайгуулын багаж, мотороор ажилладаг шигшигч машин зарим үед мөнгөн ус хэрэглэх тохиолдол байдаг.

Жоншны ордны хувьд Дорноговь аймгийн Айраг, Иххэт, Даланжаргалан зэрэг сумдын нутаг дэвсгэрт нийтлэг тархсан бөгөөд хөдөлмөрийн цар хүрээ, түүнд татагдан орсон хүүхдийн тоо харьцангуй бага байна. Жонш олборлож буй хүүхдүүдийн хамгийн их хийдэг ажлуудад шороо зөөх, нүх малтах, жонш болон хүдэр зөөх, хүдэр, чулуу, жонш бутлах, ангилах зэрэг жонш олборлох үйл ажиллагаатай холбоотой бүхий л ажлуудыг хийж байна. Албан бусаар алт, жонш олборлож буй хүмүүсийг олборлож буй ашигт малтмалын төрлөөр авч үзэхэд, 10 хүн тутмын 9 нь алт, үлдсэн 1 нь жонш олборлож буй хүмүүс байна.⁹

Судалгаанд хамрагдсан нийт хүүхдүүдийн 70% нь шороо ухах, шрүп гаргах¹⁰ ажилд, 50% нүхнээс гарсан шороог үүрч зөөх, 21% нь машин, тээврийн хэрэгсэлд ачих, мөн давхардсан тоогоор 34% нь алт угаах, ялгах, шигших, 9 % нь тухайн газар дахь цайны газар, худалдааны цэгт хөдөлмөр эрхэлж байна.

Мөн хүүхдүүдийн хувьд алт үлээх төхөөрөмжид алттай шороог хийх, ангилсан шороог зайлуулах, усанд явах, алт илрүүлэгч багажийг үүрч, эрэл хийх зэрэг үйл ажиллагаанд өргөн оролцдог байна.

Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг тодорхойлох бас нэг үзүүлэлт бол ажлын цагийн үргэлжлэх хугацаа юм. Хүүхдүүдийн ихэнх нь жилийн дөрвөн улиралд, өдөр бүр, тодорхой амралтгүйгээр ажиллаж байна. Эдгээр хөдөлмөр нь албан бус учир хөдөлмөрийн хатуу хуваарь байхгүй бөгөөд цаг агаарын байдал, хэт халуун буюу хүйтэн, алтны гарц зэргээс шалтгаалан зарим өдрүүдэд амардаг байна.

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 72.7% нь өдөр бүр ажилладаг. Мөн өдөр тутамд дор хаяж 6 цаг, түүнээс дээш буюу өглөөнөөс харанхуй болтол буюу тодорхой цаг хугацаагүйгээр ажиллах нь хэвийн үзэгдэл болсон гэж 63.2% хариулжээ. Уянга сумын нутагт дахь Өлтийн уурхайд хийсэн ажиглалтын тэмдэглэлээс үзэхэд хөдөлмөр эрхлэгчид зуны цагт өглөө нар халахаас өмнө ажилд гарч, 5 цаг орчим ажиллаад, 1-2 цаг завсарладаг байна. Түүний дараа мөн уг ажлаа үргэлжлүүлж байсан бөгөөд оройн 7 цагийн орчимд олонх баг ажлаа дуусгаж, гэртээ харьцгааж байсан болно. Оройн хоол идсэний дараа гэр орчмын шрүп ухах, багаж зэвсгээ янзлах зэргээр бас ажиллаж байсан. Ялангуяа уг уурхайн оршин суух хэсэг газарт 250 орчим гэрийг хаяа хатган, хуарангийн адилаар барьсан бөгөөд гэрүүдийн хооронд, тэр бүү хэл гэр дотроо зай завсаргүй шрүп ухсан бөгөөд эдгээрийг ихэвчлэн оройн цагаар хийдэг байна.

⁹ ХАССТ “Албан бусаар алт, жонш олборлож байгаа хїхэд, насанд хїрэгчдийн суурь судалгаа”

Тайлангийн 16 дугаар хуудас. 2006

¹⁰ Алтны илэрц бїхий хэсэгт хїрэхийн тулд нэг хїн багтахуйц байдлаар цооноглон ухсан нїх

... Би 16 настай, энэ сумынх биш, еер сумаас ирсэн, сургуульд сураагүй, 1 дигээр ангиасаа гарсан, ам бил 7, хойд эцэгтээ байнга дарамтлуулж зодуулж байснаас сургуульд сураагүй, 1 жилийн өмнө айлд мал маллаж байсан боловч хөлсөө авч чадаагүйгээс алт олборлох болсон. Энд едэрт 5000 төгрөгний хөлстэй ажиллахаар тохирсон, цаашид дадлагашиж, ахыгаа цэргээс ирэхээр энд хамтарч ажиллах бодолтой байна.

Алт олборлоод 1 сар өнгөрч байна. Өглөө нар мандахад ажлаа эхэлж, өдөр нар жаргахад ажлаа дуусгадаг, өдөрт нэг удаа цай уудаг, орой хооллоод унтдаг.

Энд ажиллах нөхцөл хинд, тоос шороо ихтэй, одоо сэрүүн болсон учир өглөө оройд даардаг, хамгаалалтын малгай, маск, энэ тэр огт хэрэглэдэггүй, 10 хоног ажиллаад амарч, дахин гарч ирдэг. Энд хөсгөнө, алт хайгч багаж энэ тэрээ хураалгах гээд асуудлууд их гардаг, бас тамхи татаж сурсан.

Бичигтэй болох, гэрийнхнийгээ тэжээх юмсан гэж боддог, одоогоор би дараа болохгүй л гэж явна. Мал маллаж байхдаа хөлс мөнгөө аваагүйгээс надад солих хувцас энэ тэр байхгүй байна, гэхдээ миний хөлсийг өгнө байх гэж найддаг...

/Сэрвэй сумын Зөвлөлийн нуруунд хөлсөөр алт олборлож байгаа хөдөлмөр эрхлэгч хийхдийн ярилцлагаас/

Ийнхүү өдрийн ажлын үргэлжлэх дундаж хугацаа нь 8-9 цаг буюу хуулинд заасан хугацаанаас илүү байна. Иймд ОУХБ-ын зөвлөмжөөр долоо хоногт ажлын нөхцлөөс үл хамааран 43 цаг болон үүнээс дээш цагаар хөдөлмөр эрхэлсэн тохиолдолд хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрт хамааруулж үзэх ёстой.

Судалгаанд хамрагдсан хүүхдүүд бүгд зуны улиралд уг ажлыг хийдэг бол харин 30 орчим хувь нь жилийн 4 улирлын турш буюу байнга ажилладаг гэж хариулсан байна. Тэдгээр хүүхдүүдийн 31.8 хувь нь уг ажлыг 1 жилийн хугацаанд, 38.6% нь сүүлийн 2-3 жилд, 6 хүүхэд уг ажлыг 4 жилээс дээш хугацаанд хийж байгаа ажээ. 2-оос дээш ажиллаж байгаа хүүхдүүдийн олонх нь сургууль завсардсан хүүхдүүд байна.

Хүүхдийн хөдөлмөрийн нөхцлийн хувьд газар доорх нүхэнд (56%), бохир, шороо тоостой, дуу чимээ ихтэй (54%), хэт халуун буюу хэт хүйтэн нөхцөлд (38.6%), хүйтэн, бохир усан орчинд (16.4%), механикжсан техник хэрэгслүүдтэй ажиллах (32.5%) ажилладаг гэж хариулжээ.

Албан бус уурхайн хөдөлмөр дэх дараах нөхцлүүд нь энэ хэлбэрийн хүүхдийн хөдөлмөрийг тэвчишгүй хүнд хэлбэрийн гэж тооцох үндэслэл болно гэж үзэж байна.

Үүнд:

- Хэт давчуу, гүн нүх, бохир ус
- Хэт халуун буюу хэт хүйтэн орчин
- Амрах, хооллох, ажиллах цагийн дэглэмгүй байх
- Хөдөлмөр хамгааллын стандарт үйлчлэхгүй, мөрдөхгүй байх
- Техникийн аюулгүй байдал хангагдаагүй байх
- Насанд хүрэгчдийн зүй бус нөлөөнд автах эрсдэл
- Химийн хорт бодистой ажиллах, хордох эрсдэл

Дээр дурдсан хөдөлмөрийн нөхцөл байдлууд нь хүүхдийн эрүүл мэнд, бие бялдар, хөгжил болон үндсэн эрх, эрх чөлөөгөө эдлэхэд нь томоохон хаалт, хориг саад болж байна.

4.3. Уул уурхай дахь хүүхдийн хөдөлмөрийн үр дагавар:

Хөдөлмөр хамгаалал, эрүүл мэндийн байдал:

Гар аргаар алт олборлохдоо ямар нэг хөдөлмөр хамгааллын хэрэгсэл ашиглаж байгаа эсэхийг тодруулахад хөдөлмөр хамгааллын амны хаалт, бээлийг харьцангуй өргөн, малгай, чихний бөглөө, татлага бэхэлгээг хааяа хэрэглэдэг хандлага ажиглагдаж байна. Хүүхдүүдийн хувьд хөдөлмөрийн багаж, хэрэгслийн хувьд нэг удаагийн хэрэглээний ажлын бээлий, газар ухах хүрз зээтүү, лоом, алт угаах, ялгахад ашиглах хуванцар түмпэн, шороо хийх сав буюу шуудай зэргийг өргөн хэрэглэж байсан. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн хувьд дээр дурдсан бээлий, хүрз зээтүү зэрэг багажийг байнга хэрэглэдэг гэж 67%, хааяа хэрэглэдэг гэж 37% нь тус тус хариулсан байна.

Гэвч шрүп гэх гүн нүхрүү ороход зарим газарт татлага олсоо бэхэлж дүүжилснийг эс тооцвол хөдөлмөр хамгааллын багаж, хэрэглэл бараг байхгүй байна. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлыг хангах асуудал мөн л орхигдсон бөгөөд зарим цөөн төрлийн багаж хэрэгсэл ашигладаг байна. Тухайлбал, цөөн хүүхэд газрын гүнд ажиллах үед жижиг гэрэлтүүлэг, холбогч уяа, татлага ашигладаг байна. Тиймээс эдгээр хүүхдүүдийн хувьд шороонд дарагдах, нүхэнд унах, бие эрхтэндээ шарх сорви авах, хөлдөх, хайруулах зэрэг эрсдлүүд байнга тохиолддог. Үүний улмаас өвчин эмгэг тусах, осол гэмтэлд өртөх магадлал өндөр байна.

Насанд хүрсэн хүнтэй харьцуулахад хүүхдүүд ихээхэн эмзэг хүмүүс юм. Тэдний бие махбодь нь бүрэн гүйцэд хөгжөөгүй байх тул осолд орох, тодорхой хэмжээгээр бэртэх зэргээр эрсдэлд өртөх нь эрүүл мэндийн хувьд эдгэршгүй үр дагаварт хүргэж болзошгүй. Ажлын аюултай нөхцөл, хэт ачаалал нь хүүхдүүдэд насанд хүрэгчдийг бодвол илүү хурдан нөлөөлж гүнзгий хор урхаг үлдээдэг.

Дээрх хүүхдүүдийн 18.7% нь ажил хийж байх явцдаа нүхэнд унасан, 17.1 % нь чулуу багаж зэрэгт цохиулсан, 1.5 % нь шороонд дарагдсан, 3.1 % нь машин техникт дайруулсан, 12.5% нь усанд унах зэрэг тохиолдлууд гарч байжээ. Судалгаанд хамрагдсан нийт хүүхдүүдийн 53% нь дээрх тохиолдлуудад өртөж, 48.3% нь хөл, гар, нуруу, толгойдоо бэртэл, гэмтэл авч байсан байна.

Ажил хийсэнтэй холбоотой хүүхдүүд өөрсдийн эрүүл мэндэд өөрчлөлт орж, нуруу, толгой, хөл гар нь өвддөг болж, арьсан дээр нь тууралт гарсан гэж олонтоо тэмдэглэжээ. Үүний хамт 27.2% нуруу өвдөх, 20.4% нь толгой, 22.7% нь бөөр элэг зэрэг дотор эрхтэн өвдөж, ханиалгах зэргээр эрүүл мэндэд сөрөг өөрчлөлтүүд гарсан гэж үзжээ. Мөн тус бүр 2-3 хүүхэд нуруу, толгой, хөл бэртэж, хөлдөх буюу түлэгдсэн, 2 хүүхэд хараа муудах, 3 хүүхдийн хувьд арьсан дээр тууралт гарсан, 4 хүүхдийн хувьд харшилтай болох шинж тэмдгүүд ажиглагдсан гэж үзсэн байна. Энэ байдал нь даарах буюу халууцах, байнгын ядрах, хүйтэн усанд буюу газар доорх нөхцөлд ажиллах, эрүүл мэндийн тусламж, үзлэг, урьдчилан сэргийлэх ажлууд хийгдэхгүй байгаа зэрэгтэй холбоотой гэж үзэж байна.

Судалгаанд оролцсон хүүхдүүд болон тэдгээрийн эцэг эхийн 50-аас дээш хувь нь эрхэлж буй ажлаасаа болоод хүүхдүүдийн эрүүл мэндэд муугаар нөлөөлж, бие нь өвддөг болсон гэж үзжээ. Мөн бидэнд байгаа мэдээллээр хүүхэд хөдөлмөрийн нөхцлөөсөө шалтгаалан хөгжлийн бэрхшээлтэй болсон 6 тохиолдол гарсан байна.

Химийн хорт бодисын нэр төрөл, тоо хэмжээний худалдаа сүүлийн жилүүдэд эрс өсчээ. 2002 онд нийслэл, 21 аймагт явуулсан химийн хорт бодисын тооллогоор Монгол улсад 563 нэр төрлийн 1.7 мянган тонн химийн бодис байна гэсэн дүн гарчээ. Уул уурхайн салбарын хөгжилтэй уялдан олон төрлийн химийн хорт бодисыг иргэд хууль бусаар,

хөдөлмөр хамгааллын ямар ч арга хэмжээ авалгүйгээр хэрэглэж байна¹¹. Хууль бусаар, гар аргаар ашигт малтмал олборлож байгаа иргэд төдийгүй тэдний хүүхэд, гэр бүлийн гишүүд эдгээр химийн бодисонд хордох, ахуйн болон үйлдвэрлэлийн осолд орох, улмаар амь нас, эрүүл мэндээрээ хохирох эрсдэл бодитой байна.

4.4. Хөдөлмөрийн эдийн засгийн үр дагавар:

Хүүхдүүдээс авсан санал асуулгын дүнгээс үзэхэд тэдгээрийн гэр бүл сард

дунджаар 30001—100000 төгрөгийн орлоготой гэж олонхи нь хариулжээ. Хүүхдийн өөрсдийн орлогоо ихэвчлэн янз бүр, тухайлбал, өдөрт 3000-5000 төгрөг (31.5%), 6000-9000 төгрөг (39.4%), 10000-аас дээш төгрөг олдог гэж (21%) тус тус олдог гэж хариулжээ. Мөн хүүхдүүд орлогын хувьд алтны гарц болон тухайн өдрийн нөхцөл байдлаас шалтгаалан янз бүр байдаг гэсэн тайлбарыг хийсэн бөгөөд зарим нь өөрийн орлогоо тодорхойлох боломжгүй гэсэн хариултыг өгсөн байна.

Судалгаанд оролцсон эцэг эхчүүдийн 46.6% нь өрхийн сарын орлогоо 50000 төгрөг хүртэл, 33 % нь 100000 хүртэл төгрөг, үлдсэн 22 % нь сард 100000-аас дээш орлоготой гэж хариулжээ. Тэдгээр эцэг, эхчүүдийн 30% нь цалин, тэтгэвэр тэтгэмж, хувийн аж ахуй зэрэг бусад нэмэлт орлоготой бол үлдсэн 70% гаруй нь дан албан бус хөдөлмөрийн орлогоор амьдарч байна гэж хариулжээ.

Хэдийгээр судалгаанд хамрагдсан хүүхдүүд, эцэг эхийн хувьд орлогоо ийнхүү багаар хэлж байгаа боловч ажиглалт, бусад эдийн засгийн үр дагаврын талаас

“Манайх энд дэлгйр ажиллуулдаг. Химийн хоол хинс,тамхи шидэнз зэрэг ойр зуурын хэрэгцээний зийлсийг борлуулдаг. Ер нь химийн худалдан авах чадвар сайн гэж болно. Нэг айл дунджаар өдөрт 10000 төгрөгийн хинс болон бусад бараа авчихдаг юм. .

Экспертийн ярилцлагын тэмдэглэлээс:

Уулзвар худалдаа эрхээр, Баянхонгор аймгийн Баян Орос сум

үзвэл орлогын хувьд ихээхэн өндөр байна гэж үзэх үндэстэй байна.

Тухайлбал, эдгээр ажлыг хийснээр хүүхдүүд хоногт дунджаар 3000-5000 төгрөгийн орлого олдог гэж тооцоолж байна.

Мөн шороон ордын орчимд амьдарч байгаа айл бүр ачааны буюу жижиг машинтай, мөн мотоцикльтэй байна. Мөн тухайн газар ажиллаж буй баг, бүлэг бүхэнд металл хайгч төхөөрөмж байгаа бөгөөд олон тооны хүмүүс эдгээрийг барин, уул толгод, хөндийгөөр тархан явж байгаа нь нийтлэг байна. Уг металл хайгч төхөөрөмж нь овор хэмжээ, хэдий хир гүнээс алт илрүүлэх боломжтойгоосоо шалтгаалаад 2 сая төгрөгөөс дээш 10 хүртэл сая төгрөгийн үнэтэй байдаг бөгөөд тухайлбал, Баянхонгор аймгийн Баянтээгийн уурхай дээр байнгын борлуулагч дэлгүүртэй болсон байв. Энэ бүгдээс үзэхэд орлогын хувьд судалгаанд хариулснаас илүү дээгүүр гэж үзэх магадлалтай байна.

Өөртөө болон гэр бүлдээ хөдөлмөр эрхэлдэг бага насны буюу 5-12 насны хүүхдүүдийн олборлосон алт, жоншийг эцэг, эх нь илүүтэйгээр борлуулдаг болох нь харагдаж байна.

¹¹ Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилт Үндэсний хоёрдахь илтгэл, Хураангуй 2007 14 хуудас

Харин нас нэмэгдэх тусам алт олборлож буй хүүхдүүд өөрсдөө олборлосон ашигт малтмалаа борлуулдаг буюу түүний орлогоо өөрөө захиран зарцуулдаг байдал ажиглагдаж байна.

Гэвч судалгаанд оролцогчдын өгсөн мэдээллээс үзэхэд тухайн ажлыг хийж гүйцэтгэснээр цалин хөлс, орлогын хувьд төдийлэн хангалттай биш байна. Ялангуяа хүүхдүүдийн хувьд өөрийн орлого, цалин хөлс зэргийг төдийлэн тодорхой тооцож, хуримтлал үүсгэх асуудал байхгүй байгаа нь ажиглагдлаа.

4.5. Хүүхдийн сурч боловсрох нөхцөл байдал:

Судалгаанд хамрагдсан хүүхдийн 57.8% нь сургуульд суралцдаггүй ажээ. Сургуульд суралцахгүй байгаагийнхаа шалтгааныг тэд ихэвчлэн сургуультай холбоотой зардал, мөнгийг төлөх боломж байхгүй гэжээ. Ялангуяа хөдөөгийн алслагдмал сумаас ажиллаж байгаа хүүхдүүдийн дийлэнх нь малчин айлын хүүхдүүд бөгөөд багаасаа сургууль завсардсан, бичиг үсэг мэддэггүй болох нь харагдаж байв.


Дээрх хүнд, хүчир хөдөлмөрийг эрхэлснээр сургуульд суралцахгүй болох, завсардах, сурлагын амжилт муудах зэрэг нөхцөл байдлууд мөн үүсэж байна. Үүний шалтгааныг тухайн орд газар, орон нутагт ойролцоо сургууль байхгүй, шилжилт хөдөлгөөн хийгдээгүй, сургуультай холбогдох зардал, мөнгийг төлөх боломжгүй хэмээн олонх хүүхэд, эцэг эхчүүд тодорхойлжээ. Тухайлбал, Өвөрхангай аймагт хүүхдийн хөдөлмөр эрхлэлт нь тэдгээрийн сургууль завсардалтад хүргэдэг нэгэн гол шалтгаан болох нь тогтоогдсон байна¹².

Ялангуяа олон жил алтан дээр гэр бүлийн хамт ажиллаж, мөнгө төгрөг хуримтлуулж буй айл өрхийн хүүхдүүд сургуульд сурах сонирхолгүй болох, завсардах хандлага илэрч байна. Гэвч сургууль завсардсан хүүхдийн тоо дээрх нутгуудад цөөн байсан бөгөөд дийлэнх хүүхдүүд зуны амралтаараа эцэг эх, гэр бүлийнхний хамт хөдөлмөр эрхэлж байгаа нь тогтоогдсон.

Өвөрхангай аймгийн Уянга сумын Өлт, Баянхонгор аймгийн Баян-Овоо, Бөмбөгөр сумын Алтан-Ус, Буйлст зэрэг алтны уурхайн орд газруудад ОУХБ-аас хэрэгжүүлж буй хүүхдийн тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэх болон хөндийрүүлэх төслийн хүрээнд “Мэдээлэл сургалтын гэр төв”-үүдийг байгуулан ажиллаж байна. Уг гэр төв нь олон нийтийн ойлголт хандлагыг нэмэгдүүлэх, сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулах зорилготой бөгөөд тус сумдын албан бус боловсрол хариуцсан мэргэжилтэн, багш нар ажиллаж, сургуулиас завсардсан болон бичиг үсэг үл мэдэх хүүхдүүдэд сургалт явуулах ажлыг зохион байгуулж байгаа нь сайшаалтай.

¹² МБХАН, Монгол дахь сургууль завсардалтын судалгаа, Тайлан 2006 он, 60 хуудас

ЗУРАГ 1. Сургууль завсардсан хүүхдүүдийн эрхэлж буй ажлын төрлүүд¹³



Мөн тэдгээр гэр төвийн дэргэд сумдын ЗДТГ-ын дэмжлэгтэйгээр нүүдлийн гэр цэцэрлэг ажиллаж, цөөн тооны боловч хүүхдүүдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулах үйл ажиллагааг зохион байгуулж байсан.

Зан суртахууны байдал

Уг судалгааны асуулгад тухайн газар хамт ажиллаж буй хүүхдүүдийн зан суртахууны байдал, түүнд уг хөдөлмөрийн нөхцөл хэрхэн нөлөөлж байгааг тодруулах асуулт тавьсан болно. Уг асуултын хүрээнд асуулгад оролцогчдын 27.2% нь хамт ажиллаж буй хүүхдүүд тамхи татах, архи уух зуршилтай болсон гэж бусдыгаа үнэлжээ.

Харин алтны орд газруудтай ойр орших сум, суурин газрын хүүхдүүд анги бүлгээрээ нийлэн амралтын өдрүүдэд болон заримдаа бүр хичээлийн өдрүүдэд сургалтаа тасалдуулан түр зуурын шинжтэй хөдөлмөр эрхэлдэг тухай мэдээлэл байна. Тухайлбал, Өвөрхангай аймгийн Уянга, Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын сурагчид анги бүлгээрээ хоршин алт ухаж, түүнээс олсон мөнгөөр архидан согтуурах, нийлж наргидаг тухай экспертийн ярилцлагын явцад тэмдэглэгдсэн байна

¹³ МБХАН, Монгол дахь сургууль завсардалтын судалгаа, Тайлан 2006 он, 59 хуудас

“... Манай сумын сургуулийн хүүхдүүд бараг бигд л алт ухдаг. Зарим ахлах ангийн хүүхдүүд баасан гаригт ч юм уу бигдээрээ нийлээд хойшоо явчихдаг. Ингээд хүүхдүүд мөнгө олдог, мөнгө ихтэй болчихоод байгаа. Тийнийгээ дагаад нийллэг, баяр ёслолыг их ерсэн тэмдэглэж, архи тамхи хэрэглэх хандлага ихээхэн гарч байгаа.

Энэ нь сийлдээ бйр зан суртахуун нь эвдэрэхэд хйрч байна. Тухайлбал, энэ хавар гэхэд л хэсэг сурагчид нийлээд архи уучихсан, машинтай явж байгаад багшийгаа явж байхыг хараад “Энэ муу явган багшийг машиныхаа тоосоор булья” гээд багшийгаа доромжилж, гомдоосон хэрэг гарсан

Экспертийн ярилцлагын тэмдэглэлээс:

Өвөрхангай аймгийн Уянга сум.

Эцэг эхчүүдийн үзэж байгаагаар газар ухах, нүхлэх, үүрэх, зөөх, мөнгөн усаар алт бариулах зэрэг нь хүүхэд огт хийж болохгүй буюу хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд гэж дүгнэсэн байна.

4.6. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагаа

Бодлого, хууль тогтоомжийн хүрээнд:

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны дэргэд хүүхдийн хөдөлмөрийн асуудлыг хууль тогтоомж, бодлого шийдвэрт тусгах, түүний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж чиг үүрэг бүхий Хүүхдийн хөдөлмөрийн асуудлаарх үндэсний зохицуулах хороог 2000 онд байгуулж, бүрэлдэхүүнийг 2006 онд шинэчилсэн байна.

Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Хүүхдийн хөдөлмөрийг устгах олон улсын хөтөлбөр (АЙПЕК)- гуравдахь удаагийн хөтөлбөр, төслийг 2005-2009 он хүртэл хэрэгжүүлж байна. Энэ хөтөлбөр, төслийн хүрээнд албан бус уурхай, хөдөө аж ахуй болон үйлчилгээний салбарт хөдөлмөр эрхэлж байгаа, түүнчлэн айл гэрт болон амралт цэнгээний газар үйлчлэгчээр ажиллах зэргээр тэвчишгүй хөдөлмөрт татагдах эрсдэлтэй 6000 гаруй хүүхдэд чиглэсэн цогц үйл ажиллагааг хэрэгжүүлж эхлээд байна.

Хүүхдийн эрхийн хорооны дүгнэлт, зөвлөмжийн 61 дүгээр заалтыг хангах чиглэлээр Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлөөс Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хүнд хэлбэрийг устгахад чиглэсэн нөлөөллийн стратегийг 2007 онд батлан хэрэгжүүлж эхэлжээ. Энэхүү стратегийн хүрээнд бодлого боловсруулагч, олон нийт болон хэвлэл мэдээллийн ажилтан, хүүхдэд чиглэсэн нөлөөллийн олон талт үйл ажиллагаа явуулах, хүүхдийн хөдөлмөрийн талаарх хууль тогтоомж, бодлогын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах, хүүхдийг тэвчишгүй хүнд хөдөлмөрөөс хөндийрүүлэх хөтөлбөр, төслийг өргөжүүлэх замаар олон нийтийн хандлагад өөрчлөлт гаргахыг зорьж ажиллаж байна. Нөлөөллийн стратегийн хэрэгжилтийг Хүүхдийн төлөө үндэсний газар, орон нутгийн хүүхдийн төлөө төвүүд хянах үүрэгтэйгээр ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газар Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын ажил олгогч эздийн холбоо уул уурхайн салбарт хүүхдийн хөдөлмөрийг 2015 он гэхэд арилгах талаар хамтран ажиллах гурван талт хэлэлцээрийг 2005 онд байгуулан ажиллаж байна. Энэ хэлэлцээрийн дагуу орон нутагт ухуулга сурталчилгааны ажил өрнүүлэх, мэргэжлийн боловсрол олгох зэргээр хүүхдийг уурхайн хөдөлмөрөөс хөндийрүүлэх ажлыг Монголын ажил олгогч эздийн холбооноос эрхлэн 2006 оноос талуудын оролцоотойгоор эхлээд байна.

Монгол Улсын Засгийн газар Хүүхдийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын хоёрдугаар тайлан илтгэлээ өргөн барьсантай холбогдуулан Хүүхдийн эрхийн хорооноос 2005 онд ирүүлсэн дүгнэлт, зөвлөмжид Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуульд “насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтад харшлахгүй бол 15 насанд хүрсэн хүн эцэг, эх буюу харгалзан дэмжигчийн зөвшөөрөлтэйгээр хөдөлмөрийн гэрээ байгуулж болно. Мөн мэргэжлийн баримжаа, ажлын дадлага олгох зорилгоор 14 насанд хүрсэн хүнтэй эцэг эх, асран хамгаалагч болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлтэйгээр хөдөлмөрийн гэрээ байгуулж болно” гэсэн заалт хүүхдийн сурч боловсрох настай зөрчилдөж байна дүгнэсэн байна. Засгийн газар зөвлөмжийн энэ хэсгийг судалж байгаа бөгөөд өнөөгийн нөхцөлд өөрчлөх бололцоо бага байна гэж үзжээ¹⁴.

Орон нутгийн хэмжээнд:

Өвөрхангай аймаг:

Тус аймагт “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдтэй тэмцэх аймгийн дэд хөтөлбөр”-ийг боловсруулан, 2006 оноос хэрэгжүүлж байна. Хөтөлбөр нь Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг хориглох болон нэн даруй устгах тухай ОУХБ-ын 182-р конвенц, Монгол улсын Засгийн газрын 2006 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр”-ийн зорилтыг хангах хоёр дахь шатны /2006-2008/ арга хэмжээний чиглэлийн 13 дугаар зорилт, ”Гар аргаар ашигт малтмал олборлож буй иргэдийн хөдөлмөр, нийгмийн хамгааллын нөхцлийг сайжруулах, уул уурхай дахь хүүхдийн хөдөлмөрийг устгах талаар МҮЭ-үүдийн холбооноос баримтлах стратеги” зэрэг баримт бичгүүдэд үндэслэн боловсруулагджээ.

Тус аймагт хүүхдийн тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэх болон хөндийрүүлэх чиглэлээр ОУХБ-ын дэмжлэгтэй төсөл хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ асуудал аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2007 оны үндсэн чиглэлд тусгагдсан байна.

Уг төсөл нь “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгахад орон нутгийн нэгдсэн үйл ажиллагаа” шууд туслалцааны хөтөлбөр нэртэйгээр 2007 оны 01-р сарын 04-өөс эхлэн хэрэгжүүлж байгаа бөгөөд хөтөлбөрийн хүрээнд бүх сумдын Засаг дарга, ЗДТГ-ын Хүүхдийн эрхийн ажилтан, Албан бус боловсролын арга зүйч, ЕБС-ийн нийгмийн ажилтан, Нийгмийн эрүүл мэндийн ажилтан, ажил олгогчдын төлөөлөл, Үйлдвэрчний эвлэлийн ажилтнуудын төлөөлөл зэргийг, шууд туслалцааны хөтөлбөр хэрэгжиж буй сумдын ажлын хэсгийнхнийг хамруулсан хүүхдийн хөдөлмөрийн

¹⁴ Хүүхдийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын 3 ба 4 дигээр тайлан илтгэл, 2007 он 72 хуудас

асуудлаар чадавхи бэхжүүлэх, хамтын ажиллагааг идэхижүүлэх болон ойлголт нэмэгдүүлэх 7 удаагийн сургалтыг зохион байгуулж нийт 230 орчим хүнийг хамруулаад байна.

Шууд туслалцааны хөтөлбөр Уянга, Нарийнтээл, Хархорин, Бат-Өлзий, Баян-Өндөр, Арвайхээр сумдад хэрэгжиж, албан болон албан бус боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдүүд, тэдний эцэг эх, гэр бүлийн гишүүд нийт 160 орчим хүнд хүүхдийн хөдөлмөрийн талаар ойлголт нэмэгдүүлэх, хүүхдийн хөдөлмөрийн хор уршгийг таниулах сургалт, уулзалтыг зохион байгуулсан. Мөн дээр дурдсан гэр төвүүдэд түшиглэн, аймгийн хэмжээнд нийт хөдөлмөр эрхэлж буй 180 /Уянга суманд-60, Арвайхээр суманд 40, Нарийнтээл суманд 20, Баян-Өндөр суманд 20, Бат-Өлзий суманд 20, Хархорин суманд 20 хүүхэд/ хүүхдийг албан бус боловсролын үйлчилгээнд хамруулжээ.

Эдгээр хүүхдүүдийг бүрэн эмчийн үзлэгт оруулж, шаардлагатай амин дэм, эрүүл мэндийн анхан шатны тусламжуудыг үзүүлээд байна. Мөн төслийн хүрээнд “Хүүхдийн хөдөлмөрийг устгахад хүүхдүүд бидний оролцоо” гар зургийн уралдаан, хүүхдийн хөдөлмөрийн асуудлаар мэдээллийн хуудас, сануулга бичиг зэргийг хэвлүүлэн олон нийт, бүх сумдын хэмжээнд тараасан байна. Мөн дээрх гэр төвүүдийг түшиглэн уурхайд гар аргаар алт олборлож байгаа хүүхдүүдийг нийгэмшүүлэх, албан бус боловсролын үйлчилгээнд хамруулах үйл ажиллагааг зохион байгуулж байна.

Баянхонгор аймаг:

Баянхонгор аймаг мөн “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдтэй тэмцэх аймгийн дэд хөтөлбөр”-ийг боловсруулан, ИТХ-ын тогтоол гарган хэрэгжүүлж байна.

Үүний дотор “Хүүхдийн хөдөлмөрийг устгах цогц ажиллагаа, үүнд чиглэсэн нийгмийн түншлэлийг дэмжих нь” нэртэй томоохон төслийг хэрэгжүүлж байна. Уг төслийн хүрээнд доорх ажлуудыг аймгийн хэмжээнд цогцолбор байдлаар хэрэгжүүлж байна. Үүнд:

- Аймгийн хэмжээний хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн судалгааг гаргах, шинэчлэх, хүүхдүүдийн хэрэгцээг тодорхойлох
- Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй болон эрсдэлтэй, далд хэлбэрүүд, тэдгээрийн сөрөг нөлөөллийг эрт илрүүлэх
- Хүнд, тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдэд тулгарч буй зан үйлийн болон эрсдлүүдийн талаар судлах
- Хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүд, тэдгээрийн гэр бүлийн гишүүдэд үзүүлсэн нийгмийн үйлчилгээний үр дүнгийн талаарх мэдээллийг цуглуулах, анализ хийх, бодлогод тусгах
- Мэдээлэл сургалтын гэр төв”-үүдийг байгуулах, олон нийтэд мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлуудыг зохион байгуулах зэргийг төлөвлөсөн байна.

“Хүүхдийн хөдөлмөрийг устгах цогц ажиллагаа, үүнд чиглэсэн нийгмийн түншлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд ЗДТГ, Хүүхдийн төлөө төв, аймгийн Цагдаагийн хэлтэс, Ажил олгогч эздийн холбоо, Үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо зэрэг төрийн болон төрийн бус олон байгууллагын төлөөлөл орж ажиллаж байгаа бөгөөд дээрх зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор олон нийт, хүүхдүүдэд чиглэсэн сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг өргөнөөр зохион байгуулж байна.

4.7. БҮЛГИЙН ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ

Эдийн засгийн шилжилтийн үр дүнд мал аж ахуйн салбарын бүтээмж буурч, үйлчилгээний салбар зонхилгогч салбар болсноор нийслэл төдийгүй хөдөө, орон нутагт ажлын байрны хомсдол үүсэж, хүн амын амьдралд асар их нөлөө үзүүлсэн билээ. Ийнхүү хөдөлмөрийн зах зээлд гарсан өөрчлөлттэй уялдан алт, жонш, нүүрс зэрэг ашигт малтмалыг гар аргаар олборлогчдын тоо эрс өсөж, орд газрыг бараадан нүүдэллэн амьдрагч иргэдийн бүлэг үүсээд байна.

Уг судалгаагаар уул уурхайн салбар дахь хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, ялангуяа хүүхдийн эрүүл мэнд, бие махбодь, сэтгэл санааны хувьд сөрөг үр дагавар бүхий хүнд хөдөлмөр эрхлэж буй шалтгаан, нөхцөл байдал, үр дагаврыг тодорхойлж, тэдгээрийг бууруулах, таслан зогсоох арга замуудыг судлах зорилго дэвшүүлэн ажиллав.

Уул уурхайн хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн олонх нь газар ухах, шороо үүрэх, зөөх, алт угаах, ялгах зэрэг ажил үүрэг гүйцэтгэж, эцэг эхдээ туслах хэлбэрээр ажиллаж байна. Дээр дурдсанчлан хүүхдүүд өдөр тутам 8-аас дээш цаг буюу эсвэл тодорхой цаггүйгээр, хөдөлмөрийн аюулгүй байдал огт хангагдаагүй нөхцөлд эдгээр ажлыг гүйцэтгэж байна. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрт тооцогдож буй эдгээр хөдөлмөр нь дараах хүнд нөхцлүүдийг бүрдүүлж байна. Үүнд:

- Хэт давчуу, гүн нүх, бохир ус
- Хэт халуун буюу хэт хүйтэн
- Амрах, хооллох, ажиллах цагийн дэглэмгүй
- Хөдөлмөр хамгааллын стандарт үйлчилдэггүй
- Техникийн аюулгүй байдал хангагдаагүй
- Насанд хүрэгчдийн зүй бус нөлөө
- Химийн хорт бодистой ажиллах эрсдэл

Тиймээс хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийн хувьд усанд буюу нүхэнд унах, шороо, чулуу эсвэл багаж хэрэгсэлдээ цохиулах, нурсан шороонд дарагдах зэрэг эрсдлүүд тохиолдож эрсдэлтэй бөгөөд үүний үр дүнд хөл гар шалбарах, гэмтгээх, шарх сорви авах нь байнга тохиолддог, хэвийн зүйл мэт болсон байна. Улмаар нуруу, толгой, хөл гар, дотор эрхтэн өвдөж, ханиалгах зэргээр эрүүл мэндэд сөрөг өөрчлөлтүүд гарсаар байна. Энэ байдал нь байнга даарах буюу халууцах, ядрах, хүйтэн усанд буюу газар доорх нөхцөлд ажиллаж, хангалттай хоол тэжээл авч, эрүүл мэндийн тусламж, үзлэг, урьдчилан сэргийлэх ажлууд хийгдэхгүй байгаагаас үүдэж байна.

Хүүхдийн хөдөлмөрийн сөрөг нөлөөг нэгтгэн авч үзвэл:

- Амь нас, эрүүл мэндэд аюултай, эрсдэл өндөр
- Амрах, эрүүл өсөж бойжих, хөгжих, оролцох зэрэг боломжийг хаах
- Сэтгэл санааны болон бусад дарамт учруулах
- Ёс суртахууны ба харилцааны төлөвшил сул
- Сургууль, боловсролоос хөндийрүүлэх
- Боловсролын чанарт сөрөг нөлөөлөх
- Ядуурлыг үе дамжуулан урхагшуулах зэрэг муу үр дагавартай

Хөдөлмөр эрхэлж байгаа олон хүүхэд суурь боловсрол эзэмшиж чадахгүй байх, сургуулиас завсардах, сурлагаар хоцрогдох эрсдэл бодитой байна. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд нь хүүхдийг сургууль боловсролоос хөндийрүүлэх, үр дүн, чанарт сөрөг нөлөө бий болгох, улмаар боловсрол эзэмших боломжийг нь хааж

байна. Мөн гэр орон болон эцэг эхээс нь хөндийрүүлдэг, хүүхдэд сэтгэл санааны болон бусад дарамт учруулах, амрах, эрүүл өсөн бойжих, хөгжих зэрэг олон боломжийг алдагдуулах, ёс суртахуун, оюун ухааны хөгжилд нь сөрөг нөлөөтэй бөгөөд аюултай байдалд хийгддэг, хүүхдийн эрхийг зөрчдөг болох нь тодорхой байна.

Судалгааны явцад хамгийн анхаарал татсан асуудал бол хүүхдүүдийн зүгээс уг ажлыг хийх сонирхол, тэмүүлэл огт байхгүй явдал юм. Судалгаанд оролцсон дийлэнх эцэг эх болон хүүхдүүд хоол ундтай байх, гэр орныхоо амьжиргаанд тус нэмэр болох зорилгоор амьдралын эрхэнд зайлшгүй ажиллах шаардлагатай болдог тухай өгүүлж байна.

Хүүхдийн тэвчишгүй, хүнд хэлбэрийн хөдөлмөр гэж хүүхдийн эрүүл мэнд, өсөлт бойжилтод сөрөг нөлөөтэй, оюун ухаан, ёс суртахууны хөгжил төлөвшилд нь хор учруулах, сурч боловсрох боломжийг хаах, хүчирхийлэл, дарамт учруулах аюул, эрсдэл бүхий хөдөлмөрийн төрлүүдийг хэлнэ.

Ялангуяа, уул уурхайд хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүд аюултай, бохир, тусгаарлагдсан орчинд ажиллаж, улмаар насанд хүрэгчдийн болон нөхцөл байдлын зохисгүй хяналт дор, хүчирхийлэл, дарамт амсах магадлал өндөр байна. Иймд тэдний хувьд эрүүл байх, амьдрах, хөгжих, үзэл бодлоо илэрхийлэх, чөлөөтэй бодож сэтгэх зэрэг эрх нь ноцтой зөрчигддөг байна.

Албан бус уурхайн хөдөлмөр дэх дараах нөхцлүүд нь энэ хэлбэрийн хүүхдийн хөдөлмөрийг тэвчишгүй хүнд хэлбэрийн гэж тооцох үндэслэл болно гэж үзэж байна. Үүнд:

- Хэт давчуу, гүн нүх, бохир ус
- Хэт халуун буюу хэт хүйтэн орчин
- Амрах, хооллох, ажиллах цагийн дэглэмгүй байх
- Хөдөлмөр хамгааллын стандарт үйлчлэхгүй, мөрдөхгүй байх
- Техникийн аюулгүй байдал хангагдаагүй байх
- Насанд хүрэгчдийн зүй бус нөлөөнд автах эрсдэл
- Химийн хорт бодистой ажиллах, хордох эрсдэл

Иймд ОУХБ-ын зөвлөмжид заасны дагуу эдгээр хөдөлмөрийн төрлүүдийг хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрт хамааруулж үзэх ёстой.



ТАВ: ХОТ СУУРИН ГАЗАР ДАХЬ ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨР

5.1 Танилцуулга, ерөнхий мэдээлэл

“Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд” судалгааны энэ хэсэгт хот суурин газар дахь хүүхдийн хөдөлмөрийн төрлүүд, тэдгээрийн дотроос тэвчишгүй хэлбэрт тооцогдох хөдөлмөрийг тодорхойлж, тийм төрлийн хөдөлмөрийн хэв шинж, үр дагаврыг гүнзгийрүүлэн судлахыг зорилоо. Тайланг боловсруулахад ХЭҮК-оос 2007 оны 6 дугаар сараас 12 сард хийсэн судалгааны үр дүн, Хүүхдийн төлөө үндэсний газар, аймгийн хүүхдийн төлөө төвүүд болон мэргэжлийн хяналтын байгууллагын мэдээллийг харьцуулан үзсэн болно. Мөн Олон улсын хөдөлмөрийн байгууллагын АЙПЕК төслийн захиалгаар хийгдсэн судалгааны тайлангуудыг ашиглав.

Хүүхдийн хөдөлмөрийн устгах тухай 182 дугаар конвенцийн 3 дугаар зүйлийн d хэсэгт заасны дагуу мөлжлөгийн чанартай, олон цагаар үргэлжилсэн, хүнд нөхцөлтэй, хүүхдийн бие махбодь, эрүүл мэнд, сэтгэл санаанд муугаар нөлөөлөхүйц, боловсрол олоход нь саад болж байгаа ажил, хөдөлмөрийг тэвчишгүй хэлбэртэй гэж үзэн судлагдахууныг тодорхойлсон болно.

Хот суурин газрын албан хэвшилд хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийн талаарх улсын хэмжээний нэгдсэн статистик мэдээлэл байхгүй боловч 2004 онд Улсын Мэргэжлийн Хяналтын Газраас Улаанбаатар хот, Ховд, Хэнтий, Дундговь, Дорнод аймгуудын албан байгууллагуудад хийсэн үзлэгээр 18-аас доош насны 109 хүүхэд хөдөлмөр эрхэлж байсан нь илэрчээ. Гэвч тэдгээр хүүхдүүдийн нас, ажлын байр, хөдөлмөрийн нөхцлийн талаар тодорхой мэдээлэл авагдаагүй учраас хөдөлмөр эрхлэлт хуулийн дагуу байгаа эсэхэд үнэлэлт хийх боломжгүй байна. Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын

- 2007 оны 8 дугаар сард Багахангай дүүргийн цэцэрлэгийн барилга дээр ажиллаж байсан 17 настай Т цементэн хавтанд даруулж, нас баржээ.
- 2007 оны 5 дугаар сард “Интерьер сервис” ХХК барилга дээр ажиллаж байсан 16 настай Г хамгаалалтгүй тоног төхөөрөмжтэй харьцсаны улмаас хиндээр бэртжээ.
- 2007 оны 3 дугаар сард “Монцахилгаан утас” ХХК-д ажиллаж байсан 17 настай Н цахилгаан утсанд ороолгогдож, шилбээрээ хинд бэртжээ. Тэрээр ХЭК-т хандаж, эрхээ сэргээлгэсэн байна.

үйлдвэрлэлийн ослын жилийн эцсийн мэдээгээр 2007 онд Улаанбаатар хотод нийт 117 хүн үйлдвэрлэлийн осолд орсны 18 нь нас барж, 22 нь хөгжлийн бэрхшээлтэй болж, 77 нь хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдсан байна. Үйлдвэрлэлийн осолд орсон 117 хүний 4 нь 18-аас доош настай байжээ. Эдгээр тоон мэдээ, баримт жишээ нь албан салбарт хүүхэд хориглогдсон төрлийн хөдөлмөр эрхлэх явдал байгааг харуулж байна.

Улаанбаатар хот, аймгийн төвүүд болон бусад төвлөрсөн сум суурин газруудын албан бус хэвшилд 6950 орчим¹⁵ хүүхэд хөдөлмөр эрхэлж¹⁶ байгаагийн 4600 орчим нь

¹⁵ Тоог аймгуудын Цагдаагийн хэлтсийн хийхдийн байцаагчид, Хийхдийн төлсө тевийдийн мэдээлэл, Улсын Мэргэжлийн Хяналтын Газрын 2006 онд хийсэн бйртгэл судалгааны дйн, МЭ консалтинг компанийн 2006 онд хийсэн “Улаанбаатар хот болон сонгогдсон хот суурин газруудын албан бус хэвшил дэх хийхдийн хөдөлмөрийн суурь судалгаа”-ны дйнг харьцуулан гаргасан болно.

¹⁶ Хөдсө, аж ахуй, уул уурхайн салбарт хөдөлмөр эрхэлдэг, бэлгийн мөлжлөг, садар самууны сурталчилгаанд оролцдог хийхдийн тоог хасч тооцов.

Улаанбаатар хотод байна. Хөдөлмөрийн орчин, хэв шинжийг нь харгалзан үзвэл Улаанбаатар хотын албан бус салбарт хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн 24.3 хувь нь буюу 1200¹⁷ орчим нь тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхлэж байна. Аймгуудын¹⁸ Хүүхдийн төлөө төвүүдээс 2007 оны 12 дугаар сард ирүүлсэн мэдээгээр тэдгээр аймгуудын албан бус хэвшилд зах, үйлчилгээний төв, хогийн цэг 2334 хүүхэд хөдөлмөр эрхэлж байна гэжээ.

Хот суурин газрын албан бус хэвшил дэх хүүхдүүдийн хөдөлмөрийн голлох төрлүүд нь жижиглэнгийн худалдаа (хүнсний зүйл, сонин сэтгүүл болон бусад туслах хэрэгсэл) ачаа зөөх, үүрэх, вагон түрэх, чирэх, хоёрдогч түүхий эд цуглуулах, утсаар яриулах, мод хөрөөдөх, хагалах, автомашин угаах харах, авто засвар, нийтийн хоолны газруудад ажиллах, нийтийн тээвэрт мөнгө хураагч хийх, урлаг, цирк, хувцас загварын үзүүлбэрт тоглох, цэвэрлэгээ хийх, айлд гэрийн үйлчлэгч хийх, хүүхэд харах зэрэг байна. Харин албан салбарын хувьд тоосго, барилга, оёдол, нэхмэл, мод бэлтгэх үйлдвэрүүд, зочид буудлуудад хүүхдүүд ажиллах нь харьцангуй элбэг байгаа юм. Хэвлэл мэдээлэл, урлаг соёлын байгууллагуудад цөөн тооны хүүхэд гэрээ байгуулан ажиллаж байна. Хүүхдүүдийн эрхлэж буй хөдөлмөрийн төрлөөс хогийн цэгт ажиллах, зах, хэт хүнд ачаа өргөх, зөөх (ихэвчлэн зах, үйлчилгээний төвүүд, төмөр замын вокзалд хийгддэг), мал, мах бэлтгэх зэрэг ажлууд тэвчишгүй шинжтэй байгаа бөгөөд нэн даруй хоригловол зохих хөдөлмөр мөн. Түүнчлэн, түгээмэл биш ч хүнд нөхцөлтэй, хүнд нөхцөлтэй биш ч хэт олон цагаар үргэлжилсэн буюу шөнийн цагаар эрхэлдэг хөдөлмөр нь тэвчишгүй шинжтэй байна. Хэдийгээр цагдаагийн байгууллагад бүртгэгдээгүй байгаа ч бага насны хүүхдүүдээр гуйлга гуйлгах, шаардах, зохион байгуулах явдал гарч байгаа бөгөөд ийм төрлийн мөлжлөгт хараа хяналтгүй хүүхдүүд өртөх эрсдэл өндөр байна.

“Улаанбаатар болон сонгосон хот суурин газруудын албан бус хэвшил дэх хүүхдийн хөдөлмөрийн суурь судалгаа”¹⁹-ны дүнд 2005 оны 10 дугаар сарын байдлаар Улаанбаатар хотод 9-17 насны 4900 хүүхэд хөдөлмөр эрхэлж байгаа дүр зураг гарчээ. Тэдгээр хүүхдүүдийн 34 орчим хувь нь сургуулиас гадуур байгаа бөгөөд 13 орчим хувь нь уншиж, бичих чадваргүй байна.

Улаанбаатар хотын албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн ажлын байрны нөхцөл нь хүүхдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эрсдлийг агуулж байна. Тухайлбал, нийт хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийн 3 хувь нь өндрөөс унах, хоёр зүйлийн дунд хавчуулагдах, дарагдах эрсдэлтэй газар (барилга, бөөний цэгт), 49 хувь нь зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэт хүнд ачаа өргөж, зөөдөг (зах, вокзалд), 12 хувь нь хурц үзүүртэй багаж хэрэглэдэг (гутал засварын газар, автомашин, дугуй засварын газар), 13 хувь нь түлэгдэх эрсдэлтэй (нийтийн хоолны газар), 9 хувь нь ариун цэврийн шаардлага хангахгүй, өмхий үнэртэй (хогийн цэг), 6 хувь нь хортой болон бохирдсон орчинд (модны зах, хогийн цэг), 67 хувь нь хэт халуун, хүйтэн, дуу чимээ ихтэй, доргилттой газарт, 80 хувь нь хэт их тоосжилттой ажлын байранд тус тус хөдөлмөр эрхэлж байна. Ажлын байрны нөхцлөөсөө шалтгаалан тэдгээр хүүхдүүдийн дунд амьсгалын замын, мэдрэлийн болон шээс ялгаруулах тогтолцооны эмгэг элбэг байна. Түүнчлэн хүүхдүүдэд бэртэж, гэмтэх явдал олонтоо тохиолддог бөгөөд тэдний 16

¹⁷ Улаанбаатар хотын хөдөлмөр эрхлэгч хийхдийн тооноос хөдөлмөрийн хэв шинжийн хувьд мөлжлөгийн чанартай, олон цагаар иргэлжилсэн, хинд нөхцөлтэй, хийхдийн бие махбодь, эрүүл мэнд, сэтгэл санаанд муугаар нөлөөлөхийц, боловсрол олоход нь саад болохуйц ажил эрхэлж буй хийхдийн тоог ялгаж тооцов.

¹⁸ Баянхонгор аймгаас бусад 20 аймаг.

¹⁹ МЭ Консалтинг компани, 2005 он

орчим хувь нь бэртэж, гэмтэж байжээ. Нийт бэртэл, гэмтэл авсан хүүхдүүдийн дунд шарх (88.1 хувь), зөөлөн эдийн няцрал (38 хувь), хугаралт (32 хувь) зэрэг гэмтэл илүүтэй байдаг ажээ.

Түүнчлэн дээрх судалгааны хүрээнд нийслэл хотоос гадна бусад 10²⁰ хот суурин газар дахь хүүхдийн хөдөлмөрийн байдалд үнэлгээ хийсэн байна. Судалгааны дүнд сонгогдсон хот суурин газруудад 7-17 насны нийт 1635 хүүхэд хөдөлмөр эрхэлж байгаа бөгөөд тэдний 515 нь буюу 31.4 хувь нь сургууль завсардсан байна. Хөдөлмөрийн орчин эрүүл ахуйн шаардлагыг хангаж чаддаггүй болон хүйтний улиралд олон цагаар гадаа ажилладаг зэрэг шалтгааны улмаас хөдөө, орон нутгийн хот суурин газарт хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийн дунд амьсгалын замын, шээс ялгаваруулах тогтолцооны эмгэг, элдэв төрлийн харшил элбэг байна.

Хөдөлмөр эрхлэгч хүүхдүүд ажлыг байрны нөхцлийнхөө хүнд болон эрсдэл ихтэйг мэддэг боловч хөдөлмөр хамгааллын хэрэгслийг тэр бүр хэрэглэхгүй байна. Энэ нь хүүхдүүд хөдөлмөр хамгааллын хэрэгслийн ач холбогдлыг ойлгохгүй, анхаарч үзэхгүй байгаатай холбоотой юм.

Хүүхдүүд хөдөлмөр эрхлэх явцдаа ажил олгогч, хамтран ажиллагч, үйлчлүүлэгчдийн зүгээс бие махбодийн болон сэтгэл санааны дарамтад өртдөг бөгөөд нийт хүүхдийн 27 орчим хувь нь ийм төрлийн дарамтад тогтмол болон тогтмол бусаар өртдөг байна. Дарамтад өртөж байсан гэх хүүхдүүдийн 71.7 хувь нь загнуулдаг, хэл амаар доромжлуулдаг, 21.9 хувь нь зодуулдаг, 4 хувь нь дээрэмдүүлдэг гэжээ.

Судалгаанд хамрагдсан эцэг эх, асран хамгаалагчдын 37 хувь нь хүүхдийн хөдөлмөр өрхийн орлогод нэмэр болдог, сургалтын зардлаа өөрөө санхүүжүүлдэгтээ сэтгэл хангалуун байдаг байна. Харин тэдний 60 гаруй хувь нь хүүхдийнх нь эрхэлж буй хөдөлмөр тэдний боловсрол эзэмших боломжийг хязгаарлахын зэрэгцээ эрүүл мэнд, хүмүүжилд нь муугаар нөлөөлж байгаа учраас сэтгэл дундуур байдгаа илэрхийлжээ.

Хүүхдүүд эрхэлдэг хөдөлмөрийнхөө эерэг талыг мөнгөний үнэ цэнийг мэдэрсэн, хоолтой байх болсон, хүнтэй харилцах чадвар нэмэгдсэн, өрхийн амьжиргааны түвшин нэмэгдсэн, найз, нөхөд, хамт олонтой болсон, өөрийн захиран зарцуулах мөнгөтэй болсон гэж тодорхойлсон бол сөрөг талыг боловсрол эзэмших боломжийг хязгаарладаг, эрүүл мэндээрээ хохирдог гэж үзсэн байна.

Хот суурин газар дахь хүүхдийн хөдөлмөр нь олон төрөл хэлбэртэй, тус тусын онцлогтой боловч хүүхдийн амь нас, эрүүл мэндэд аюултай, сурч боловсроход ямар нэг хэмжээгээр саад болж байгаагийнхаа хувьд ижил төсөөтэй юм. Урлагийн салбарт ажиллаж байгаагаас бусад төрлийн хөдөлмөр эрхлэгч хүүхдүүд, тэдний эцэг эх хүүхэд хөдөлмөр эрхлэх нь таагүй зүйл гэж үздэг нь дийлэнх байгаа хэдий ч өрхийн орлого багатайн улмаас хүүхдүүдээ хөдөлмөр эрхлүүлсээр байна. Хөдөлмөрийн хэв шинжээсээ үл хамааран хүүхдүүд ажлын байрандаа болон ажилдаа ирэх, буцах замдаа эрүүл мэнд, амь насаараа хохирох эрсдэлтэй байна. Хот суурин газар дахь хүүхдийн хөдөлмөрийн зарим төрөл мөлжлөгийн шинжтэй байгаа нь анхаарал татаж байна.

5.2 Хогийн цэгт хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүд

²⁰ **Сүврхангай аймгийн Арвайхээр, Хархорин, Сэлэнгэ аймгийн Сихбаатар, Алтанбулаг, Мандал, Дархан-Уул аймгийн Дархан, Дорнод аймгийн Хэрлэн, Чойбалсан, Дорноговь аймгийн Сайншанд, Замын-Ид**

Улаанбаатар хотын хэмжээнд Цагаандаваа, Мориндаваа, Улаанчулуутын гэх хог хаягдлын төвлөрсөн 3 цэг байгаа бөгөөд эдгээр хогийн цэгүүдэд хүүхдүүд хөдөлмөр эрхлэж байна. Түүнчлэн хотын төвийн орон сууцны хороолол, томоохон ресторан, үйлчилгээний төвүүдийн хогийн цэгээс хог хаягдал цуглуулдаг хүүхдүүд ч цөөнгүй байгаа юм. Харин эдгээр цэгүүдээс хамгийн олон хүн ажилладаг, цар хүрээ томоохон нь Улаанчулуутын хогийн цэг тул тус цэгийг сонгон авч хогийн цэгт хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн хөдөлмөрийн нөхцөл, эрсдэлд үнэлгээ хийхийг зорьлоо.

Судалгааны хүрээнд тус хогийн цэгт хөдөлмөр эрхэлж буй 85 хүүхэд, 32 эцэг, эхээс санал асуулга авч, 8 хүүхэд, 5 эцэг, эхтэй ганцаарчлан ярилцаж, холбогдох кейс, тохиолдлыг судлан, орчны ажиглалт хийж, баримтжуулсан болно. Санал асуулганд нийт 85 хүүхэд оролцсон нь 2007 оны байдлаар тус цэгт хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн 90 хувь орчим болж байгаа юм. Иймд тэдний судалгаанд оролцсон байдал нь эх олонлогийн төлөөлөх чадвартай болно.

Энд ажилладаг хүүхдүүдийн талаар нарийн тооцоо судалгаа байхгүй. Хүүхдүүд ирж, очоод л байдаг болохоор тийм судалгаа хийх боломж ч байхгүй байх. Гэхдээ 90-100 хүүхэд лав бий.

Улаанчулуутын хогийн цэгийн

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 4-р хорооны нутаг дэвсгэрт байрлах Улаанчулуутын хогийн цэгт өдөрт дунджаар 330 тонн орчим хог буулгагддаг бөгөөд энэ нь нийслэл хотод өдөрт хуримтлагддаг нийт хог хаягдлын 58.9 хувь нь болж байгаа юм²¹. 2006 оны 12 сарын байдлаар тус хогийн цэгээс нийт 387 хүн хог хаягдал түүж, амьжиргаагаа залгуулж байсны 82 нь буюу 21.1 хувь нь 18-аас доош насны хүүхдүүд

байжээ²². Өөрөөр хэлбэл, 2007 оны байдлаар ойролцоогоор 120-140 орчим хүүхэд Улаанчулуутын хогийн цэгт хөдөлмөр эрхэлж байна. НҮБ-ын Хүүхдийн эрхийн хороонд Монгол Улсын Засгийн газраас хүргүүлдэг үндэсний 3, 4 дүгээр илтгэлд нийслэл хотын хэмжээнд 8-17 насны 130 хүүхэд хогийн цэг дээр хөдөлмөр эрхлэж байгаа тухай дурдсан байна. Хогийн цэгт хөдөлмөр эрхлэгч хүүхдийн тоо жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа байна.

Хүүхдүүдийн талаарх ерөнхий мэдээлэл

Санал асуулгад оролцсон хүүхдүүдийн 2.3 хувь нь 7 хүртлэх, 30.5 хувь нь 8-14 хүртлэх, 60.7 хувь нь 14-18 хүртлэх настай бөгөөд тэдний 56.4 хувь нь охид, 43.6 хувь нь хөвгүүд байна. Тус хогийн цэгт хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийн дундаж нас нь 14 байгаа бөгөөд хүйсийн хувьд ерөнхийдөө тэнцвэртэй байгаа юм.

Хүүхдүүдийн 83.5 хувь нь 3-аас дээш 10 хүртлэх гишүүнтэй өрхөд хамаарч байна. Тэдгээр өрхийн 80 хувь орчим нь сардаа 30000-100000 төгрөгийн орлого олж байгаа ажээ. Энэ тоо эцэг, эхээс авсан санал асуулгын дүнгээр ч батлагдаж байгаа юм. Өрхийн орлого, гэр бүлийн гишүүдийн тоог харьцуулахад, Улаанчулуутын хогийн цэгт хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийн ар гэрийн 92.9 хувь орчим нь ядуу, нэн ядуу амьдралтай²³ байна.

²¹ Нийслэлийн хот тохижуулах газрын мэдээгээр өдөрт дунджаар 560 тонн хог хуримтлагддаг байна.

²² Улаан Загалмай Нийгэмлэгийн Нийслэлийн зөвлөл

²³ Нэг хинд ноогдох ерхийн орлого нь 30000 буюу түүний 40%-аас доош байна. Үндэсний Статистикийн Газрын даргын 2005 оны 133 дугаар тушаалаар ядуурлын шугамыг тогтоосон.


... Хогийн цэгт янз бүрийн амьдрал байдаг. Жишээлбэл, аав, ээжтэйгээ тэнд амьдардаг 17 настай нэг охин байдаг юм. Тэр аав, ээжийнхээ найз 40 аль хэдийн гарсан нэг хинтэй суугаад гэрийнхээ хажууд оромж бариад тэндээ амьдарч байгаа.

Нийслэлийн Улаанзагалмай

Хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийн 96.4 хувь нь гэр хороололд амьдарч байгаа бөгөөд тэдний гэр бүлийн 58.8 хувь нь хөдөө, орон нутгаас шилжин иржээ. Тэдгээр хүүхдүүдийн 32.9 хувь ганцаараа буюу эцэг, эхийнхээ аль нэгтэй амьдарч байна. Түүнчлэн, тэдний²⁴ 3 нь үр, хүүхэдтэй болж, тусдаа амьдарч байгаа ажээ. Хогийн цэгт

ажиллаж байгаа хүүхдүүд дунд насанд хүрээгүй эцэг, эхчүүд байгаагийн шалтгаан нь тэдгээр хүүхдүүдэд гэр бүл, насанд хүрэгчдийн анхаарал, хараа хяналт сул болон тэдний эцэг эх, асран хамгаалагчдын боловсролын түвшин доогуур байгаатай холбоотой юм. Гэхдээ хэдийгээр хогийн цэгт хүүхдээ хөдөлмөрлүүлдэг боловч хүүхэдтэйгээ байнга хамт байж, хараа хяналтаасаа гаргадаггүй эцэг, эх байгааг ч үгүйсгэж болохгүй.

Судалгаанд хамрагдсан 85 хүүхдийн 51 нь буюу 60 хувь нь сургуульд суралцдаггүй байна. Сургуульд суралцахгүй байгаагийнхаа шалтгааныг тэд ихэвчлэн сургуультай холбоотой зардал, мөнгийг төлөх боломжгүй болон шилжилт хөдөлгөөн хийгдээгүйтэй холбон тайлбарласан байна. Сургуульд суралцах хүсэл сонирхлынх нь талаар асуухад хүүхдүүдийн 62.3 хувь нь сургуульд суралцах хүсэлтэй, 25.8 хувь нь сурах сонирхолгүй гэж хариулжээ. Хөдөлмөр эрхлэгч хүүхдүүд сурах хүсэл, сонирхол байгаа боловч сургуульд хамрагдаж чадахгүй байгаа нь судалгааны дүнгээс харагдаж байна. Тус хогийн цэгт ажилладаг судалгаанд оролцогч 12 настай А охин бүжгийн дугуйланд сурах хүсэлтэй боловч хотын захад бүжгийн дугуйлан байдаггүй, тэгээд ч төлбөрийг нь төлөх боломжгүй тухайгаа харамсан ярьж байсан юм. Тэрээр хөдөөнөөс шилжиж ирсэн бөгөөд аймагтаа байхдаа хэд хэдэн бүжгийн тэмцээнд түрүүлж, медаль шагнал авч байжээ.



5.3. Хөдөлмөрийн орчин, хэв шинж:

Хүүхдүүд Улаанчулуутын хогийн цэгт байнгын утаа манан, толгой эргэм эвгүй үнэр, тоосонцортой орчинд хөдөлмөр эрхэлж байна. Түүнчлэн, зуны улиралд хог гэнэт шатаж гал гарах, нуранги үүсэх, хог цөмрөх зэрэг аюул тэдэнд байнга тулгарч байдаг ажээ.

²⁴ 18 насанд хирээгүй.

2006 онд Японы Кокусай Когео байгууллагаас хийсэн “Улаанбаатар хотын хог хаягдлын менежмент”²⁵ судалгаанд оролцогчдын 30 хувь нь Улаанчулуутын хогийн цэгт хөдөлмөр эрхлэхийн хамгийн хүнд хэцүү нөхцөл байдлыг осол, аваарт орох эрсдэлтэй байдал гэж нэрлэжээ. Түүнчлэн тэд эрхэлдэг хөдөлмөрийн нөхцлийнхөө хүнд хэцүү байдлыг байнгын үнс нурам агаарт дэгддэг (15 хувь), гал гарах (15 хувь) хорт хий ялгарах (15 хувь), өмхий үнэр (15 хувь), ундын болон ахуйн хэрэглээний усны хүрэлцээ (10 хувь), хог түүгчдийн дундах өрсөлдөөн (10 хувь) хэмээн нэрлэсэн байна.

Хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийн ихэнх нь машинаас хаягдал буулгах, цуглуулах ажлыг хийж байна. Цөөн тооны хүүхдүүд жолоочтой тохиролцон хөлсөөр (Нэг машин хог буулгахад 1500 төгрөгийн хөлс авдаг.) хог буулгах ажил хийдэг ажээ. Тухайлбал, санал асуулгад оролцсон хүүхдүүдийн 86.6 хувь нь хаягдал цуглуулах, 11.7 хувь нь машинаас хаягдал буулгах, 11.7 хувь нь хөлсөөр хог буулгах зэрэг ажил хийж байна.

Хогийн цэгээс хүмүүс голчлон цаас, картон цаас, шил, хөнгөн цагаан лааз, төмөр лааз, пластик сав зэргийг цуглуулж байна. Кокусай Когео байгууллагаас хийсэн судалгааны тайланд Улаанчулуутын хогийн цэгт ажиллагч нэг хүний өдөрт цуглуулдаг хаягдал, түүнээс олох орлогыг дараах байдлаар тодорхойлжээ.

Хүснэгт 1



Цуглуулдаг зүйлс	Өдөрт цуглуулах хэмжээ	Өдөрт олох орлого /төгрөгөөр/
Цаас	3.4 кг	61
Картон цаас	33 кг	490
Шил	97 ширхэг	610
Хөнгөн цагаан лааз	1.3 кг	580
Төмөр лааз	0.05 кг	30
Ундаа, усны хуванцар сав	1.5 кг	510
Зөөлөн хуванцар	3.3 кг	320
Хатуу хуванцар	6.3 кг	320
Төмөр	24 кг	450
Хуванцар тор	1.0 кг	140
		Нийт 3500 төгрөг

Хүүхдүүдийн хөдөлмөр эрхлэх болсон шалтгааныг судлахад 44.7 хувь нь өдөр тутмынхаа хоол хүнсийг олохын тул, 28.2 хувь нь гэр бүлээ тэжээхийн тулд, 11.7 хувь нь аав, ээж шаардсан учраас ажиллаж байгаа гэжээ. Хүүхэд хөдөлмөр эрхлэхийн давуу талуудыг эцэг, эхчүүд ядрахыг мэддэггүй учраас олон зүйлийг амжуулдаг (31.5 хувь), хөнгөн учраас хогийн машин дээр хурдан гардаг (8.2 хувь), сайн хардаг учраас хэрэгцээт зүйлсийг амархан олдог (7 хувь) хэмээн дүгнэсэн байна. Хүүхдийн хөнгөн, хурдан шаламгай, ядарч байгаагаа анзаардаггүй байдал нь тэднийг хогийн цэгт ажиллуулах хүчин зүйл болж байгаа нь харагдаж байна.

Хүүхдүүд ихэнх нь жилийн дөрвөн улиралд, тодорхой өдөр, хугацаагүйгээр ажиллаж байна. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 28.2 хувь нь долоо хоногийн 7 өдөр, 14.1 хувь нь 6 өдөр, 17.6 хувь нь 5 өдөр, 24.7 хувь нь тодорхой өдөргүйгээр ажилладаг бол тэдний 17.6 хувь нь өдөрт 8-аас дээш цаг, 72.9 хувь нь өдөрт тодорхой цаг хугацаагүйгээр ажилладаг гэжээ. Кокусай Когео байгууллагын судалгаагаар тус хогийн цэгт ажилладаг насанд хүрэгсдийн 80 хувь нь өдөрт 10-аас дээш цагаар ажиллаж байна гэсэн байна. Хогийн цэгт ажиллаж буй хүүхэд, насанд хүрэгсдийн дунд

²⁵ Судалгааны тайлан, хуудас 2-65

ажлын цагийн ялгаа байхгүй тул тодорхой цаг хугацаагүйгээр ажилладаг хүүхдүүд 10-аас дээш цагаар ажилладаг гэж ойлгож болно.



Хогийн цэгт машин ирэх бүрт хүүхдүүд бие биенээсээ өрсөн ажиллах ёстой²⁶ болдог бөгөөд тодорхой амралт, завсарлагаа авахгүй байна. Хогийн цэг орчимд цэвэр усны худаг, худалдааны цэг байхгүй тул тэр бүр ус ууж чаддаггүйгээс гадна зарим хүүхдүүд хогноос олдсон хүнсний зүйлсээр хооллож байна.

Хүүхдүүдийн 44.7 хувь нь энэ төрлийн ажлыг 2-3 жил хийсэн бол 11.8 хувь нь 4-6 жил, 21.1 хувь нь 1 жил, 11.7 хувь нь 7 жилээс дээш хугацаанд хийж байгаа ажээ. Энэ нь хүүхдүүд хогийн цэгт харьцангуй тогтвортой ажиллаж байгааг харуулж байна.

Ийнхүү хөдөлмөрлөөд хүүхдүүд хоногт дунджаар 3000 орчим төгрөгийн орлого олдог бөгөөд түүнийгээ өрхийн өргөн хэрэгцээтэй хүнсний бүтээгдэхүүнийг худалдан авах (49.4 хувь) буюу гэрийнхэндээ шууд өгөх (44.7 хувь) байдлаар зарцуулж байна. Хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийн өрхийн орлогод оруулах хувь нэмэр тухайн гэр бүлийн

²⁶ Ойролцоогоор 5 минутанд 1 машин ирдэг.

гишүүдийн байдлаас шалтгаалан янз бүр боловч ерөнхийдөө тэд өрхийн төсвийн 20-40 орчим хувийг олж байна. Хүүхүүдийн орлого гэр бүлийн өдөр тутмын хэрэгцээнд зарцуулагдаж байна.

Хог хаягдал цуглуулахдаа ямар нэг хөдөлмөрийн хэрэгсэл ашиглаж байгаа эсэхийг тодруулахад нийт хүүхдүүдийн 96.4 хувь нь хөдөлмөрийн багаж, хэрэгсэл ашигладаг гэсэн боловч ихэнх нь шуудай, дэгээ төмөр зэрэг хийж буй ажилд нь гарцаагүй шаардлагатай зүйлийг нэрлэжээ. Харин эрүүл мэндээ хамгаалах зорилгоор маск, бээлий зэргийг хэрэглэдэг гэж санал асуулгад оролцсон хүүхдүүдийн 52.9 хувь нь хариулсан байна. Харин сүүлийн 1-2 жилд тусламжийн байгууллагуудын шугамаар хогийн цэг дээр ажиллагсдад бээлий, ажлын хувцас түгээх болсон нь сайшаалтай байна. Гэвч хамгаалалтын хувцас, хэрэгсэл тэдний эрүүл мэнд, аюулгүй байдалд чухал болох талаарх хүүхдүүдийн мэдлэг дутмаг, мэдсэн ч төдийлөн анхаардаггүйгээс тогтмол хэрэглэдэггүй нь ажиглагдаж байлаа. Тухайлбал, ярилцлаганд оролцогч хүүхдүүд бээлий, маск байгаа боловч гэртээ мартсан, тэр бүр ашигладаггүй гэж ярьж байсан нь түгээмэл байв.

Хөдөлмөр ба эрсдэл:

Хогийн цэгийн хөдөлмөр нь хүүхдийн амь нас, эрүүл мэндэд эрсдэлтэй байна. Санал асуулгаар хогийн цэгт хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдэд тохиолддог түгээмэл бэрхшээлийг тодруулахад бэртэж гэмтэх, хэл амаар доромжлуулах, зодуулах, маш ихээр ядрах гэсэн бол хогийн машинаас унах, хогонд даруулах, машинд дайруулах зэрэг осолд хааяа өртдөг гэжээ. Харин судалгаанд хамрагдсан эцэг, эхүүд дээрх асуудлууд дээр нэмж хорт утаанд угаартах, хог цөмрөх, хөөгдөх зэрэг хүндрэл бэрхшээл байнга гардаг гэж хариулсан байна.

... 2005 оны 6 дугаар сард Улаанчулуутын хогийн цэгт хөдөлмөр эрхлэгч 11 настай хүү тухайн ёд хогийн цэгийг хирээлж байсан далангаас хаягдал цуглуулж байхад нь хогийн машин дээрээс нь хог асгаж, амь нас нь хохирсон. Энэ талаар ямар нэг хэрэг үйцсээгүй бөгөөд хүүгийн буруу болоод өнгөрсөн.

Улаанчулуутын хогийн цэгийн талбайн зохицуулагч Т

Хэн хогийн машинд түрүүлж гарна тэр хүн хамгийн их олз, омогтой харих тул ирж буй машинд олноороо зүүгдэх улмаар гэмтэх, бэртэх, амь насаа алдах тохиолдол ч гардаг. Харамсалтай нь хогийн цэгт хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийн ар гэрийн амьдрал дорой, эцэг эх, асран хамгаалагчдын боловсрол, мэдлэг муу, харж хандах хүн муутайгаас эрүүл мэнд, амь насаараа хохирсон ч хохирлоо төлүүлж, эрхээ сэргээлгэж тэр бүр чадахгүй байна.

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 17.6 хувь нь ажлаа хийж байхдаа хэн нэгний дарамтанд өртдөг гэсэн бөгөөд хамгийн ихээр дарамт учруулдаг хүмүүс нь хамт ажилладаг хүүхдүүд (73.3 хувь), хог дээр ажилладаг томчууд (33.39 хувь) байдаг байна. Дарамт, хүчирхийлэлд өртсөн ч хэн нэгнээс тусламж авч чадахгүй байна. Тухайлбал, судалгаанд оролцсон хүүхдүүдийн 10.3 хувь нь хэн нэгний дарамтад өртвөл гэр бүлийхэндээ хэлдэг гэсэн байхад 80 орчим хувь нь энэ асуултанд огт хариулаагүй байв. Харин гэр бүлийнхэн нь дорвитой арга хэмжээ авч чаддаггүй байна.

Хогийн цэг дээр ажиллах болсноос хойш хүүхдүүдийн 30.5 хувийнх нь биед ямар нэг сөрөг өөрчлөлт

... 2006 оны 7 дугаар сард энд ажилладаг байсан Н гэгч охин хогийн машинаас унаад, хинд гэмтсэн. Энэрэл эмнэлэгт бараг сар шахам хэвтүүлж эмчлүүлсэн байх. Эмнэлгээс гарч ирээд дахиад нэг сар болсон уу, үгүй юу нас барсан.

Улаанчулуутын хогийн цэгт амьдардаг иргэн Х

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС

гарсан гэж дүгнэжээ. Хамгийн элбэг тохиолддог эмгэг, зовиур нь толгой өвдөх (73 хувь), харшилтай болох (46.1 хувь) нуруу өвддөг болох (57.6 хувь), арьсан дээр тууралт гарах (42.3 хувь), ханиалгадаг болох (46.1 хувь) зэрэг байна. Үүний зэрэгцээ хордлого авсан, дотор эрхтэн өвддөг болсон, хөл, гар өвддөг болсон, дотор эрхтэн өвддөг болсон тухай тус бүр 2-7 хүүхэд хариулсан байна. Түүнчлэн, санал асуулгад оролцсон хүүхдүүд ажлаа хийж байхдаа хөлөө бэртээх (22.3 хувь), гараа бэртээх (21.1 хувь), нуруугаа бэртээх (4.7 хувь), толгойгоо бэртээх, түлэгдэх (8.2 хувь) зэргээр бэртэж, гэмтэж байжээ. Судалгаанд хамрагдсан эцэг, эхийн 87.5 хувь нь Улаанчулуутын хогийн цэгт хаягдал цуглуулах ажил тэдний хүүхдүүдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлнө гэж үзэж байна. Санал асуулгад хариулсан байдлаас

2007 оны 7 дугаар сард 11 настай А хогийн машинд дайруулж, газар дээрээ нас барсан байна. Хийгийн эцэг, эх буруутай жолоочоос оршуулгын зардал болон машиныг нь шаардаж, өгсөн тохиолдолд ямар нэг хэрэг зарга ийгэхгүй гэжээ. Гэвч жолооч тэдний шаардлагыг биелүүлэх боломжгүй тул хийгийн эцэг, эх цагдаад хандсан байна.

*Нийслэлийн Улаан загалмай
нийгэмлэгийн ажилтан С.*

тохиолдолд л “Энэрэл” зэрэг буяны үйлчилгээ үзүүлдэг эмнэлэгт хандаж байна. Энэ нь тэдгээр өрхүүдийн ихэнх нь иргэний харъяалалгүй, бичиг баримт байхгүй байгаатай холбоотой юм.

Санал асуулгаар тус хогийн цэгт хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийн зан суртахууны байдлыг судлаж үзлээ. Хүүхдүүдийн хариулснаар тэдний дунд тамхи татах, архи уух, муухай ааштай болох, бусдад уруу татагдах, гэмт хэрэгт оролцох зэрэг тохиолдол элбэг гардаг ажээ. Энэ талаар эцэг, эхчүүд ч ижил хариулт өгч байна. Нийт эцэг эхчүүдийн 81.25 хувь нь хогийн цэгт ажиллах нь тэдний хүүхдүүдийн зан суртахуун, хүмүүжилд муугаар нөлөөлнө гэж үзжээ.

Хогийн цэгт ажилладаг, ялангуяа тэнд амьдардаг, хогноос хооллодог хүүхдүүд өөрсдийгөө “хүн биш” мэтээр үзэж, хандаж байгаа нь хамгийн сэтгэл эмзэглүүштэй байлаа. Тэд өөрсдийгөө “лавианы банхар”, “халтарууд”, “цыганууд” гэх бөгөөд хогийн цэгт ажилладаггүй бусад хүмүүсийг “цагаанууд” гэж нэрлэн биднээс өөр, тусдаа хүмүүс гэж үзэх үзэл, хандлагатайгаар өсч байна. Мөн тус хогийн цэгт хөдөлмөр эрхлэдэг 13-аас дээш насны охидууд бэлгийн хүчирхийлэлд өртөх, садар самуунд уруу татагдах эрсдэлтэй нөхцөлд байна. Тухайлбал, Нийслэлийн Улаанзагалмай нийгэмлэгээс Улаанчулуутын хогийн цэгт хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдэд зориулан зохион байгуулдаг албан бус сургалтанд хамрагддаг охид, хөвгүүдийн зарим нь чөлөөт цагаараа “шоудах” буюу согтууруулах ундаа хэрэглэж, “том хүний” кино үздэг төдийгүй бэлгийн харьцаанд ордог тухайгаа ярьж байна.

... Ийм хийгийн дунд, ийм орчин нөхцөлд амьдарч байгаа хийхдүүд яаж зан суртахууны хувьд өөрчлөгдөхгүй байхав дээ. 10 хирэхгүй настай жаахан юмнууд беегнереэд тамхи татаж л байх юм. Ярьж хэлж байгаа нь ч гэсэн их л эвгүй. Манайх энд 8-10 насны хоёр ачтайгаа амьдардаг. Тэд маань ч гэсэн ийм л болж байна. Энэ бичсэн яахав дээ. Хамгийн хэцүү нь энэ хийхдүүдэд ямар ч ирээдүй алга.

*Улаанчулуутын хогийн цэгт
амьдардаг иргэн Х –гийн ярианаас*

хогийг ажиллах нь хүүхдийн эрүүл мэндэд ихээхэн сөрөг үр дагавартай болох нь харагдаж байна.

Бэртэж, гэмтсэн тохиолдолд хүүхдүүд эмнэлгийн тусламж авч чадахгүй байгаа нь анхаарал татаж байна. Жижиг осол, бэртлийг хүүхдүүд ч, тэдний эцэг эх, асран хамгаалагчид ч төдийлөн хайхарч үздэггүй бөгөөд маш их хүндэрсэн

Судалгаанд хамрагдсан эцэг, эхийн 12.5 хувь нь хүүхдээ цаашид ажлаа хийж байсан нь дээр гэж үзсэн бол 59.3 хувь нь цаашдаа ажиллуулахгүй гэж боддог, 18.7 хувь нь цаашдаа огт ажлуулахгүй, 9.3 хувь нь амьдрал сайжирвал одоо ч больж болно гэж хариулжээ. Хэрвээ хүүхэд нь хогийн цэгт ажиллахаас татгалзвал хэрхэн тухай асуухад 50 хувь нь хүүхэд өөрөө л шийднэ биз, 21.8 хувь нь ажлаа үргэлжлүүлэн хийж, гэр бүлдээ тус дэм болохыг шаардана гэсэн байхад 6.25 хувь нь ямар нэг ажил заавал хийлгүүлнэ гэж хариулсан байна. Хүүхдээрээ цаашид ажил хийлгэнэ гэсэн бодолтой эцэг эхийн тоо харьцангуй бага байгаа эерэг дүр зураг гарч байгаа нь талархууштай боловч тэдгээр өрхийн амьжиргаа дорой байгаа нь хүүхэд хөдөлмөр эрхлэх бодитой шалтгаан болсоор байгаа юм.

Хогийн цэгт хөдөлмөр эрхлэгч хүүхдүүд ил задгай, бохир заваан, эрсдэлтэй орчинд олон цагаар ажиллаж байна. Тэдний зарим нь сургууль боловсролоос ангид, соёл хүмүүжлээс хол, хүчирхийлэл, садар самуун, гэмт хэрэг гэх мэт нийгмийн сөрөг үзэгдлүүдийн сүүдэр дор амьдарч, амьдрахын тулд ажиллаж байгаа нь сэтгэл эмзэглүүлж байна. Иймээс хогийн цэгт ажиллах нь нэн даруй устгавал зохих хүүхдийн тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр мөн.

5.4. Захуудад ажиллагч хүүхдүүд

Улаанбаатар хотын захууд дахь хүүхдийн хөдөлмөрийн талаарх дэлгэрэнгүй судалгааг 2002 онд МУИС-ын Хүн ам зүй, сургалт, судалгааны төв хийсэн. Энэ судалгаанд нийслэлийн 6 дүүргийн 11 захад хөдөлмөр эрхлэгч 300 хүүхэд хамрагдсан бөгөөд судалгаагаар тэдгээр хүүхдүүдийн хувийн байдал, хөдөлмөрийн нөхцөл, учирч буй саад бэрхшээл, хүсэл тэмүүллийг тодорхойлжээ. “Улаанбаатар хотын захууд дээр хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн нөхцөл байдал” судалгааны үр дүн нь энэ мэдээллийн үндсэн эх сурвалж юм.

Харин дээрх судалгааг хийснээс хойших 5 жилийн хугацаанд захуудад хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийн нөхцөл байдалд орсон өөрчлөлтийг тодорхойлох зорилгоор бид нийслэлийн Нарантуул, Да хүрээ, Барс, Хүчитшонхор, Хархорин, Хангай, Цайз захуудад тандалт судалгаа хийсэн бөгөөд судалгаандаа дээрх захуудад хөдөлмөр эрхлэгч 66 хүүхдийг хамрууллаа. Үүний зэрэгцээ сонгон авсан захуудад хөдөлмөр эрхлэгч насанд хүрэгсэд, тэрэг түрээслүүлэгч зэрэг 8 хүнтэй ганцаарчлан ярилцаж, захуудын хэв журмын байдалд хяналт тавьж ажилладаг цагдаагийн 7 албан хаагчтай бүлгийн ярилцлага зохион байгуулах замаар тайланд орсон мэдээллийг цуглууллаа.

Бидний тоогоор Улаанбаатар хотын том, жижиг захууд, худалдааны төвүүдэд 1800 орчим хүүхэд хөдөлмөр эрхэлж байна. Эдгээрээс цар хүрээ, хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийнхээ тоогоор хамгийн том нь Нарантуул зах байгаа бөгөөд 2007 оны байдлаар тус захад 450 орчим хөдөлмөр эрхлэгч хүүхэд бүртгэгдсэн талаар Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын үндэсний гурав ба дөрөвдүгээр тайлан илтгэлд дурджээ.

...Захуудад хөдөлмөр эрхлэгч хүүхдийн нэмэгдлэхгйн тулд заримыг нь хөөдөг. Ер нь дураар нь тавьбал улам бір нэмэгдэх л байх.

*Цагдаа нартай хийсэн
бүлгийн ярилцлагын тэмдэглэлээс...*

Захуудад хөдөлмөр эрхлэгч хүүхдүүд 2002 оныхтой харьцуулахад тооны хувьд нэлээд цөөрсөн байна. Энэ нь нэг талаас 2002 онд судалгаа явуулах үед захуудад хөдөлмөр эрхэлж байсан хүүхдүүдийн ихэнх нь одоо насанд хүрсэн, нөгөө талаас захуудын удирдлага, цагдаа нар шинээр ажил, хөдөлмөр

эрхлэх хүүхдүүдэд боломж, зөвшөөрөл тэр бүр олгодоггүйтэй холбоотой ажээ. Түүнчлэн ихэвчлэн захуудын удирдлагууд, цагдаагийн ажилтнуудад хүлээн зөвшөөрөгдөж, тэдний итгэлийг олсон хүүхдүүд байнга ажиллах болсон өөрчлөлт ажиглагдаж байлаа.

Хүүхдүүдийн талаарх ерөнхий мэдээлэл

2002 оны судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 64.3 хувь нь эрэгтэй, 35.7 хувь нь эмэгтэй байсан бөгөөд тэдгээрийн талаас илүү хувийг 13-15 насны хүүхдүүд эзэлж байжээ. Тандалтын судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 66.6 хувь нь эрэгтэй, 28.7 хувь нь эмэгтэй байв. Захуудад хөдөлмөр эрхлэгч хүүхдийн дундаж нас ойролцоогоор 13.5 байна.

2002 оны судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 58.7 хувь нь сургуульд суралцдаггүй гэсэн бол бидний судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 71.7 хувь сургуульд сурдаггүй байна. Энэ нь хичээл эхэлснээс хойш тандалт судалгааг авсан тул ихэвчлэн сургууль сурдаггүй хүүхдүүд л захуудад ажиллаж байсантай холбоотой юм. Сургуульд суралцаагүй тухай шалтгаанаа тэд сургуультай холбоотой гарах зардлыг төлөх боломжгүй (47.9 хувь), гэрийн ойролцоо сургууль байхгүй (47.9 хувь), сурах сонирхолгүй (14.5 хувь), шилжилт хийлгээгүй (12.5 хувь) гэж хариулсан байна.

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 62.1 хувь нь хөдөө, орон нутгаас шилжиж иржээ. Улаанбаатар хотын харьяат хүүхдүүдийн дийлэнх нь сурахын хажуугаар ажил эрхэлдэг бол хөдөөний болон шилжин ирсэн хүүхдүүд нь суралцахгүйгээр ажиллаж байсан тухай өмнөх судалгааны дүн энэ удаад ч давтагдаж байна.

Хүүхдүүдийн хөдөлмөр эрхлэх болсон голлох шалтгаан нь өдөр тутмынхаа хоол, хүнсийг олох (21.21 хувь), гэр бүлийнхнийгээ тэжээх (19.69 хувь), аав, ээжийн шаардлагаар (18.18 хувь) байсан бол сургалттай холбоотой зардлаа төлөхийн тулд хөдөлмөр эрхлэж байгаа гэж нийт хүүхдийн 9.09 хувь нь хариулсан байна. Хөдөлмөр эрхлэх болсон шалтгааны талаарх асуултад хариулсан байдлаас аав, ээжийнхээ шаардлагаар ажиллаж байгаа гэсэн хүүхдийн тоо харьцангуй өндөр байгаа нь орлого бага өрхийн хүүхдүүд эцэг, эхийнхээ шаардлагаар ажил хөдөлмөр эрхлэдэгийг харуулж байна.

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн өрхийн ам бүлийн дундаж тоо 6 байгаа бөгөөд тэдний 66.6 хувь нь гэрт, 31.8 хувь нь хашаа, байшинд, 1.5 хувь нь орон сууцанд амьдарч байна. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 86.3 хувийнх нь өрхийн сарын орлого 30000-100000 төгрөгийн хооронд хэлбэлзэж байгаа бөгөөд хүүхдүүдийн амьдардаг орон сууцны байдал, өрхийн орлогын хэмжээ нь тэдний гэр бүл бага орлоготой байгааг харуулж байна.

Хөдөлмөрийн орчин, хэв шинж

Захуудад хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийн ихэнх нь тоосонцор, дуу чимээ ихтэй орчинд өвөл, зуны аль ч улиралд ил задгай газарт ажиллаж байна. Түүнчлэн зах, худалдааны төвүүдэд машин олноор цуглардаг учраас тэнд ажиллагсад их хэмжээний утаа угаар, хорт хийтэй орчинд нөхцөлд хөдөлмөрлөж байгаа юм. Хэдий байдал ийм ч зах дээр ажиллагсад шаардлагатай үедээ орж дулаацах, амрах байр байхгүй байна. Хөдөлмөрийн орчны энэ мэт сөрөг байдал нь хүүхдийн эрх зөрчигдөх, эрүүл мэндээрээ хохироход хүргэж байна.

Захуудад ажиллагч хүүхдүүд тэргэнцэрээр ачаа зөөх, ачаа өргөх, ачих, буулгах, жижиглэнгийн худалдаа хийх (чихэр, жимс, хоол, хүнсний зүйлс, сонин уут, хүүдий зарах), машин угаах, харах, гутал тослох, төмс, ногоо ялгах зэрэг ажил хийж байна. Хүйсээр авч үзвэл эрэгтэй хүүхдүүд тэргээр болон тэрэггүйгээр ачаа зөөх ажлыг голлон хийдэг бол эмэгтэй хүүхдүүд хүнсний хаягдал цуглуулах, жижиг бараа зарах ажлуудыг хийдэг ажээ. Бидний судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн олонх нь буюу 74.2 хувь нь ачаа зөөж, өргөдөг хүүхдүүд байгаа бөгөөд эдгээрээс гадна машин угаадаг, хардаг, мод бэлтгэдэг хүүхдүүдийн төлөөллийг судалгаандаа илүү оролцуулахыг зорьсон. Харин гар дээрээс жижиглэнгийн худалдаа хийдэг хүүхдийг (7.5 хувь) цөөн тоотой оролцуулсан юм. Энэ түүврийн сонголт нь хүүхдийн хүнд, тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөрийн нөхцлийг гүнзгийрүүлэн судлах манай судалгааны зорилгоос үүдэлтэй бөгөөд захуудад ажиллагч хүүхдүүдийн талаар урьд өмнө нь хийгдсэн судалгааны үр дүнг харгалзан тодорхойлсон юм.

Тэрэг түрдэг хүүхдүүд гол төлөв 15-18 насны хөвгүүд байгаа бөгөөд манай судалгаанд хамрагдсан тэрэг түрдэг хүүхдүүдийн хамгийн бага нь 13 настай байв. Эдгээр хүүхдүүд нэг удаад доод тал нь 10-20 кг, дээд тал нь 500 кг-аас 1 тонн хүртэл ачаа зөөж, тээвэрлэж байна. Энэ нь Нийгмийн Хамгаалал Хөдөлмөрийн сайдын тушаалаар батлагдсан насанд хүрээгүй хүнээр өргүүлэх, зөөлгөх хэмжээнээс 4-8 дахин их байгаа юм. (Тушаалд 13 хүртэл насны хүүхэд хоёр дугуйтай тэргэнцэрээр ачаа зөөхийг хориглодог, харин 16-17 насны хүүхэд 1 удаа зөөх ачааны хэмжээ нь 115 кг-аас хэтрэхгүй байх тухай заасан.) Тэрэггүйгээр ачаа өргөж, зөөдөг хүүхдүүдийн ачааны хэмжээ доод тал нь 20-80 кг байгаа нь зөвшөөрөгдсөн хэмжээнээс их байгаа юм.

... “Тэгш мөр” төвийн “Цоглог” клут суралцдаг 15 настай О хий зах дээр ачаа зээдэг бегеед хичээн хинд ачаа байсан ч хамаагүй 100 тегрегеер ирдэг. 50 кг ачаа ирэх тохиолдол байнга гардаг. Нэг едер бix биен дээгiр нь улаан юм туурч, хендiрлээд 10 хоног халуурсан. Эмнэлэгт iзiйлэх гэсэн боловч даатгалын дэвтэргий, мөнгөгий байсан учраас iзiйлж чадахгүй нэлээд хугацаа алдсан. Харин дараа нь Халдварт Евчин Судлалын Индэсний Төвд

Ерөнхийдөө тэргэнцэрээр ачаа зөөж байгаа хүүхдүүд зөвшөөрөгдөх хэмжээнээс 4-8 дахин, ачаа зөөж байгаа хүүхдүүд 4-5 дахин хүнд ачаа зөөж байгаа бөгөөд хэмжээнээсээ хэт илүү ачаа зөөж яваад осолд орох, ачаандаа даруулах, гэмтэл, бэртэл авах тохиолдолууд байнга гардаг байна. Үүний зэрэгцээ ачаагаа зөөлгөж байгаа томчууд хүүхдүүдийг загнаж, аашлах, айлган сүрдүүлэхийг урьтал болгодог төдийгүй мөнгөө гүйцэд өгөхгүй байх тохиолдол ч их гардаг талаар хүүхдүүд ярьж байв. Даах, аюулгүй хэмжээнээсээ хэт их ачаа

зөөснийхөө улмаас хүүхдүүд эрүүл мэндээрээ хохирч байна. Харин зарим эцэг эхчүүд хүүхдээ хамгаалах, эмчлүүлэхийн оронд ажил хийх, мөнгө олохыг шаардах, айлган сүрдүүлэх тохиолдол цөөн боловч гарч байгаа юм. Тухайлбал, Барс зах дээр ачаа үүрдэг 14 настай “А” хүүгийн эцэг, эх нь архи уудаг бөгөөд “А”-гаас мөнгө нэхэхийн зэрэгцээ, өөдөөс юм дуугарлаа, бага мөнгө авчирлаа гэж зоддог байна. А хүү багадаа халуун цайд түлэгдсэнээс болж унадаг, татдаг болсон бөгөөд ажил их хийснээс болж заримдаа өдөрт 3-4 удаа хүртэл татдаг болжээ. Харин ажил хийхгүй бол ээж нь мөнгө авчирсангүй гэж зоддог байна. “А” одоо “Тэгш мөр” төвийн албан бус сургалтанд хамрагдаж байна.

Нарантуул захын тэрэг түрээслэгчийн тайлбарласнаас тэд тэргийг зөвхөн 18-аас дээш насны хүмүүст олгож байгаа бөгөөд түрээсний төлбөр тэргэний том, жижгээс хамаарч 1500-2500 байдаг байна. Түрээсээр тэрэг олгохдоо түрээслэгчийн иргэний

үнэмлэхийг нэг талаас тэргэний барьцаа, нөгөө талаас хүүхэд тэрэг түрээслүүлэхүйн тулд тавих хяналтын журмаар авдаг гэж тайлбарлаж байв. Харин судалгаа хийх үед хэдийнэ 20 гаруй тэрэг түрээслэгдсэн байсан ч 1 иргэний үнэмлэх түрээслэгчид хадгалагдаж байлаа. Түрдэг тэргийн хэн нэг насанд хүрсэн хүний нэр дээр аваад 13-15 насны хүүхдүүд ажилладаг тохиолдол цөөнгүй байна.

Барс зах дээр барааг их хэмжээгээр нь бөөндөж, борлуулдаг тул ачаа ачих, буулгах хөдөлмөр эрхэлдэг хүүхдийн тоо харьцангуй өндөр байдаг. Тэд вагоноос хүнсний бараа, материал буулгах, машинд ачих, түүнийг захын складууд уруу зөөх, буулгаж хураах, үүрч зөөх, төмс хүнсний ногоо сортлон ялгах, шуудайлах, лангуу хүртэл зөөх ажлууд голдуу хийгддэг. Төмс хүнсний ногоог шуудайгаар үүрч зөөх, машинд ачиж, буулгах ажил хүүхдүүдийн хийдэг үндсэн ажил болдог байна. Зоорины ногоо ялгах ажлыг охидууд хийдэг бөгөөд энэ нь тоос ихтэй, нөхцлийн хувьд хүндэд тооцогдох ажил юм. Мөн энэ зах дээр хаягдал ногоо цуглуулж зардаг хүүхдүүд ч ажиллаж байна.

Мод, түлээ, нүүрсний зах дээр ажилладаг хүүхдүүд машинаар ачиж ирсэн мод, түлээ, банзыг буулгаж хураах, машинд ачих, мод хөрөөдөж, жижиглэх хагалах шуудайлах, мод, түлээ, нүүрсийг зөөж, айл гэрт хүргэх зэрэг ажлуудыг хийж байна.

...Би өнгөрсөн жилээс модон дээр ажиллаж байгаа. Мод шуудайлахаас эхлээд ерех, зөөх гээд аль тааралдсан ажлыг л хийнэ дээ. Хашааны эзэн даалгавар өгдөг. Ингэж ажлаад мөнгө авдаггүй. Гэхдээ иртэс, зомгол аваад эмээлдээ аваачиж өгдөг. Тілээндээ

Голдуу 10-15 насны охидууд гар дээрээс жижиг наймаа, худалдаа хийж байна. Гэхдээ жижиглэнгийн худалдааг 6-7 настай хүүхдүүд ч хийж байгаа юм. Тухайлбал, 2006 онд Хүүхдийн төлөө үндэсний газраас зохион байгуулсан “Хүүхэд насаа сурч, хөгжихөд зориулъя” хөдөлмөр эрхлэгч хүүхдийн чуулганд оролцогчдын хамгийн бага нь зах дээр мэдээ зардаг 6 настай Б хүү байжээ. Тэдгээр хүүхдүүд гар дээрээс чихэр, самар, жимс, хоол, хүнс, сонин, гялгар уут зэрэг зүйлийг бага хэмжээгээр зарж, борлуулж, орлого олж байна.

...Да хирээ захад машин угаадаг 20 гаруй хїхэд байдаг. Тэдний бараг 10 нь насанд хїрчихлээ дээ. Мєн машин хардог 9 хїхэд байдаг. Тэдгээр хїхдїїд бол итгэл даасан хїхдїїд.

Техникийн захад ажиллагч хүүхдүүд худалдах машиныг угааж цэвэрлэх, манах зэрэг ажлыг хийж байна. Ийм төрлийн ажил нь ихэвчлэн гадаа хийгддэг тул мөн ч байгаль, цаг уурын өөрчлөлтөөс нэн хамааралтай юм. Да хүрээ захад ажиллагч хүүхдүүдийн зарим нь эрхэлж буй ажилдаа

нэлээд гаршсан байдал ажиглагдаж байна. Захын ажилтнууд, ченжүүд, цагдаа нарын “итгэлийг хүлээсэн” хүүхдүүд аман тохиролцооны үндсэн дээр машин, эд зүйлийг манаж хонодог ажээ. Ойролцоогоор нэг хүүхэд шөнөдөө 20 орчим машин манадаг бөгөөд нэг машин харсныхаа хөлсөнд 1000 төгрөг авдаг байна. Техникийн захад хөдөлмөр эрхлэгч хүүхдэд тулгардаг хамгийн том бэрхшээл бол харж буй машиныгаа эд зүйлийг хулгайд алдах явдал юм. Машины эд зүйлийг хулгайд алдсан тохиолдолд хүүхдүүд төлөх үүрэгтэй боловч төлж чадахгүй байх, улмаар ченжид зодуулах, бэртэх тохиолдол цөөнгүй гардаг тухай хүүхдүүд ярьж байна.

Зах дээр болон захын орчим тоглоом тоглуулдаг, дуулдаг, гутал тосолдог зэрэг ажлыг цөөн тооны хүүхдүүд, гол төлөв дулааны улиралд эрхэлж байна. Судалгааны явцад зах, олон нийтийн газруудад гуйлга гуйж байгаа хүүхдүүд анхаарал татаж

байсан юм. Харин Нарантуул худалдааны төвд судалгаа хийх үед таарсан 3 хүүхэд бидэнтэй уулзаж, мэдээлэл өгөхөөс татгалзсан. Нарантуул захын тэр орчимд байнга ажилладаг худалдаачны яриагаар тэдгээр хүүхдийг арай томоохон (15-16 орчим настай) нэг нь удирдаж, зохион байгуулдаг бөгөөд олсон орлогыг нь хурааж авдаг гэж байлаа. Гэхдээ сүүлийн үед захуудад гуйлга гуйдаг хүүхдийн тоо эрс цөөрч бөгөөд хүүхдүүд ихэнхдээ “боллоцотой хүмүүс” үйлчлүүлдэг том супермаркет, худалдааны төвийг бараадах болсон байна.

Хөдөлмөрийн хуулиар 14-15 насны хүүхдүүд өдөрт 6 хүртлэх цаг, 16-17 насны хүүхэд 7 хүртлэх цаг ажиллахыг зөвшөөрсөн ч зах дээр ажиллаж байгаа хүүхдүүд ихэвчлэн өглөө зах цугларахад ирээд орой тарахад ажлаа дуусгаж байна. Тухайлбал, судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 18.01 хувь нь долоо хоногийн долоон өдөр, 43.9 хувь нь зургаан өдөр ажиллаж байна. Ихэнх захууд долоо хоногийн 1 өдөр амардаг тул хүүхдүүдийн 63 орчим хувь нь зах ажилладаг бүх өдөр ажиллаж байна. Үүний зэрэгцээ тэд хэт олон цагаар буюу эсхүл шөнийн цагаар ажиллаж байна. Тухайлбал, хүүхдүүд ажилдаа өглөө голдуу 10 цагт ирж, орой 20 цагийн үед гэртээ харьдаг бөгөөд өдөрт зах дээр дунджаар 9 цаг орчим байдаг байна. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 69.6 хувь нь өдөрт 8-аас дээш цагаар ажилладаг гэж асуулганд хариулсан байна.

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 69.6 хувь нь жилийн дөрвөн улиралд, 86.3 хувь нь өвлөөс бусад улиралд ажилладаг бол тэд бүгд зуны улиралд ажилладаг байна. Зах ажилладаг бүх өдрүүдэд ажилладаг гэж асуулгад оролцсон хүүхдүүдийн 62.1 хувь нь хариулсан нь хамгийн өндөр үзүүлэлттэй байгаа юм.

Ажлынхаа дундуур хүүхдүүдийн 89.3 хувь нь амарч чаддаг боловч халуун хоол, цай тэр бүр идэж чадахгүй байгаа дүр зураг байна. Ажлын дундуурхи амралтаараа өдрийн хоол иддэг гэж 2002 оны судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 29.7 хувь нь хариулжээ. Харин бидний судалгаанд энэ асуудал хөндөгдөөгүй юм. Ерөнхийдөө дээрх нөхцөл байдлаас хүүхдүүд голдуу өдөрт хоол ундгүй удаан хугацаагаар ажилладаг болох нь харагдаж байна.

Хүүхдийн нас ахих тусам амрах цаг гардаггүй ажээ. Хүүхэд томрох тусам үйлчлүүлэгч олон болж, тэдний ажлын ачаалал улам нэмэгддэг тул завсарлагагүйгээр ажлаа хурдан дуусгах сонирхолтой байдаг байж болох юм. Мөн ажлыг хурдан шуурхай дуусгахгүй бол тэдгээрийг хөлсөлсөн хүмүүс ажлаа зогсооно хэмээн айлгадаг учир хүүхдүүд богино хугацаанд завсарлагагүй ажиллахад хүрдэг байна.

Үйлчлүүлэгчид зөвхөн хүүхэд гэдэг шалтгаанаар томчуудын авах ёстой хөлсөөс бага хөлс өгдөг, заримдаа амласан хөлсөө бүрэн өгдөггүй талаар ачаа зөөгч хүүхдүүд ярьж байлаа. Түүнчлэн, ажлаа хийж дуусгаагүй байхад нь зогсоолгож, том хүмүүсийг үргэлжлүүлэн ажиллуулчихаад, хөлс, мөнгө өгөхгүй байх тохиолдол гардаг байна. Хүүхдийн хөдөлмөрийг шударгаар үнэлэхгүй, маш бага хөлс өгөх явдал олон гардаг талаар удаа дараагийн судалгаанд оролцогч хүүхдүүд өгүүлж байснаас хүүхдийг хямд ажиллах хүч гэж ойлгох хандлага нэлээд түгээмэл байгаатай холбоотой хэмээн дүгнэж болохоор байна.

Захуудад ажилладаг хүүхдүүдийн өдрийн орлого эрхэлдэг ажлынхаа төрлөөс шалтгаалан янз бүр байгаа боловч ерөнхийдөө өдөрт дунджаар 2850 төгрөгийн орлоготой ажиллаж байна. Харин Да хүрээ захад машин манаж хонодог, өдөрт нь машин угаадаг хүүхдүүд өдөрт 12000 орчим төгрөг олж байгаа нь хамгийн их,

жигжлэнгийн худалдаа эрхэлдэг хүүхдүүд дунджаар 950 орчим төгрөг олж байгаа нь хамгийн бага байна.

Зах дээр ажилладаг хүүхдүүд хөдөлмөр хамгааллын багаж, хэрэгсэл хэрэглэхгүй байна. Тухайлбал, судалгаанд хамрагдагчдын 72.2 хувь нь ажил хийж байхдаа хамгаалах хувцас хэрэгсэл ашигладаггүй гэжээ. Хүүхдүүд байнгын гадаа, тоосонцортой орчинд ажилладаг боловч хамгаалах хувцас хэрэгсэл тэр бүр хэрэглэхгүй байгаа нь тэдний эрүүл мэндэд муугаар нөлөөлж байна.

Хөдөлмөр ба эрсдэл:

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 80 гаруй хувь нь ажил хийж байхдаа ямар нэгэн хүндрэл, бэрхшээлтэй тулгардаг гэж хариулсан бөгөөд энэ хариултыг өгсөн хүүхдүүдийн хүйсийн хувьд онцын ялгаа байхгүй байна. Тухайлбал, хөлс мөнгөө авч чадахгүй байх (байнга тохиолддог 10 хувь, хааяа тохиолддог 74.2 хувь), даарч, халууцах (байнга тохиолддог 27.2 хувь, хааяа тохиолддог 59 хувь), маш ихээр ядрах (байнга тохиолддог 21.2 хувь, хааяа тохиолддог 54.5 хувь), бэртэж, гэмтэх (байнга тохиолддог 9 хувь, хааяа тохиолддог 53 хувь), зодуулах (байнга тохиолддог 3 хувь, хааяа тохиолддог 40.9 хувь), дээрэмдүүлэх (байнга тохиолддог 3 хувь, хааяа тохиолддог 30.3 хувь), хөөгдөх (байнга тохиолддог 4.5 хувь, хааяа тохиолддог 46.9 хувь), хэл амаар доромжлуулах (байнга тохиолддог 6 хувь, хааяа тохиолддог 50 хувь), бусдад уруу татагдах (байнга тохиолддог 9 хувь, хааяа тохиолддог 57.5 хувь), атаманд татвар төлөх (байнга тохиолддог 4.5 хувь, хааяа тохиолддог 18.1 хувь), эд хөрөнгөө хураалгах, эвдүүлэх (хааяа тохиолддог 10.6 хувь) зэрэг бэрхшээл тохиолддог гэж хүүхдүүд хариулжээ.

2006 онд зохион байгуулагдсан “Хүүхэд насаа сурч хөгжихөд зориуль” уулзалтын тэмдэглэлд зах дээр ажилладаг хүүхдүүдийг хамгийн ихээр айлгаж, дарамталдаг хүмүүс нь цагдаа, захын ажилтнууд болох талаар хүүхдүүд ярьжээ. Тухайлбал, хүүхдүүд дараах байдлаар санал бодлоо илэрхийлсэн байна.

... Бадмаа гэдэг цагдаа биднийг дандаа зоддог, гэм буруугий байхад дандаа ингэж байдаг. Бид Нарантуул зах дээр ажилладаг.

... Би 97-р сургуульд сурдаг. Зах дээр ажиллахад байцаагч, цагдаа нар татвар авдаг. Татвар егсгийг тохиодолд тэд барааг маань хурааж авдаг.

... Хүүхдүүд зах дээр хөдөлмөр эрхлэж байхад байцаагч нар дарамталж, зодох асуудал гардаг гэж ярьсан. Нэг хүүхдийн гар хугалсан цагдаад ерөөсөө хариуцлага тооцоогий. Ерөөр хэлбэл, тэр хүүхдийн хохь болоод илддэг. Цагдаагийн нарт арга хэмжээ авч егсч ээ.

Зах дээр ажилладаг хүүхдүүдэд дараах төрлийн хүндрэл бэрхшээл тохиолддог байна. Тухайлбал:

- Томчуудын зүгээс дарамт, шахалт үзүүлэх
- Ажлын хөлсийг дутуу олгох
- Таарч тохирох ажил олдохгүй байх
- Үдийн хоол идэж, унд уух боломж нөхцөл муу байх
- Зарим тохиолдолд том хүүхдүүд, согтуу, хөлчүү хүмүүс, гудамжны хүүхдүүд мөнгө нэхэх, дээрэмдэх, зодох

- Дээрэмдүүлсэн хүнд зодуулсан, осол, гэмтэлд орсон үед харж хандах, туслах хүн олдохгүй байх

Бэрхшээл тохиолдсон хүүхдүүд тэр бүр бусдаас дэмжлэг, тусламж авч чаддаггүй байна. Хамгийн сүүлд өөрт нь ямар нэгэн бэрхшээл тохиолдоход эрэгтэй хүүхдүүдийн 59.6 хувь, эмэгтэй хүүхдүүдийн 39.2 хувь нь хэнд ч хандаагүй байв. Харин ар гэрийнхэн, хамаатан садандаа хандсан гэж хөвгүүдийн 20.6 хувь, охидын 40.5 хувь, найз нөхдөөсөө тусламж хүссэн гэж хөвгүүдийн 15.4 хувь, охидын 23 хувь тус тус хариулжээ. Тандалтын судалгаанд оролцсон хүүхдүүдээс хүндрэл, бэрхшээл тулгарсан үед хэнд ханддаг талаар асуухад 42.4 хувь нь гэр бүлийнхэндээ, 15.1 хувь нь цагдаад, 7.5 хувь нь зах дээр ажилладаг томчуудад хандана гэсэн бол 35 хувь нь хэнд ч хандахгүй гэж хариулсан байна.

Судалгаанд хамрагдсан нийт хүүхдүүдийн 69.6 хувь нь зах дээр ажилладаг болсноос хойш эрүүл мэндэд нь ямар нэг сөрөг өөрчлөлт гарсан гэж үзсэн байна. Тухайлбал, ажил хийх болсноос хойш нуруу өвддөг болсон гэж 28.2 хувь, толгой өвддөг болсон гэж 15.2 хувь, хөл, гар өвддөг болсон гэж 4.3 хувь, дотор эрхтэн өвддөг болсон гэж 8.6 хувь, ханиалгадаг болсон гэж 17.3 хувь, арьсан дээр тууралт гарсан гэж 13.0 хувь, харшилтай болсон гэж 4.3 хувь нь тус тус хариулсан байна. Хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийн өвчлөлийн шинж байдлаас гадна бэртэл, гэмтлийн байдлыг асуулгаар тодорхойлсон юм. Асуулгад хамрагдсан хүүхдүүдийн 19.6 хувь нь хөл бэртсэн, 43.9 хувь нь гар бэртсэн, 13.6 хувь нь нуруу бэртсэн, 9.0 хувь нь толгой бэртсэн, 3.0 хувь нь хөлдсөн, 4.5 хувь нь түлэгдсэн байна. Захуудад ажилладаг хүүхдүүдийн 69.5 хувь нь ямар нэг байдлаар өвдсөн, 63.6 хувь нь бэртэж, гэмтсэн байгаа нь энэ төрлийн хөдөлмөр хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөлдөгийг харуулж байна.

... Дундаж тившингээс доогуур амьдралтай хиймийс нь захаар ийлчлүүлнэ ший дээ. Ийм болохоор нөхцөл нь хийхдийн зан суртахуунд сөрөг нөлөө иэиллэхгүй гэх индэс байхгүй.

... Хөдөлмөр эрхлэгч хийхдид бас хулгай хийдэг. Бага балчир насаа ихгэж өнгөрсөн хийхдидийн ирээдэй тийм ч сайнгий л байна байх.

Ижил төрлийн хөдөлмөр эрхлэдэг бусад хүүхдүүд захад ажиллах болсноос хойш зан харьцааны сөрөг өөрчлөлт гарсан талаар судалгаанд оролцогчид ямар санаа бодолтой байгааг асуулгаар тодорхойллоо. Асуулгад хамрагдсан хүүхдүүдийн 60.6 хувь нь хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийн ааш зан эвдэрдэг, 33.3 хувь нь бусад уруу татагдаж, хулгай хийдэг, 25.7 хувь нь архи уудаг болдог,

48.4 хувь нь тамхи татдаг болдог гэж хариулсан байна. Түүнчлэн, МУИС-ын Хүн ам зүй, сургалт, судалгааны төвийн судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 75.3 хувь нь хүүхдүүдийн дунд тамхи татах, 39.7 хувь архи уух явдал түгээмэл байдаг гэжээ. Мөн тэдний 16 орчим хувь нь зах дээр биеэ үнэлдэг охидууд байдаг гэж хариулсан байна. Харин хөвгүүдийн 23.8 хувь, охидын 3.7 хувь болон 15-аас дээш насны хүүхдүүдийн гуравны нэг нь өөрсдөө тамхи байнга татаж байсан байна. Захуудад ажилладаг охидууд хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгт өртөх тохиолдол гардаг нь зарим жишээ, баримтаас харагдаж байна. /Судалгааны “Хүүхдийг бэлгийн мөлжлөгт ашиглаж буй гэмт хэргийн өнөөгийн байдал” хэсгээс үзнэ үү./

Захуудад ажилладаг насанд хүрэгсэд, захын ажилтнууд, цагдаагийн албан хаагчид энэ төрлийн хөдөлмөр хүүхдийн зан суртахуунд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй гэж дүгнэж байна. Гэсэн хэдий ч хөдөлмөр эрхлэх нь сургуульд явдаггүй, амьжиргааны

нөхцөл доогуур хүүхдүүдийн хувьд гадуур дэмий тэнэж байснаас хавьгүй дээр төдийгүй ажлын дадлага туршлага хуримтлуулахад чухал гэж тэд ярьж байна.

Улаанбаатар хот болон бусад хот суурингийн зах, худалдааны төвүүд нь орлого багатай өрхийн гишүүд, хүүхдүүдийн хувьд хөдөлмөр эрхлэх, орлого олох гол талбар юм. Тэнд ажиллагч хүүхдүүд сургуульд суралцахынхаа зэрэгцээ эцэг, эхийнхээ хараа хяналтан дор жижиглэнгийн худалдаа эрхлэх зэргээр амьжиргаандаа хувь нэмрээ оруулж, ажлын дадлага туршлага хуримтлуулж эерэг дүр зураг байгаа боловч хөдөлмөрийн орчин нөхцөл нь тэдний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхүйц байгаа юм. Захуудад хүүхдийн эрхэлж буй хөдөлмөрийн төрлүүдээс эрүүл мэндэд сөрөг үр дагавартай, нэн даруй устгавал зохих тэвчишгүй шинжтэй нь хүнд ачаа өргөх, зөөх байна. Хэдийгээр захууд дахь хүүхдийн хөдөлмөрийн төрлүүд хүнд, хөнгөн янз бүр боловч хэт олон цагаар, амралтгүйгээр ажиллаж байгаагаараа тэвчишгүй хөдөлмөрийн шинжийг агуулж байна.

5.5. Төмөр замын өртөөнд ажиллагч хүүхдүүд

Төмөр замын буудал орчимд ажилладаг хүүхдүүдийн хөдөлмөрийн байдалд үнэлгээ өгөх зорилгоор Хүний эрхийн үндэсний комиссын баг Дорноговь аймгийн Замын-Үүд суманд ажиллав. Замын-Үүд боомт нь бусад төмөр замын дагуух хот суурин газартай харьцуулахад зорчигч, ачаа тээврийн урсгалын хувьд их тул түүнийг дагаад хүүхдийн хөдөлмөр эрхлэлт ч өндөр хувьтай байдаг.

Замын-Үүд сумын хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийн байдал нь төмөр зам орчимд хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийн ерөнхий нөхцлийг илэрхийлж чадна гэж үзсэн учраас тус сумыг сонгож судалгаа хийх болсон юм. Судалгааны хүрээнд хөдөлмөр эрхэлж буй 30 хүүхдээс санал асуулга авч, бүлгийн ярилцлага зохион байгуулан, холбогдох кейс, тохиолдлыг судлан, орчны ажиглалт хийж, баримтжууллаа. Судалгааг хийхэд Замын-Үүд сумын Цагдаагийн хэлтсийн ажилтнуудтай хамтран ажилласан болно.

Замын Үүд сумын Цагдаагийн хэлтэст 2007 оны 8 сарын байдлаар тус сумын төвд хөдөлмөр эрхэлдэг нийт 47 хүүхэд бүртгэгдсэн байгаа нь цөм төмөр замын өртөө, вокзалд орчимд ажиллаж байна. Замын-Үүдийн ачаа, зорчигч тээврийн эргэлт жилээс жилд улам бүр нэмэгдэж байгаатай холбоотойгоор тухайн орон нутагт харьяалалгүй хүмүүс сүүлийн үед олноор суурьшин амьдрах болжээ. Ихэвчлэн шилжин суурьшсан өрхийн хүүхдүүд хөдөлмөр эрхэлж байгаа нь тэд сургуульд суралцдаггүй буюу амьжиргааны түвшин доогуур байгаатай холбоотой гэж дүгнэж болно.

Санал асуулгад оролцсон хүүхдүүдийн 35 хувь нь 8-14 хүртлэх, 65 хувь нь 14-18 хүртлэх настай бөгөөд тэдний 3 нь эмэгтэй байв. Замын-Үүд өртөөнд хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийн дундаж нас 14 байна.

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 40 гаруй хувь нь 7-10 гишүүнтэй өрхөд харьяалагдаж байгаа бөгөөд тэдний гэр бүл сард дунджаар 100 000-200 000 төгрөгийн орлого олж байна. Өрхийн гишүүдийн тоог сарын дундаж орлоготой харьцуулахад тэдгээр хүүхдүүдийн ар гэрийн амьжиргаа доогуур түвшинд байгааг харуулж байна.

Хөдөлмөр эрхлэгч хүүхдүүд цөм гэрт, эсвэл хашаа байшинд амьдарч байна. Судалгаанд хамрагдсан хүүхдийн 12 нь буюу 40 хувь нь сургуульд суралцдаггүй ажээ. Сургууль завсардсан хүүхдүүдийн дийлэнх нь өөр орон нутгаас шилжиж ирсэн, Замын-Үүд суманд харьяалалгүй хүүхдүүд байгаа юм.

Төмөр замын орчимд ажилладаг охидууд голчлон жижиглэнгийн худалдаа эрхэлдэг бол хөвгүүдийн хувьд ачаа үүрэх, зөөх ажлыг хийж байна. Тэдний 86 орчим хувь нь өдөр тутмынхаа хоол хүнсийг олох, гэр бүлээ тэжээхийн тулд хөдөлмөр эрхлэх болсон байна. Ийм ч учраас төмөр замын өртөөнд хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийн олсон орлого гэр бүлийн үндсэн хэрэгцээг хангахад зарцуулагдаж байна.

Хөдөлмөрийн орчин, нөхцөл, хэв шинж:

Төмөр замын орчимд хөдөлмөр эрхлэгч хүүхдүүд тоосжилт, дуу чимээ ихтэй орчинд ажиллаж байна. Үүний зэрэгцээ тэд хэт хүнд ачаа үүрч, зөөж байгаа нь эрүүл мэндэд нь сөргөөр нөлөөлөхүйц хэмжээнд байна. Хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийн ихэнх нь вокзал, ачаа тээшийн хэсэгт ачаа ачих, буулгах, тэрэг түрэх, зорчигчдын гар тээшийг хүргэж өгөх зэргээр ажиллаж байна. Төмөр замын ачаа тээшийн хэсэгт байгууллага, хувь хүмүүсийн БНХАУ-аас оруулж ирсэн том, овор хэмжээ ихтэй ачаа буулгагддаг бөгөөд хүүхдүүд тэдгээр ачааг тэргээр зөөх, жинлүүлэх зэрэг ажил хийдэг. Ачаа тээшийн хэсэгт нэг удаад зөөвөрлөж буй ачааны хэмжээ дунджаар 500-600 кг байх бөгөөд зарим тохиолдолд 1 тонн болон түүнээс дээш жинтэй ачаа зөөвөрлөдөг ажээ.

Үүний зэрэгцээ цөөн тооны хүүхдүүд гар тээш, иргэдийн биедээ авч явж байгаа ачааг вагонд хүргэх, зорчигчдод сонин сэтгүүл, хоол хүнс зарах ажил хийж байгаа бөгөөд энэ төрлийн хөдөлмөр нь харьцангуй хөнгөн, үргэлжлэх хугацаа багатай байдаг ажээ.

Хүүхдүүд ихэнх нь жилийн дөрвөн улиралд, тодорхой өдөр, хугацаагүйгээр ажиллаж байна. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 40 хувь нь өдөрт 8-аас дээш цаг, 30 хувь орчим нь өдөрт 4-6 цаг, үлдсэн нь өдөрт 1-3 цаг ажилладаг гэжээ. Өдөрт 8-аас дээш цагаар ажилладаг хүүхдүүд нь сургууль завсардсан байгаа бөгөөд харин тодорхой цагаар ажилладаг хүүхдүүд хичээл тарсны дараа ажлаа хийдэг байна.

Хүүхдүүдийн 45 хувь нь ачаа өргөх, зөөх ажлыг зөвхөн зун, намрын улиралд хийдэг бол үлдсэн 55 хувь нь жилийн дөрвөн улиралд байнга хийж байна. Байнга ажилладаг хүүхдүүд уг ажлыг сүүлийн 2-3 жилд хийж байгаа бол зун, намар ажилладаг хүүхдүүд ихэвчлэн 1 жилийн хугацаанд ажиллаж байгаа сонирхолтой дүр зураг харагдаж байна. Энэ нь хүүхэд удаан жил ажиллаж, туршлага хуримтлуулах тусмаа ажил нь байнгын шинжтэй болж байгааг харуулж байна. Судалгаанд хамрагдагчдаас нэг нь л уг ажлыг 7 жилээс дээш хугацаанд хийж байгаа ажээ. 2-оос дээш ажиллаж байгаа хүүхдүүдийн олонх нь сургууль завсардсан хүүхдүүд байна.

Хүүхдүүдийн орлого наснаасаа шалтгаалан харилцан адилгүй байна. Тухайлбал, дунджаар нэг хүүхэд хоногт дунджаар 3000-4000 төгрөг олж байгаа боловч 14-18 настай хүүхдүүдийн өдрийн орлого харьцангуй өндөр буюу 4000-8000 төгрөг байна. Мөн судалгаанд хамрагдсан 2 хүүхэд өдөрт 10000-25000 төгрөг олдог гэжээ.

Хөдөлмөр ба эрсдэл

Судалгаанд хамрагдсан нийт хүүхдүүдийн 36.3 хувьд нь даарах буюу халууцах, маш ихээр ядрах, ажлын хөлсөө авч чадахгүй байх зэрэг бэрхшээл байнга тохиолддог гэсэн бол 75.9 хувь нь даарах, халууцах, ядрах, ажлын хөлсөө авч чадахгүй байх, бэртэл гэмтэл авах, бусдад хөөгдөх, хэл амаар доромжлуулах зэрэг хүндрэл хааяа тохиолддог

гэж хариулсан байна. Мөн ажил хийж байхдаа бусад томчууд болон хамт ажилладаг хүүхдүүдийн зүгээс дарамт үзүүлдэг гэж нийт судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 30 хувь нь хариулжээ. Тэд төмөр замын орчимд ажилладаг томчууд, вагоны цагдаа нар, хамт ажилладаг хүүхдүүд дарамт үзүүлж байсныг дурдсан байна.

Санал асуулгад хүүхдүүдийн ихэнх нь хөдөлмөр, хамгааллын хэрэгсэл ашигладаггүй гэсэн боловч тэдний 80 орчим хувь нь нэг удаагийн хэрэглээний ажлын бээлийтэй байв. Харин тоосжилттой орчинд ажиллаж байгаа хүүхдүүдэд амны хаалт хэрэглээ хангалтгүй байдал ажиглагдаж байлаа.

Ажил хийх болсонтой холбоотой эрүүл мэндэд нь өөрчлөлт гарсан гэж нийт судалгаанд хамрагдсан хүүхдийн 39.6 хувь нь хариулжээ. Ихэвчлэн толгой өвддөг, ханиалгадаг болсон, хөл гар бэртээсэн зэргээр өвчин эмгэг, бэртэл гэмтэл тохиолдсон байна. Хөдөлмөр эрхлэж байх явцдаа тэдний 1 нь толгойгоо, 2 нь хөлөө, 4 нь гараа бэртээж байжээ.

Судалгааны хүрээнд эрхэлдэг хөдөлмөр, хамт ажиллагсдын зан харьцаа тэдний хүмүүжил, төлөвшилд хэрхэн нөлөөлж байгааг тандсан болно. Санал асуулгаар нийт хүүхдүүдийн 40 хувь нь зан харьцаа өөрчлөгдсөн гэсэн бол 25 орчим хувь нь бусдад уруу татагдаж, тамхи татах, архи уудаг болсон гэжээ. Ажил хийхийн сайхныг тэд ажлаа дуусгаад гэртээ харих, ажил хийж мөнгө олох, өөртөө хэрэгцээтэй зүйлээ худалдан авах гэсэн бол муу талыг нь ачаа үүрэх, зөөхөд бэрхшээлтэй, насанд хүрэгчид дээрэлхдэг, “гахай” хүнд байдаг гэж тодорхойлсон байна.

Төмөр замын өртөө нь харьцангуй жижиг газар тул тэнд хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдэд тавих насанд хүрэгчдийн болон цагдаагийн байгууллагын хараа хяналт сайн байдаг бөгөөд хүүхдүүд галт тэргийн хувиарын дагуу цагийн хязгаартайгаар хөдөлмөр эрхэлдэг нь тэдэнд тулгарч болох аюул, эрсдлийг бууруулж байгаа юм. Гэсэн хэдий ч зөвшөөрөгдсөнөөс хэт их ачаа өргөж, зөөж байгаа нь хүүхдүүдийн эрүүл мэндэд таагүй нөлөө үзүүлэхүйц хэмжээнд байгаа бөгөөд тэвчишгүй хөдөлмөрийн шинжтэй байгааг анхаарах шаардлагатай байна.

5.6. Циркэд хөдөлмөр эрхлэгч хүүхдүүд

Монгол Улсад 1940-өөд оноос эхлэн харьцангуй амжилттай хөгжсөн циркийн урлаг нийгэм, эдийн засгийн шилжилтийн эхэн үеэс төрийн бодлого, дэмжлэгийн гадна үлдэх болжээ. Ялангуяа 1994 оноос циркийг хувьчлах асуудал тавигдаж, улсын циркийг төсвөөс санхүүжүүлэхийг зогсоосон хийгээд орлогын хомсдолын улмаас үзэгчдийн тоо эрс цөөрсөн нь циркийн урлагийг цаашид “зөнгөөрөө” хөгжихөд, жүжигчдийг “бор зүрхээрээ” амьдрахад хүргэсэн байна.

Монголд циркийн урлаг уналтанд орж эхлэх үед буюу 1990 онд Монголын циркчдын тэмээтэй акробат, уран нугаралтын тоглолт Швейцарьт тоглогдож, үзэгчдээс өндөр үнэлэлт авсан нь тэдэнд Европын зах зээлийг нээлттэй болгоход чухал нөлөө үзүүлжээ. Энэ үеэс циркчдийн тухайлбал, Монгол циркийн нэрийн хуудас болсон уран нугараачдын гадаадыг чиглэсэн урсгал бий болсон байна. Гадаад улс оронд ажиллаж байгаа циркчдын талаар нэгдсэн тоон мэдээлэл байхгүй. Гэсэн хэдий ч циркчдын тархалт, циркийн хамтлаг, бүлгүүдийн гишүүдийн тоог харгалзан үзвэл манай улсын 600 гаруй циркчид хилийн чанадад түр буюу удаан хугацаагаар амьдарч, ажиллаж байна. Гадаад улсад ажилладаг циркчдын 70 орчим хувь нь уран нугаралтын жүжигчид байгаа нь Монголын улсын уран нугаралт дэлхийн хэмжээнд хүртэл хөгжсөнтэй

холбоотой юм. Монголын циркчид дэлхийн аль ч тив, улс оронд тоглож байгаа боловч АНУ, ОХУ, Канад, Герман, Итали, Испани, Турк, Тайвань зэрэг улсуудад олноороо, тогтмол шинжтэй ажиллаж байна.

Циркийн тоглолтын эрэлт, хэрэгцээ гадаадад төдийгүй Монгол Улсад ч нэмэгдэх хандлагатай байна. Сүүлийн жилүүдэд манай улсын аялал жуулчлал, урлагийн салбар хөгжихийн хамт ардын урлагийн тоглолт, жуулчны бааз, амралтын газруудын шоу хөтөлбөр, албан байгууллагын баяр ёслол, хүлээн авалтад ч циркчид, ялангуяа уран нугараачид оролцох нь элбэг болсон. Зах зээлийн эрэлт, хэрэгцээ өсөх нь циркийн хөгжилд чухал ач холбогдолтой боловч үүнийг дагаад циркчид, түүний дотор циркчин хүүхдийн эрх зөрчигдөх тохиолдол гарч байна.

Цирк бол залуу насны урлаг. 5-6 наснаасаа эхлэн хичээллэж байж, 11-13 насандаа үзүүлбэр үзүүлэх чадвартай жүжигчин болдог нь циркийн онцлог юм. Хүүхдийн уян хатан, хөнгөн байдаг онцлогийг акробат, гимнастик, уран нугаралтын үзүүлбэрүүдэд өргөн ашигладаг тул циркийн хамтлаг, баг бүрт хүүхдүүд олон, цөөн тоогоор ажилладаг. Хилийн чанадад ажиллаж байгаа Монголын циркчдын дотор 18-аас доош насны хүүхдүүд олон байгаа юм. Барагцаагаар 100-120 орчим циркчин хүүхдүүд хилийн чанадад ажиллаж байгаа гэж үзэж болох бөгөөд цаашид циркийн жүжигчин болохоор бэлтгэгдэж байгаа 300-400 орчим хүүхэд байна. Одоогоор эх орондоо байгаа тэдгээр хүүхдүүдийн нэлээд хэсэг нь түр хугацаагаар гадаад улсад гэрээний дагуу ажилладаг ажээ. Түүнчлэн тэд байгууллага, хувь хүмүүсээс санал ирүүлсэн тохиолдолд дотооддоо жуулчны бааз, зочид буудал, шоу хөтөлбөр, цэнгүүнд тоглож байна.

Циркт хүүхдүүд олноороо ажилладаг боловч энэ салбарт ажилладаг хүүхдүүд төдийгүй салбар бүхэлдээ төрийн бодлого, хараа хяналтын гадна байгаа нь бидний анхаарлыг татсан юм. Иймд цирк дэх хүүхдийн хөдөлмөрийн байдалд үнэлгээ хийх, цаашид төрийн зүгээс анхаарах шаардлагатай асуудлуудыг тодорхойлох зорилгоор “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд” судалгааны хүрээнд цирк дэх хүүхдийн хөдөлмөрийн асуудлыг судалсан болно. Ингэхдээ үндсэн асуудлын зэрэгцээ энэ хөдөлмөрийн салшгүй нэг хэсэг болох циркийн бэлтгэл сургуулилт, сургалттай холбоотой зарим асуудлыг авч үзлээ.

Судалгааны мэдээлэл цуглуулахад циркийн зарим дугуйлангийн багш нар, жүжигчид мэдээлэл өгөхөөс татгалзаж байсны зэрэгцээ олон тохиолдолд судалгаанд оролцогчид тодорхой баримт, жишээ дэлгэхээс цааргалж байсныг тэмдэглэх нь зүйтэй бизээ.

Хүүхдүүдийн талаарх ерөнхий мэдээлэл:

Циркийн урлагт 18-аас доош насны 300-400 орчим хүүхэд суралцаж байгаагийн 200 орчим нь мэргэжлээрээ ажилладаг гэж үзэж болно. Түүнчлэн одоогоор бэлтгэгдэж байгаа боловч ажлын санал ирсэн тохиолдолд хүлээн авах боломж, хүсэлтэй хүүхэд ч цөөнгүй байгаа юм. Цирк дэх хүүхдийн хөдөлмөрийг судлахдаа циркийн 12 багш, жүжигчинтэй ганцаарчлан ярилцаж, 38 хүүхдээс санал асуулга авч, ярилцахын зэрэгцээ баримт, тохиолдлыг цуглуулан магадласан болно. Санал асуулгыг идэвхтэй хөдөлмөр эрхэлдэг болон одоогоор зөвхөн бэлтгэл сургуулилт хийдэг хүүхдүүдээс ялгаатай байдлаар боловсруулж авсан бөгөөд хөдөлмөр эрхэлдэг 24, бэлтгэл сургуулилт хийдэг 14 хүүхэд судалгаанд хамрагдсан.

Санал асуулгад оролцсон нийт хүүхдүүдийн 10.5 хувь нь 10 хүртлэх, 36.8 хувь нь 11-14, 50 хувь нь 15-18 настай бөгөөд ажиллаж, ашиг орлого олдог хүүхдүүдийн 50 хувь нь 15-18, 41.6 хувь нь 11-14 настай байна. Эндээс циркийн салбарт идэвхтэй хөдөлмөр эрхэлдэг хүүхдийн дундаж нас нь 14-16 гэж үзэж болно.

Нийт судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн дунд уран нугаралтын чиглэлээр хичээллэдэг хүүхдүүд зонхилж байсан. Тухайлбал, судалгаанд хамрагдсан 38 хүүхдийн 29 нь буюу 76.3 хувь нь уран нугараачид байсан юм. Энэ нь дотоод, гадаадад ч уран нугараач хүүхдүүдэд хөдөлмөрийн эрхлэх боломж илүү тул түүгээр хичээллэдэг хүүхдүүд олон байдагтай холбоотой. Харин гимнастик, жонглёр, цагираг, акробат, хөлөөр шидэгч, тэнцвэрийн төрлүүдээр хичээллэдэг хүүхдүүд 24.7 хувь нь байлаа. Уран нугаралтаар хичээллэдэг хүүхдүүд судалгаанд түлхүү оролцсонтой холбоотойгоор тэдний 94.7 хувь нь охид байв.

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 52.6 хувь нь гэр хороололд, 39.4 хувь нь орон сууцанд амьдарч байна. Түүнчлэн, тэдгээр хүүхдүүдийн 10.5 хувь нь 3 хүртлэх гишүүнтэй өрхөд, 84.2 хувь нь 4-7 гишүүнтэй өрхөд, 2.6 хувь нь 7-гоос дээш гишүүнтэй өрхөд харьяалагдаж байна. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн гэр бүлийн сарын дундаж орлогыг тодруулахад 40.02 хувь нь л өрхийн орлогоо мэдэж байсан юм. Өрхийн дундаж орлогоо тодорхойлсон хүүхдүүдийн 36 хувь нь ар гэрээ сард 100000-200000 төгрөг, 12 хувь нь 200000-300000, 12 хувь нь 300000-400000, 32 хувь нь 400000 төгрөгөөс дээш орлого олдог гэжээ. Циркээр хичээллэдэг хүүхдүүдийн амьдардаг орон сууцны байдал болон өрхийн гишүүдийн тоог сарын дундаж орлоготой харьцуулахад тэдгээр хүүхдүүдийн талаас илүү хувь нь амьжиргааны түвшин доогуур өрхөд хамаарагдаж байна.

Ихэвчлэн аав, ээж, ойр дотныхон нь циркэд ажиллаж байсан хүүхдүүд циркэд суралцаж, энэ чиглэлээр ажиллаж байна. Өөрөөр хэлбэл, циркийн мэргэжил харьцангуй удам дагаж, өвлөгдөж байна. Түүнчлэн, хүүхдийнхээ хүчээр амьдралын нөхцлөө дээшлүүлэхийг хүссэн эцэг, эхүүд ашиг орлого ахиу олох боломжтойг нь бодолцон хүүхдээ циркээр хичээллүүлэх нь олонтаа байна.

... Манай энэ охины ар гэр хэцүүхэн амьдралтай. Нэг хэсэг орон гэргий ч байсан. Гэсэн хэдий ч сарын 20000 төгрөгийн телберийг нь телеед хийхдээ сургалтанд явуулдаг. Заримдаа ээж нь манайд цэвэрлэгээ, туслах ажил хийж хийхдийнхээ сургалтын телберийг телдег. Охин нь гадаадад амжилттай ажлаад ирсний дараа хамар хашааных нь айл хийхдээ манайд авчирч өгсөн.

Циркээр хичээллэдэг буюу энэ салбарт ажилладаг хүүхдүүд ихэвчлэн эцэг, эх насанд хүрэгсдийн хүсэлтээр хичээллэж эхлээд, үзүүлбэрийнхээ нарийн, хүнд элементүүдийг эзэмшиж, орлого олж эхэлмэгцээ өөрсдөө дур сонирхолтой болсон дүр зураг харагдаж байна. Тухайлбал, судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 18.4 хувь нь ээж, аавынхаа хүсэлтээр хичээллэж байгаа гэсэн бол 47.36 хувь нь өөрсдийнхөө сонирхлоор хичээллэж байгаа гэсэн байна. Гэхдээ өөрийн сонирхлоороо энэ урлагаар хичээллэж байгаа гэсэн хүүхдүүдийн 22.22 хувь нь эхлээд ээж, аавын хүсэлтээр циркийн хаалга татсан ч дараа нь өөрөө дуртай болсон гэж хариулжээ. Судалгаанд оролцсон хүүхдүүдийн 28.94 хувь нь ирээдүйд алдартай жүжигчин болохын тулд циркээр хичээллэж байна. Ерөнхийдөө циркээр хичээллэдэг хүүхдүүдийн зорилго нь гадаад улсад ажиллаж, ашиг орлого олох явдал ажээ. Судалгаанд хамрагдсан хүүхдүүд цөм ажилдаа дуртай бөгөөд 94.7 хувь нь цаашид циркийн мэргэжлээрээ ажиллах хүсэлтэй байна.

... Ер нь манай циркчдын дунд боловсролын асуудал хэцүү. Сайхан сайхан жүжигчдийн зарим нь бичиг ёсэг мэдэхгүй гээд бод л доо...

Циркийн хүүхдүүдийн сургуульд хамрагдсан байдал анхаарал татаж байна. Хэдийгээр нийт хүүхдүүдийн 86.8 хувь нь сургуульд суралцаж, 7.8 хувь нь суралцахгүй байгаа ч сургуульд сурдаг хүүхдүүдийн дунд байх ёстой ангидаа

суралцдаггүй хүүхэд цөөнгүй байна. Энэ нь 3-6 сарын хугацаатай гадаад улсад гэрээгээр ажиллахын тулд хүүхдүүд сургуулиасаа чөлөө аваад, буцаж ирэхдээ үргэлжлүүлэн суралцдагтай холбоотой. Хүүхдүүд хичээлээсээ урт хугацааны чөлөө авдаг ч энэ нь гадаад улсад очоод сурдаг зүйл, олдог мөнгөтэй нь харьцуулахад тийм ч их асуудал биш тухай ярьж байна. Ер нь циркээр нэлээдгүй амжилттай хичээллэж байгаа, үзүүлбэр хийх чадвартай хүүхдүүдийн хувьд боловсролын асуудал хоёрдугаар зэрэгт тавигдаж байна. Энэ талаар эцэг эх, багш нарын анхаарал, зүтгэл хангалтгүй байна. Бидний судалгаагаар тогтоогдоогүй ч шинэ үеийн циркийн жүжигчдэд боловсролтой холбоотой тулгамдсан асуудлууд бий ажээ.

Хөдөлмөрийн орчин нөхцөл, хэв шинж, эрсдэл:

Манеж, 5-7 минутын үзүүлбэр, үзэгчдийн алга ташилт, зарим төрөл нь эрсдэлтэй боловч ерөнхийдөө нэр хүндтэй, хялбар, ашиг орлого сайтай ажил... Энэ салбарыг төдийлөн мэдэхгүй хүмүүс циркийн жүжигчний хөдөлмөрийг ихэвчлэн ийм байдлаар төсөөлдөг. Гэвч алга ташилт, алдар хүндийн цаана нөр хичээнгүй хөдөлмөр, байнгын бэлтгэл, сургуулилт, тэсвэр тэвчээр, эрсдэл бий.

Санал асуулгад оролцсон 7 настай уран нугараач охин циркэд ажиллахын сайхныг чадахгүй юмаа сурах, хинд хэцүүг хичээ шавхах, давхралдсан хинд ижилбэр хийх гэж тодорхойлжээ.

Циркийн жүжигчний мэргэжил эзэмшихийн тулд хүүхдүүд ихэвчлэн 6-9 наснаасаа эхлэн 5-6 жилийн хугацаанд, өдөрт 2-4 цагийн бэлтгэл хийх ёстой болдог бөгөөд мэргэжлээ эзэмшсэний дараа ч бэлтгэл сургуулилтаа үргэлжүүлэн хийсээр байдаг нь энэ урлагийн бас нэгэн онцлог шинж юм. Тухайлбал, манай судалгаанд хамрагдсан циркийн салбарт

ажилладаг 24 хүүхдийн 58.3 хувь нь 4-6 жил, 29.1 хувь нь 7-гоос дээш жил циркээр хичээллэж байгаа бол тэдний 50 хувь нь долоо хоногт 15-20 цаг, 8.3 хувь нь 25-30 цаг, 12.5 хувь нь 30-40 цаг ажиллаж, хичээллэж байна. Ерөнхийдөө циркийн салбарт ажилладаг хүүхдүүд долоо хоногт дунджаар 21.8 орчим цаг ажиллаж байгаа нь 13-14 настай тэдний хувьд нэлээдгүй хүнд ачаалал болдог ажээ. Гэхдээ эдгээр нь хүүхдүүдийг эх орондоо, харьцангуй ажлын ачаалал багатай үед нь авсан мэдээлэл бөгөөд гадаад улсад ажиллахад энэ ачаалал 2-3 дахин нэмэгдэх тохиолдол байдаг байна. Уран нугараач охид гадаадад ажиллаж байхдаа зарим тохиолдолд 7-8 удаа ч үзүүлбэр хийдэг нь нуруу халаалттайгаа нийлээд өдөрт 15-16 удаа тоглосонтой ижил хэмжээний ачаалалтай болдог талаар ярьж байна. Энэ мэт ачаалал нь төрөлхийн уян хатан биш нуруутай хүүхдүүдийн хувьд боломжгүй зүйл болдог тул ийм тохиолдолд гагцхүү “нуруу сайтай” охидууд л ямар ч ачааллыг үл харгалзан үзүүлбэрээ авч гардаг байна.

Циркчин хүүхдүүд шөнийн цагаар ажиллаж байгаа нь анхаарал татаж байна. Хэдийгээр хүүхдүүдийн “үнэлэгддэг” ажлын цаг нь үзүүлбэрийн үргэлжлэх хугацаа буюу 6-8 минут байгаа боловч циркийн урлаг нэгэнтээ зугаа цэнгээн, чөлөөт цагийн арга хэмжээ учраас тэд эх орондоо ч, гадаад улсад ч шөнийн цагаар ажиллах болдог.

Энэ нь насанд хүрээгүй хүнийг шөнийн цагаар ажиллуулахыг хориглосон Хөдөлмөрийн тухай хуулийн 110 дугаар зүйлийн 110.2 дэх заалтыг зөрчиж байгаа юм.

Хэдийгээр циркийн нэг төрөл боловч уран нугаралт Монгол ардын урлагийн шинжтэй учраас дотоодын аялал жуулчлалын байгууллагууд нугараач охидыг ажиллуулах нь элбэг байдаг. Зарим тохиолдолд жуулчны баазуудад үзүүлбэр тоглодог хүүхдүүдийг ажлын тодорхой цаг хугацаагүйгээр, жуулчин хүссэн үед өдөр, шөнийн цагийг үл харгалзан тоглуулж байгаа нь хүүхдийн эрх, ашиг сонирхлыг зөрчиж байна.

Уран нугаралтын дугуйлан, сургалтууд сард ойролцоогоор 20000-50000 төгрөгийн төлбөртэй хичээллэж байгаа бөгөөд жүжигчин хүүхдүүд байгууллага, компаниудын хүсэлтээр нэг удаагийн гаралтад 5000-10000 төгрөгийн хөлс, урамшуулал авч ажиллаж байна. 2007 оны 12 дугаар сараас АСА цирк буюу Монгол циркийн жүжигчин хүүхдүүдийн нэг гарааны үнэлгээг 15000 төгрөг болгосон нь дотооддоо нэг удаад авч байгаа хамгийн өндөр үнэлгээ байна. Харин жуулчны бааз, кабаре шоуны газруудад сард 70000-100000 орчим төгрөгийн тогтмол хөлс өгч, нугараач хүүхдүүдийг ажиллуулдаг ажээ.

Цирк, түүний дотор уран нугаралтын дугуйлан, дамжаа, шавь сургалтаар хичээллэдэг хүүхдүүдийг төлөөлж, багш, эцэг, эхийн хооронд гэрээ байгуулагдаж байна. Тухайлбал, манай судалгаанд оролцсон циркээр ажилладаг 24 хүүхдийн 20 нь багштайгаа гэрээ байгуулсан байна. Гэвч энэ гэрээ нь ихэвчлэн сургалттай холбоотой асуудлаар талуудын харилцан эдлэх эрх, үүрэг, сургалтын төлбөрийг зохицуулсан байгаа бөгөөд хүүхдийг гэнэтийн ослын даатгалд хамруулах, эрсдэлтэй нөхцөлд хүүхдийн эрх, эрүүл мэндийг хамгаалах, хариуцлага хүлээх талаар тодорхой заалт тусгагдаагүй байна. Харин Хөгжим бүжгийн коллежийн харъяа Циркийн сургууль сурагчдаа гэнэтийн ослын даатгалд хамруулж, эрсдлээс хамгаалсан байна.

Монгол циркийн хувьд тус Циркийн сургаж, тоглолтондоо оруулдаг 8-16 насны 20 орчим хүүхэд байдаг боловч тэдгээр хүүхдүүдтэй хөдөлмөрийн гэрээ бус хөлсөөр ажиллах гэрээ байгуулан ажиллуулж байна. Гэвч тэдгээр хүүхдүүдийн хийдэг акробат, уран нугаралтын үзүүлбэр нь циркийн үндсэн үзүүлбэр бөгөөд тоглолт бүрт багтдгаараа байнгын шинжтэй ажээ. Одоогийн байдлаар²⁷ тус Циркийн 13 групп гадаад улсад гэрээгээр ажиллаж байгаагийн дотор 18-аас доош насны 3 хүүхэд байна.

Гадаад улсад гэрээгээр ажиллах тохиолдолд хүүхдүүдийг төлөөлөн зуулчлалын болон хөлсөөр ажиллах гэрээг багш нь хийж байна. Харамсалтай нь гэрээ төлөөлөн хийж байгаа хүмүүсийн хууль, эрх зүйн мэдлэг дутмаг, эрсдлээс хамгаалах гэрээний үүргийн талаар эцэг эхчүүд төдийлөн анхаарал тавьдаггүйгээс хүүхэд эрүүл мэндээрээ хохирох тохиолдол олонтаа гардаг байна. Тухайлбал, 2006 онд Монгол циркийн акробатчин хүү БНСУ-д гэрээгээр ажиллаж байхдаа бэхэлгээ муугаас унаж, шилбээрээ гэмтэл авсан байна. Тухайн үедээ ясаа хадуулж, эмчилгээ хийлгэсэн боловч Монголд ирээд бэртэл нь үрэвсэж, идээлжээ. Гэрээнд жүжигчдийн аюулгүй байдлыг хүлээн авагч байгууллага хариуцахаар заасан боловч осол, гэмтэл гарсан үед ямар арга хэмжээ авах, хэдий хэмжээний нөхөн олговор олгогдох талаар тодорхой зохицуулалтгүй байгаагүй ажээ. Гэрээ байгуулах үед хүүгийн

... Тухайн үедээ гэрээнд нь заагаагүй болохоор яаж ч чадахгүй өнгөрсөн. Цаашдаа гэрээ байгуулахдаа их анхааралтай байх хэрэгтэй юм байна лээ. Одоо удахгүй байгуулах гэрээгээ хуулийн талаас нь та нараар харуулнаа

²⁷ 2007 оны 2 дугаар сар

багш, эцэг эх энэ асуудалд төдийлөн анхаарал хандуулаагүй бөгөөд гэмтсэн хүү нөхөн олговор авч, хохирлоо төлүүлж чадаагүй тохиолдол гарсан байна. Түүнчлэн, 1998 онд Норвегт гэрээгээр ажиллаж байсан 16, 17 настай нугараач охид аялан тоглолтоор нэг хотоос нөгөө уруу явж байхдаа машины орж, Э нь гараа хүнд бэртээжээ. Харин гэрээнд аялалын явцад осол, гэмтэл тохиолдвол гэрээлэгч байгууллага ямар хариуцлага хүлээх тухай заалт байгаагүй учраас Э-гийн хохирлыг барагдуулаагүй байна. Э-гийн хоёр гар нь мэдээгүй болсон бөгөөд одоо эх орондоо уран нугаралтын багшаар ажиллаж байна. Гэрээтэй холбоотой энэ мэт хүндрэлтэй асуудлууд цөөнгүй гардаг ажээ.

1992 оноос эхлэн Германы иргэн Тео Крат Монгол уран нугараачдын Европын зах зээлд гаргаж эхэлсэн. Багцаагаар 300-400 орчим хйн энэ шугамаар явсан байх. Нэг ээлжид очсон нугараачдаа Европт зарж байгаад тэд нар нь насанд хирч, биеэ даагаад хинтэй гэрлээд ч юм уу ажлаа хийхээ болихоор дахиад Монголоос ирж хийхдйд авдаг. Саяхан хиртэл Тео Кратыг телеелж, Н гэдэг Монгол эмэгтэй ирж, хийхдидийг шалгаад явсан.

Циркийн хүүхдүүдийн гадаад улс дахь хөдөлмөр эрхлэлт анхаарал татаж байна. Монголын циркчид дэлхийн аль ч тив, улс оронд тоглож байгаа боловч АНУ, ОХУ, Канад, Герман, Итали, Испани, Турк, Тайвань зэрэг улсуудад олноороо, тогтмол шинжтэй тоглож байна. Бидний тооцоогоор 100-120 орчим циркийн жүжигчин хүүхэд гадаад улсад түр буюу урт хугацааны гэрээтэй ажиллаж байна.

1990-ээд оноос эхэн үеэс баруун Европын орнуудад Монголын уран нугаралт нэрд гарахын хамт энэ зах зээлээс ашиг орлого олох сонирхолтой дотоод, гадаадын хувьд хүн байгууллагууд бий болжээ. Тухайбал, Герман улсад Монголын уран нугараачдыг зуучилдаг Тео Крат, Турк улсад зуучлалын үйл ажиллагаа явуулдаг Илхаан Оёүздмер зэрэг гадаадын иргэд энэ чиглэлээр идэвхтэй ажиллаж байна. Түүнчлэн, Монгол улсын нэртэй уран нугараачийн байгуулсан Герман улсын хуулийн этгээд Хоризонте Шоу компани олон улс орны жүжигчдийг Европын шоу бизнест зуучлах үйл ажиллагаа явуулж байна. Мөн, Монгол цирк, циркийн дугуйлан, дамжаа хичээллүүлдэг багш нар ч гадаад улс орны шоу бизнесийн зах зээлд өөрийн жүжигчид, сурагчдаа тоглуулах боломжийг эрэлхийлж байна.

1997-1998 оны үеэс Европт циркийг сонирхогч, үзэгчдийн тоо эрс багассан нь тэр хавийн улс орнуудад үйл ажиллагаа явуулдаг манай циркчдын бизнест ч хүндрэл учруулжээ. Чадвартай жүжигчин л өндөр үнээр борлогддог шоу бизнесийн хууль Монголын циркчдыг ч тойроогүй нь мэдээжийн хэрэг бөгөөд ур чадвартай нь дэлхийд алдартай циркүүдэд гэрээгээр тоглож байхад тэдний хэмжээнд үнэлэгдэж чадахгүй хэсэг нь арга буюу жижиг буудал, цэнгээний газруудад цагаар тоглож, үүнийхээ хирээр эрх, эрх чөлөө нь зөрчигдөж байна.

18-аас доош насны хүүхдүүдтэй гэрээ байгуулж, шоу цэнгүүнд тоглуулахгүй гэсэн ерөнхий шаардлагыг Европын улс орнуудад тавьдаг боловч гадаад паспорт хуурамчаар авах болон өөр бусад арга замаар 12-18 насны хүүхдүүд хөдөлмөр эрхэлсээр байна.

Циркчдийн хөдөлмөрийн үнэлгээ улс орнуудаас хамаарч харилцан адилгүй байна. Тухайлбал, Европт цалин хөлсний түвшин өндөр буюу сард 1200-1300 евро байхад циркчид Тайвань, БНСУ, Сингапур зэрэг Азийн улс орнуудад 610-850 америк долларын цалинтай ажиллаж байна. Европын улс орнуудаас Туркийн зах зээлийн үнэлгээ харьцангуй бага буюу сарын 500-850 орчим америк доллар байна. Гадаадад ажиллах гэрээг зуучлагчаар дамжуулж байгуулсан бол гэрээнд заасан цалингийн 10

хувийг зуучлагчид, 10-20 орчим хувийг багш, дасгалжуулагч буюу зохион байгуулагчид суутгагдаад үлдсэн хувь нь жүжигчинд олгогддог ажээ. Судалгааны дүнд цугларсан мэдээллүүдээс ерөнхийдөө циркийн нэг жүжигчин Европын улс орнуудад амжилттай ажиллаж, гэрээний үүрэг хангалттай биелэгдсэн бол сард 900-950 евро, Азийн орнуудад ажилласан бол сард 300-700 америк долларын орлого олж байгаа гэж дүгнэж болохоор байна.

... Туркын тал цалингаа егөхгүй бид нэлээд хинд байдалд орсон. Тэгээд хин бiрт цалин егөхгүй номерт нь нэг багц iнэлгээ егөхөөр болсон. Харин зарим жiжигчид эд нар ар гэрээ тэжээх iррэггүй хiiхдiiд юм чинь насанд хiрсэн хiмiiсийнх нь цалинг тiрiлж олгоё гээд хэл ам гаргасан.

Судалгаанд оролцсон циркийн багш, дасгалжуулагчид, энэ салбарт ажилладаг хүмүүс насанд хүрсэн болон насанд хүрээгүй циркчдэд цалингийн хувьд ялгаа байдаггүй тухай ярьж байлаа. Харин манай судалгааны хүрээнд насанд хүрсэн жүжигчин, циркчин хүүхдийн цалин хөлсний ялгаатай байдлын талаарх

асуудал гүнзгийрүүлэн судлаагүй болно.

Ази, Европын улс орнуудын цалингийн үнэлгээг хэт бага гэж үзэх хүмүүс байна. Учир нь циркийн жүжигчинд Европт ашиг орлого ихтэй, томоохон казино, усан онгоцон дээр тоглох нь олонтаа бөгөөд тухайн зах зээлийн ханшаар 5000-6000 еврогийн цалин авах боломжтой гэж үзэж байна. Монголын циркчдыг тоглуулдаг гадаадын байгууллагууд тэдний хөдөлмөрийг маш бага үнээр үнэлж, өөрсдөө ашиг орлого их олдог талаар судалгаанд хамрагдсан зарим жүжигчид шүүмжилж байлаа.

Монголын циркчдийг хүлээн авсан гадаадын тал гэрээний үүргээ хангалтгүй биелүүлснээс жүжигчдийн эрх ашиг зөрчигдөх тохиолдол цөөнгүй гарч байна. Хамгийн түгээмэл гардаг зөрчил нь амалсан цалингаа өгөхгүй байх, гэрээнд зааснаас олон цагаар ажиллуулах, гэрээний хугацаандаа эх орон уруу нь буцаахгүй байх зэрэг зөрчлүүд байдаг ажээ. Тухайлбал, 2006 онд БНСУ-д өдөрт 2 удаа, сарын 500\$-ийн хөлстэй гэрээгээр ажиллахаар “Э” багшийн хариуцан авч явсан нугараач хүүхдүүдийг өдөрт 4-6 удаа тоглууж байсан боловч ямар нэг нэмэгдэл хөлс олгоогүй ажээ. Харамсалтай нь тэдний хууль эрх зүйн мэдлэг дутмаг, туслалцаа авч чадаагүйгээгээс энэ талаар гомдол гаргаагүй байна. Энэ мэт жишээ, баримтаас хүлээн авагч тал гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд Монголын циркчид тухайн улсын шүүхээр асуулыг шийдвэрлүүлж, эрхээ хамгаалж чадахгүй байгаа нь харагдаж байна. Энэ нь тэдний хууль, гадаад хэлний мэдлэг хангалтгүй хийгээд санхүүгийн хүндрэлтэй байдагтай холбоотой ажээ. Ялангуяа эрх нь зөрчигдсөн жүжигчин хүүхэд байгаа тохиолдолд эрх, эрх чөлөө, эд хөрөнгө, эрүүл мэндээрээ хохироод үлддэг байна.

...2006 онд Турк уруу гэрээгээр явсан жiжигчдийн цалин хөлсийг егөхгүй удааснаас тэд визний хугацаа хэтэрч, аргагийн эрхэд зочид буудалд тоглож байж визний торгууль, онгоцны тийзээ худалдан авах мөнгө олж эх орондоо иржээ. Ачааны мөнгө байхгийн улмаас техник хэрэгслээ онгоцны буудалд орхисон байна. Зарим уран нугараач охидын эцэг эх өөрсдөө очиж хiiхдээ авчирсан байна. Хiiхдiiдийн ар гэрийнхэн Монгол Улсад суугаа Туркын Элчин сайдын яамны гадаа эсэргiiцлийн жагсаал зохион байгуулжээ. 19 жiжигчин өнөөг хiртэл цалин хөлсөө авч чадаагүй байна.

Үүний зэрэгцээ, алс хол хүний нутагт бага насны хүүхэд гэрээгээр ажиллахад гэр орноо санах, ядрах улмаар бие нь хямарч гэрээгээ биелүүлэх боломжгүй болдог тохиолдлууд ч гарч байна. 2007 оны 3 дугаар сарын 1-ээс 10 дугаар сарыг хүртэл

БНСУ-ын Намьяанжу хотын Монгол хотхонд үндэсний дуу бүжгийн нэгэн хамтлагийн бүрэлдэхүүнд уран нугаралтын үзүүлбэр үзүүлж байсан Н охин ажлын ачаалал, гэрээ санасны улмаас бие нь хямарч, сэтгэлийн гутралд оржээ. Түүнтэй хамтран тоглодог П охин ч удаа дараа олон хоногоор халуурч, дусал хийлгэхэд хүрсэн байна. Н-ийн үс маш их унаж, ядарсны улмаас гэрээний хугацаагаа дуусгах боломжгүй болжээ. Хэдийгээр Н-ийн гэр бүлийнхэн түүнийг авчруулах талаар хамтлагийн удирдлагуудтай тохиролцсон боловч ирүүлэх хугацаандаа охиныг ирүүлээгүй тул тэд энэ асуудлаар Хүүхдийн төлөө үндэсний газарт хандаж, туслалцаа хүсчээ.

Эмэгтэй хүний уян налархай бие, гоо сайхныг үзүүлдэг хийгээд шөнийн цагаар, зугаа, цэнгээний зорилгоор хөдөлмөрлөдөг нөхцөл байдал нь нугараач охидыг бэлгийн мөлжлөг, садар самуунд уруу татагдах, ашиглах эрсдэлд оруулдаг байж болзошгүй байна. Энэ байдал зарим жишээ тохиолдлоос харагдаж байна. Тухайлбал, 6 настайгаасаа уран нугаралтаар хичээллэсэн Б охин 2002 онд 19 настайдаа БНСУ-ын нэгэн шөнийн клубт нугаралтын үзүүлбэр үзүүлэх гэрээ хийжээ. Тэрээр бүжиглэж, нугарч, ширээнд үйлчлэх болсны зэрэгцээ өдөрт нь түгжээтэй хоригдож байжээ. Түүнийг нэгэн Монгол залуу, клубээс оргуулж гаргасан бөгөөд Герман улсад амьдарч байсан хамаатнуудынхаа туслалцаатай эх орондоо эргэн иржээ.

Интернэтийн дурын хайлтын системд Монголын уран нугаралт гэсэн үг оруулж, хайлт хийхэд Түмэндэлгэрийн Энхээ эротик уран нугаралт гэсэн танилцуулга, мэдээлэл <http://myvideo.caucasus.net/comment.php?comment.news.59> сайтаас төвөггүйхэн олдож байна. Хэдийгээр энэ сайтад нэр дурдагдсан нугараачийн хувийн байдлын талаарх мэдээлэл байхгүй боловч энэ мэт жишээ тохиолдлууд уран нугараач охид бэлгийн мөлжлөг, садар самууны сурталчилгаанд ашиглагдах эрсдэлтэй байгааг харуулж байна.

Гадаадын улс орнуудад хөдөлмөр эрхлэх нь дээр дурдсан бэрхшээл, хүндрэлийг дагуулж байгаа боловч ололттой талууд ч байгаа юм. Ялангуяа, гадаадад амжилттай ажиллаж, харьцангуй өндөр ашиг орлого олж, гэр бүлийнхээ амьдралд бодитой дэмжлэг үзүүлж байгаа хүүхдүүд ч цөөнгүй байна. Гадаад, дотоодод хөдөлмөрлөөд олсон мөнгөө ямар байдлаар зарцуулж байгааг нь асуухад судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 47.3 хувь нь өөртөө, 26.3 хувь нь гэртээ, 26.3 хувь нь өөртөө болон гэртээ зарцуулдаг гэсэн бол 10.5 хувь нь хадгалдаг гэж хариулсан байна.

... Энэ охин маань гадаадад ажилласан мөнгөөрөө гэр авч, гэр білийнхнийгээ орох оронтой болгосон. Бас ээждээ цагаан утас авч өгсөн, МУИС-д сурдаг эгчийнхээ сургалтын телберийг хийсэн. Гадаадад ажиллах нь хийхдүүдийн амьдралд сайн талтайг ийгсгэж болохгүй. Одоо манай хийхдүүд Испани, Итали явах асуудал шийдэгдсэн, визээ хилээгээд сууцгааж байна. Энэ охин ч бусартай байгаа.

... Бага сага “чимхэх” зййл байлгий яхав. Жишээ нь улсын циркэд морин дээр акробат иййлдэг Б гэдэг охин бий. Элементидээ бірэн гийцэтгэхгий болохоор багш нь морины ташуураараа шилбэ уруу нь хирээд авдаг. Өөрөө ч тэрэндээ дассан. Одоо шилбэ уруу л чад хийлгээд номерыг нь явуулдаг.

Жижигчин Э-тэй хийсэн ярилцлагаас...

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдээс ажлаа хийж байхдаа хэн нэгний дарамт, шахалтанд өртдөг эсэх хийгээд ямар хүндрэл, бэрхшээл тулгардагийг нь санал асуулгаар тодруулахад тэдний 92.1 хувь нь ямар нэг дарамт, шахалтанд өртдөггүй гэж хариулсан байна. Харин дарамтанд өртдөг гэж хариулсан 4 хүүхэд тус бүр багш, бусад жүжигчид, хамт ажилладаг хүүхдүүдээс дарамт, шахалт үзүүлдэг гэжээ. Хүүхдийг сургах багш нарын

Циркийн сургалтын зарим асуудал:

Бэлтгэл, сургуулилт бол циркийн ажлын салшгүй нэг хэсэг байдаг. Хэдийгээр циркчний үзэгчдийн өмнө зарцуулдаг ажлын цаг маш бага мэт боловч үүний цаана олон цагийн, нөр хичээнгүй бэлтгэл сургуулилт бий. Энэ утгаараа хүүхдийн хөдөлмөрийн талаарх судалгааны хүрээнд циркийн сургалтын асуудал хөндөгдөх шаардлагатай болсон юм. Нөгөө талаас циркийн бэлтгэл, сургуулилт нь түүгээр хичээллэдэг хүүхдүүдийн биеийн хэлбэр галбир, эрүүл мэндийг тодорхойлдог тул хүүхдийн эрхийн талаасаа анхаарал татах асуудал мөн.

Монгол ардын хувьсгалт намын 10 дугаар их хурлын шийдвэрээр 1940 онд Монгол Улсад циркийн сургууль байгуулагджээ. Тухайн үеийн Зөвлөлт холбоот улсын багш нарын сургалтын үр дүнд тус сургуулийн анхны суралцагчид циркийн нарийн төвөгтэй үзүүлбэрүүдийг богино хугацаанд эзэмшиж чадсан бөгөөд сургууль байгуулагдсанаас хойш нэг жилийн дараа Монгол цирк байгуулагджээ. Одоо Ж.Раднаабазарын нэрэмжит Циркийн сургууль БСШУЯ-ны харъяа Хөгжим, бүжгийн коллежийн бүрэлдэхүүнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Циркийн сургууль байгуулагдсан цагаасаа хойш өнөөг хүртэл 900 орчим боловсон хүчнийг бэлтгэн гаргажээ. Тус сургууль нь ерөнхий боловсролын сургуулийн 7 дугаар анги төгсөгчдөөс 25-аас илүүгүй хүүхдүүдийг 4-5 жилд нэг удаа сонгон шалгаруулах замаар элсүүлж байна. Одоогоор Циркийн сургууль жонглёр, гимнастик, тэнцвэр, акробат гэсэн циркийн 4 үндсэн төрлөөр дагнасан болон хосолсон сургалт явуулж байгаа бөгөөд уран нугаралтаар 2 хүүхэд хичээллэж байна. Энэ нь уран нугаралтаас бусад циркийн үндсэн төрлүүдээр албан бус сургалт тэр бүр явагддаггүйтэй холбоотой юм. Учир нь жонглёр, гимнастик, тэнцвэр, акробатын бэлтгэлд тусгай зориулалтын зай талбай, тоног төхөөрөмж шаардлага болдог тул эдгээр чиглэлээр албан бус сургалт явуулах боломж бага байдаг. Иймээс Циркийн сургууль жонглёр, гимнастик, тэнцвэр, акробатын жүжигчдийг бэлтгэн гаргахад голлон анхаарч байна.

Циркийн сургалтыг БСШУЯ-наас мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн шинжтэй гэж үзэн 2007 оноос эхлэн Циркийн сургуулийн сурагчдад сар бүр 45000 тэтгэмж олгож эхэлжээ. Энэ нь сурагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, сургалттай холбоотой зарим зардлыг гаргахад бодитой хувь нэмэр оруулж байна. Харин сүүлийн жилүүдэд циркийн сургуулийн барилга байгууламж, тоног төхөөрөмж, хувцас хэрэгсэл, сургалтын орчин, багш нарын хөдөлмөрийн нөхцлийг сайжруулах талаар төрөөс ямар нэг арга хэмжээ авагдаагүй ажээ. Хэдийгээр циркийн сургуулийн багш нар сургалтын тоног төхөөрөмжөө сайжруулах боломжтой арга хэмжээ авч, зарим нэг хэрэгслийг нөөц боллоцгоондоо түшиглэн шинээр хийж байгаа боловч эдгээр нь сургалт явуулах хангалттай түвшинд хүрч чадахгүй байна. Ялангуяа Циркийн сургуулийн техник, тоног төхөөрөмж, заал, талбайн тохижилт, гэрэлтүүлэг, дулаан хүүхдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөхүйц байгааг төрөөс анхаарах шаардлагатай байна.

Хөгжим бүжгийн коллежийн харъяа Циркийн сургуулийн зэрэгцээ албан бус дугуйлан, дамжаа, шавь сургалтаар циркийн жүжигчид бэлтгэгдэж байна. Гэхдээ эдгээр дугуйлан, дамжаа, шавь сургалтууд нь ихэвчлэн уран нугаралтын чиглэлээр ажилладаг бөгөөд маш цөөн тооны дугуйлан актобатын сургалт явуулдаг ажээ. Энэ нь нэг талаас уран нугаралт циркийн бусад төрөлтэй харьцуулахад зай талбай, тоног төхөөрөмжийн хувьд ч их зүйл шаардагдахгүй, нөгөө талаас гадаад улсын зах зээл дээр Монголын уран нугаралтын үзүүлбэр эрэлт ихтэй байдагтай холбоотой байна. Уран нугаралтын дугуйлан Улаанбаатар хотод төдийгүй Дархан-Уул, Орхон, Дорнод аймгуудад сургалт явуулж байна. Улсын хэмжээнд ойролцоогоор 30 орчим циркийн албан бус сургалтын нэгж үйл ажиллагаа явуулж байна. Тэдгээр дугуйлан, дамжаа, шавь сургалтанд хамгийн багадаа 8-10, зарим тохиолдолд 50 хүртлэх тооны хүүхдүүд хамрагдаж байгаа юм.

Цирк, ялангуяа уран нугаралтын сургалтын нэгдсэн хөтөлбөр, стандарт байхгүйгээс багш болгон өөр, өөрийн арга барилаар сургалт явуулж байна. Биеэ зөв халаах, техник, хэрэгслээ шалгах, аюулгүй байдлаа хангах нь жүжигчний үүрэг тул тэдгээрийг эзэмшүүлэх асуудал циркийн сургалтанд нь зайлшгүй хамрагдах ёстой ажээ. Гэвч зарим дугуйлан, сургалтуудад энэ чиглэлийн хичээл ордоггүй, багш нь тийм арга техникийн талаар хангалттай мэдлэггүй байдаг байна.

Циркийн сургалт явуулах анги танхимд тавигдах зай талбай, аюулгүйн нийтлэг шаардлага байхгүйгээс албан бус сургалт айлын орон гэрээс эхлээд, хаа олдсон өрөө, байранд явагдаж байна. Үүний улмаас хүүхдүүд хэт хүйтэн буюу ариун цэврийн шаардлага хангахгүй орчинд, эсвэл жижиг талбайд олноороо бэлтгэл, сургуулилт хийж байна.

Циркээр хичээллэсэн хүүхдийн бие бялдар бэлтгэл, сургуулилттайсаа хамаарч онцлогтой хөгжиж, төлөвшдөг ажээ. Иймээс ид өсч, биеийн галбир нь тогтож байгаа хүүхдүүд, тэдний эрүүл мэнд, гоо сайханд багшийн үүрэг асар их байдаг. Харин манай улсад циркийн сургалт явуулдаг багш нарт хяналт тавих, эрх, зөвшөөрөл олгох тогтолцоо байхгүйгээс хүүхэд эрүүл мэнд, гоо сайхнаараа хохирох эрсдэл бий болжээ. Хүүхдүүдийн бие, нурууны уян хатан чанар харилцан адилгүй тул хүүхэд бүрт тохирсон арга барилаар заах ёстой, ингэж гэмээ нь эрүүл хүүхдийн эрүүл мэндэд нь сөрөг нөлөөгүй байж чадах талаар мэргэжлийн багш нар ярьж байна. Гэтэл уран нугаралтын сургалтыг дунд сургуулийн 10 жилийн багш, гимнастикийн тамирчид, зарим тохиолдолд хүүхэд нь нугаралтаар хичээллэдэг ээж хүртэл явуулж байгааг хүүхдүүдийг мэргэжлийн нарийн онцлог, мэдрэмжтэй сургадаг гэж үзэхэд бэрх байгаа юм. Мэргэжлийн, мэргэжлийн бус хэн дуртай хүн уран нугаралтын сургалт явуулж байгаагийн үр дагаврыг хүүхэд л амсах билээ. Цаашид циркийн сургалттай холбоотой асуудалд төрийн холбогдох байгууллагууд анхаарал хандуулж, хүүхдийн эрх зөрчигдөх эрсдлээс хамгаалах арга хэмжээ авах шаардлагатай байна.

Циркийн урлаг хүүхдийн бие бялдар, гоо сайхны мэдрэмжийг хөгжүүлж, харьцангуй их ашиг орлого олох, өрхийн амьжиргаагаа дээшлүүлэх боломж бий болгож байгаа боловч сургууль завсардах, бэртэж гэмтэх улмаар эрүүл мэндээрээ хохирох эрсдлийг дагуулж байна. Циркийн жүжигчдийг гадаад, дотоодын зах зээлд зуучилдаг, сургаж бэлтгэдэг бизнесийн нэг төрөл хөгжсөн байгаа боловч төрийн хяналт байхгүй байна. Үүний улмаас хүүхдийн эрх зөрчигдөх, эдийн засгийн болон бэлгийн мөлжлөгт өртөх эрсдэл бий болсон байгааг анхаарах шаардлагатай болжээ. Зөвхөн сургалт төдийгүй циркийн урлаг бүхэлдээ төрийн анхаарлын гадна байна.

Цирк дэх хүүхдийн хөдөлмөрийн талаарх судалгааны ажлыг хийж байх явцад загвар өмсөгч хүүхдүүдтэй холбоотой асуудал сөхөгдөж байлаа. 16-18 насны загвар өмсөгч охидууд циркийн жүжигчин хүүхдүүдийн нэгэн адил гадаад улсад олноороо түр буюу удаан хугацаагаар гэрээгээр ажилладаг бөгөөд ялангуяа Европ, Азийн жижиг цэнгээний газрууд, зочид буудлуудад загвар өмсдөг охидын эрх зөрчигддөг, зарим тохиолдолд бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд өртдөг тухай судалгаанд оролцогчид мэдээлж байв. Энэ асуудлыг цаашид гүнзгийрүүлсэн судлах нь шаардлагатай байна.

5.7. Айлд гэрийн үйлчлэгчээр ажиллаж буй хүүхдүүд

2005 онд МУИС-ийн Хүн ам зүй, сургалт, судалгааны төвөөс “Айлд гэрийн үйлчлэгч хийж байгаа хүүхдүүдийн суурь судалгаа”-г хийсэн. Хэдийгээр гэрийн үйлчлэгчийн хөдөлмөр нь хогийн цэг, зах, худалдааны төвүүд, төмөр замын вокзал зэрэг газруудтай харьцуулахад нөхцлийн хувьд хөнгөвтөр боловч удаан үргэлжилдэг, зарим тохиолдолд ажил олгогчийн дарамт, шахалт, хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй байдаг тул дээрх судалгааны анхаарал татсан зарим мэдээллийг энэхүү тайланд орууллаа.

Түүврийн тархалтын тооцоогоор Улаанбаатар хотын төвийн зургаан дүүрэгт 6148 хүүхэд гэрийн үйлчлэгчийн ажил эрхэлж байгаа бөгөөд тэдний 56.7 хувь нь эрэгтэй, 43.3 хувь нь эмэгтэй байна. Хотод гэрийн үйлчлэгчээр ажиллаж байгаа эрэгтэй хүүхдүүдийн дундаж нас 13 байхад эмэгтэй хүүхдүүдийнх 14 байна. Хүүхдүүдийн 31.1 хувийнх нь эцэг нас барсан, 6.7 хувь нь бүтэн өнчин байгаа бөгөөд тэдний тал орчим хувь нь эцэг, эхтэйгээ хамт амьдардаггүй ажээ. Түүнчлэн, тэдний 12.3 хувь нь өөрийн гэсэн гэр оронгүй байна.

Хотод гэрийн үйлчлэгчээр ажиллаж байгаа 7-15 насны хүүхдүүдийн 25.3 хувь нь сургууль завсардсан ба сургууль завсардсан хүүхдүүдийн тал илүү хувь нь ар гэрийн гачигдлын улмаас ийм байдалд оржээ. Хүүхдүүдийн 8.9 хувь нь уншиж чадахгүй, 11.1 хувь нь бичиж чадахгүй байна. Ажиллах бус сургуульд сурах ёстой гэдгийг 6-11 настай хүүхдүүдийн тал хувь нь 12-14 настай хүүхдүүдийн 25 орчим хувь нь мэдэхгүй байна.

Өрхийн орлогоо нэмэгдүүлэх (25.6 хувь), эцэг, эх, асран хамгаалагч нь ажилгүй (21.1 хувь), бусад туслах (23.3 хувь), өөрийн гэсэн мөнгөтэй болох (18.9 хувь) зэрэг нь хүүхэд ажил хийх үндсэн шалтгаан болж байна.

Гэрийн үйлчлэгчээр ажиллаж байгаа хүүхдүүд ажиллаж байгаа айлдаа хүүхэд, настан асрах, гэр цэвэрлэх, хувцас угаах, хоол хийх, гэр сахих, ус зөөх, түлээ бэлтгэх зэрэг ажлыг голчлон хийдэг ч үүнийхээ хажуугаар зараалд гүйх, тухайн өрхийн ажиллуулдаг лангуу, ТҮЦ-д суух, гар дээрээс худалдаа хийх, зах дээр мод хагалах, шуудайлах, машин харах зэрэг ажлыг хийж байна. Тухайлбал, судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 22.0 орчим хувь нь дээр дурьдсан ажлуудыг нэмэлт байдлаар хийж байгаа ба нэмэлт ажилдаа долоо хоногт дунджаар 3 өдрийг зориулдаг байна.

Хүүхдүүд өдөрт дунджаар 7 хоног бүр ажиллаж байгаа бөгөөд тэдний 30 орчим хувь нь өдөрт 7 ба түүнээс дээш цаг ажиллаж байна. Хамаатан бус айлд ажилладаг хүүхдүүдийн 40 гаруй хувь нь амрах өдөргүйгээр ажилладаг гэжээ. Хүүхдүүдийн 14.4 хувь нь шөнө болон оройн цагаар заримдаа ажиллуулдаг гэсэн бөгөөд тэдний 46.7 хувь нь нийтээр амрах баяр ёслолын үед амардаггүй байна. Харин ч нийтээр амрах баяр ёслолын үеэр амарддаггүй хүүхдүүдийн 66 хувийнх нь ажлын ачаалал тэр өдрүүдэд

ихэсдэг байна. Тэдний тал хувь нь өдөрт 1 удаа, 37 хувь нь 2 удаа халуун хоол идэж байна.

Хүүхдүүдийн 44 хувь нь хийсэн ажлынхаа хөлсийг мөнгөн, 49 хувь нь мөнгөн бус хэлбэрээр авдаг бол 6.7 хувь нь ажлын хөлс авахгүй байна. Ажлын хөлсөө мөнгөөр авдаг хүүхдүүдийн сарын дундаж хөлс 11 000 төгрөг байгаа ажээ.

... Ер нь айлд гэрийн үйлчлэгч хийх их хэцүү байдаг. Хийхэд асрах ч бас гайгүй. Хамгийн хэцүү нь тэд байнга архи ууцгаадаг. Тэгээд тэднийд ирсэн улсууд намайг том биетэй болохоор ч тэрий маш их оролддог.

(УБ, БЗД, Х, 15 настай эмэгтэй)

... Урд нь би еер айлд ажилладаг байсан юм. Гэтэл тэр айлынхан еер айлд ертэй байснаас болж намайг ерийнхөө барьцаанд энэ айлд ажиллуулж байгаа.

(УБ, БЗД, Х, 16 настай эмэгтэй)

Хөдөлмөрийн хөлсөө тогтмол авч чаддаггүйн дээр эрүүл мэнд, сэтгэл санаагаараа хохирох тохиолдол хүүхдүүдийн дунд гарч байна. Ажил олгогч, тэдний гэрийнхэн зодох, айлган сүрдүүлэх, бэлгийн хүчирхийлэлд өртөх, өрийн барьцаанд тавигдах тохиолдол ч гарчээ. Гэрийн үйлчлэгчээр ажилладаг хүүхдүүдэд тулгардаг нийтлэг бэрхшээлийг судалгаанд оролцогчид айлын эзэн/эзэгтэй зоддог гэж 20 хувь, хэл амаар доромжилдог гэж 53.3 хувь, айлган сүрдүүлэг гэж 20.0 хувь нь үзсэн байхад бага хоол өгдөг, бага хөлс өгдөг, хөлс төлбөр төлдөггүй

гэж тус бүр 11.1 хувь нь үзсэн байна. Харин тэдний 1.1 хувь нь бэлгийн хүчирхийлэлд өртөж байжээ.

Хүүхдүүд, тэдний дотроос насаар бага нь ажиллах үедээ илүүтэй өвддөг бөгөөд ихэнхдээ ханиад, толгойн өвчин, хоолой, арьсны тууралтаар өвдөж байсан байна. Түүнчлэн, тэдний 85.6 хувь нь ажил олгогч сайн хооллох, хувцас хунар өгөх зэргээр сайхан харьцдаг гэсэн бол үлдсэн хэсэг нь гэрийн эзэн ашигж загнадаг, зоддог сургуульд явуулдаггүй зэргээр таагүй харьцдаг гэсэн байна.

Судалгаанд хамрагдсан нийт хүүхдүүдийн 90 хувь нь цаашид суралцах сонирхолтой байна. Гэхдээ хүүхдүүдийн дөрөвний гурав нь ажил хийх дур сонирхолтойгоо илэрхийлжээ. (Зүгээр сууснаас дээр, өөрийн гэсэн мөнгөтэй болдог, гэрийнхэндээ тус дэм болдог.) Ажилдаа дургүй гэж хариулсан хүүхдүүд гол төлөв их ядардаг, ажилдаа сонирхолгүй, сургуульд сурч чаддаггүй гэсэн шалгаануудыг нэрлэсэн байна. Ялангуяа 6-11 насны хүүхдүүд ажилдаа их ядардаг гэсэн нь хүүхдийн хийж байгаа ажил, үргэлжлэх хугацаа нь тэдний нас биед тохирохгүй байгааг харуулж байна.

Гэрийн үйлчлэгчээр ажиллаж байгаа хүүхдүүдийн дунд тамхи, согтууруулах ундааны хэрэглээ багагүй байгаа бөгөөд 12-оос дээш настай эрэгтэй, эмэгтэй хүүхдүүдийн 10 гаруй хувь нь тамхи татдаг, 12-14 настай хүүхдүүдийн 11.6 хувь нь согтууруулах ундаа хэрэглэж үзсэн байна. Мөн өвс, хар тамхи, бензин зэргийг мансуурах зорилгоор хэрэглэж үзсэн тохиолдол цөөн боловч байна. Хэрэглэж үзсэн гэж хариулсан охидын тоо хөвгүүдийнхээс олон байгаа нь анхаарал татаж байгаа юм.

5.8. Бүлгийн дүгнэлт

“Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд” судалгаагаар хот суурин газрын албан ба албан бус хэвшил дэх хүүхдийн хөдөлмөрийн асуудлыг судаллаа.

18-аас доош насны хүнийг албан хэвшлийн хориглогдсон ажлын байранд авч ажиллуулахыг таслан зогсоох талаар төрийн байгууллагуудаас арга хэмжээ авч байгаа боловч барилга, тоосго, оёдлын үйлдвэр зочид буудал, зугаа, цэнгээний газруудад хүүхэд хөдөлмөр эрхэлсээр байна.

Улаанбаатар хот, аймгийн төвүүд болон бусад төвлөрсөн сум, суурин газруудын албан бус хэвшилд 6950 орчим хүүхэд хөдөлмөр эрхэлж байгаагийн 4600 орчим нь Улаанбаатар хотод байна. Хөдөлмөрийн орчин, хэв шинжийг нь харгалзан үзвэл Улаанбаатар хотын албан бус салбарт хөдөлмөр эрхлэж буй хүүхдүүдийн 24.3 хувь нь буюу 1200 орчим нь тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхлэж байна.

Хөдөлмөр эрхлэгч хүүхдүүд ажлыг байрны нөхцлийнхөө хүнд болон эрсдэл ихтэйг мэддэг боловч хөдөлмөр хамгааллын хэрэгслийг тэр бүр хэрэглэхгүй байна. Энэ нь хүүхдүүд хөдөлмөр хамгааллын хэрэгслийн ач холбогдлыг ойлгохгүй, анхаарч үзэхгүй байгаатай холбоотой юм. Хөдөлмөр, хамгааллын хэрэгслийн ач холбогдлыг сурталчлан таниулах ажил огт хийгдэхгүй байна.

2007 оны байдлаар 120-140 орчим хүүхэд Улаанчулуутын хогийн цэгт хөдөлмөр эрхэлж байгаа бөгөөд хогийн цэгт хөдөлмөр эрхлэгч хүүхдийн тоо жилээс жилд өсөн нэмэгдэж байна. Хогийн цэгт хөдөлмөр эрхлэгч хүүхдүүд ил задгай, утаа, тоосонцор ихтэй, өмхий үнэртэй, хог цөмрөх, гэнэт гал гарах эрсдэлтэй, ундны усгүй орчинд олон цагаар ажиллаж байна. Тэд тогтмол хооллож чаддаггүй бөгөөд зарим нь хог хаягдлаар ч голоо зогоож байна. Хогийн машинд зүүгдэх, хогонд дарагдсаны улмаас хүүхдүүд эрүүл мэнд, амь насаараа хохирч байгаа боловч эрхээ сэргээлгэж, хохирлоо барагдуулж чадахгүй байна.

Улаанбаатар хотын том, жижиг зах, худалдааны төвүүдэд 1800 орчим хүүхэд байнга буюу түр зуурын шинжтэй хөдөлмөр эрхэлж байна. Тэдний ихэнх нь тоосонцор, дуу чимээ, утаа угаар ихтэй, хорт хийтэй орчинд өвөл, зуны аль ч улиралд ил задгай газарт ажиллаж байгаа нь тэдний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхүйц хэмжээнд байна. Захуудад хүүхдүүд олноороо хийдэг ажлуудаас хүнд ачаа өргөх, зөөх хөдөлмөр тэвчишгүй шинжтэй нь байгаа юм. Түүнчлэн ихэнх хүүхдүүд хэт олон цагаар, амралтгүй ажиллаж, үйлчлүүлэгчид, захын цагдаа, байцаагч нар болон зах дээр ажилладаг бусад хүүхдүүдийн дарамт, шахалтанд өртөж байна.

Төмөр замын өртөө харьцангуй жижиг газар учраас тэнд ажилладаг хүүхдүүдийн ажлын ачаалал, үргэлжлэх хугацаа харьцангуй богино байна. Гэвч зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэт хүнд ачаа өргөж, зөөж байгаа нь хүүхдийн эрүүл мэндэд эрсдэл учруулж байна.

Циркийн урлаг хүүхдийн бие бялдар, гоо сайхны мэдрэмжийг хөгжүүлж, харьцангуй их ашиг орлого олох, өрхийн амьжиргаагаа дээшлүүлэх боломж бий болгож байгаа боловч хүүхэд сургууль завсардах, эрүүл мэндээрээ хохирол, эдийн засгийн болон бэлгийн мөлжлөгт өртөх эрсдэлтэй байна. Циркийн жүжигчин хүүхдүүдийн гадаад улс дахь хөдөлмөр анхаарал татаж байгаа юм. Гадаадад ажиллах гэрээний хугацаа дунджаар 3-6 сар байх бөгөөд энэ хугацаанд хүүхэд сургуульд суралцаж чадахгүй байна. Хүүхдийг төлөөлөн гэрээ байгуулагч этгээдийн хууль, эрх зүйн мэдлэг муу, жүжигчдийг хүлээн авсан тал гэрээний үүргээ биелүүлэхгүйгээс хүүхэд эрүүл мэнд, сэтгэл санаа, эдийн засгийн хувьд хохирох тохиолдол цөөнгүй гарч байна. Циркчин хүүхдүүд шөнийн цагаар ажиллаж байгаа бөгөөд ялангуяа жуулчны баазууд тэднийг ажлын тодорхой цаг хугацаагүйгээр, жуулчин хүссэн үед өдөр, шөнийн цагийг

үл харгалзан тоглуулах тохиолдол гарч байна. Цирк, ялангуяа уран нугаралтын сургалтын хөтөлбөр, стандарт, сургалт явуулах анги танхимд тавигдах байхгүй, мэргэжлийн, мэргэжлийн бус хэн дуртай хүн сургалт явуулж байгаагаас хүүхэд эрүүл мэндээрээ хохирч байна.

Хэдийгээр гэрийн үйлчлэгчийн хөдөлмөр нь хогийн цэг, зах, худалдааны төвүүд, төмөр замын вокзал зэрэг газруудтай харьцуулахад нөхцлийн хувьд хөнгөвтөр боловч удаан үргэлжилдэг, зарим тохиолдолд ажил олгогчийн дарамт, шахалт, хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй байдаг нь судалгааны дүнгээс харагдаж байна. Хөдөлмөрийн хөлсөө тогтмол авч чаддаггүйн дээр эрүүл мэнд, сэтгэл санаагаараа хохирох тохиолдол тэдгээр хүүхдүүдийн дунд гарч байна. Түүнчлэн, гэрийн үйлчлэгч хүүхдүүдийг гэрийн эзэд зодох, айлган сүрдүүлэх, хүчирхийлэх, өрийн барьцаанд тавих тохиолдол гарсан байна. Тэдгээр хүүхдүүд эрхээ хамгаалуулах боломж хязгаарлагдмал байна.



Зургаа. Хөдөө аж ахуйн салбар дахь хүүхдийн хөдөлмөр

6.1. Айлд мал маллаж буй хүүхдийн хөдөлмөр

Монгол орны эдийн засгийн нэг гол салбар болох хөдөө аж ахуйн салбар нь шижилтийн явцад нилээд өвөрмөц шинжтэй болсон. Хөдөө аж ахуйн нэгдлийн малыг хувьчилснаар мал аж ахуй үндсэндээ хувийн хэвшлийн аж ахуй болж, малын тоо толгой эрс өсөж, олон мянган малтай иргэдийн тоо жилээс жилд нэмэгдэх болсон байна. Гэсэн хэдий ч хөдөө орон нутагт мал маллаж байсан цөөн тооны малтай иргэд удаа дараагийн ган, зуд, бусад шалтгаанаар малын тоо нь багасаж бусдын малыг маллаж амьдрахад хүрчээ.

Тариа, ногоо тариалж, мал өсгөн үржүүлж байсан сангийн аж ахуйнууд хувьчлагдаж газар тариалангийн салбарт хувийн жижиг аж ахуйнууд зонхилох болсон байна. Зарим иргэдийн малын тоо толгой эрс өссөнөөр тэдгээр малчид бусдаар малаа маллуулах, ажиллах хүч хөлслөх хэрэгцээ шаардлага урган гарч ирсэн байна. Хөдөө аж ахуйн салбарт гарсан эдгээр өөрчлөлтүүдтэй уялдан мал аж ахуйн салбарт айлд мал маллаж байгаа хүүхдийн хөдөлмөрийн шинэ хэлбэр бий болсон байна.

Улсын хэмжээгээр айлд мал маллаж байгаа хүүхдийн тоог нэгтгэн гаргасан нэгдсэн тоо баримт одоогоор байхгүй байна. Харин зарим байгууллагууд хэсэгчилсэн судалгаа хийхэд айлд мал малладаг хүүхдийн тоо бага бус гарсан байна.

Олон улсын хөдөлмөрийн байгууллага айлд мал маллаж байгаа хүүхдүүдийн суурь судалгааг хийсэн байна. Судалгаанд Өвөрхангай, Ховд, Хөвсгөл гэсэн гурван аймгийн айлд мал маллаж буй 270 хүүхэд хамрагдсан ба тэдний 64.4 хувь нь эрэгтэй, 35.6 хувь нь эмэгтэй, 21.5 хувь нь 6-11 настай, 36.7 хувь нь 12-14 настай, 41.9 хувь нь 15-17 настай хүүхдүүд байсан байна. Эдгээр хүүхдүүдийн дийлэнхи нь өөрийн орон нутагтаа мал маллаж байсан боловч 28.5 хувь нь өөр орон нутагт (өөр суманд), айлд маллаж байжээ.

Мал маллаж буй хүүхдүүдийн 30 хувь нь өвөө, эмээ, ах, эгчийндээ, 41.9 хувь нь бусад хамаатныдаа, 28.1 хувь нь хамаатан бус айлд ажиллаж байна. Насны бүлгийн хувьд, бага буюу 6-11 насны хүүхдүүд эмээ, өвөө, ах, эгчийндээ (43.1 хувь), харин 12-14 насны хүүхдүүдийн хувьд хамаатан бус айлд (34.3 хувь), 15-17 насны хүүхдүүдийн бусад хамаатныдаа ажилладаг гэсэн хувь тус тус хамгийн өндөр байна.

Нийт хүүхдүүдийн 7.8 хувь нь хагас өнчин, 5.6 хувь нь бүтэн өнчин, 270 хүүхдийн 116 нь буюу 43 хувь нь өөрийн гэртээ эцэг, эхтэйгээ хамт амьдардаггүй байна. Айлд мал маллаж байгаа хүүхдүүдийн тухайд тэдний хөдөлмөрийг шударгаар үнэлэх, хүүхдийн хөдөлмөрийг мөлжихгүй байх, хүүхдийг сурч боловсрох, хөгжих эрхийг нь хангах асуудал чухал байна.

Айлд хөлсөөр мал маллаж байгаа хүүхдүүд ихэнх тохиолдолд ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн болон ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ хийдэггүй, эцэг эхтэй нь хөдөлмөрийн хөлс, нөхцлийнх нь талаар урьдчилан тохиролцож бичгийн гэрээ байгуулдаггүй ихэвчлэн аман хэлбэрээр мал маллуулагчийн тавьсан болзлоор хөдөлмөрлөдөг болох нь харагдаж байна. Үүнээс шалтгаалан хүүхдүүд хохирох, хөдөлмөрөө мөлжүүлэх, эрх ашиг нь зөрчигдөх явдал гарсаар байна.

...1998 оны 3 дугаар сарын сїлчээр Говь-Алтай аймгийн Цогт сумын Баянтоорой багийн иргэн ."С"-ийн хїї 16 настай "У"-г тус сумын мянгат малчин "С" Єверхангай хїртэл малаа туулгуулан хїргїлээд 10 ямаа хелсэнд нь єгч 12 сарын эхээр зардлыг нь дааж буцаан явуулна, гэж тохиролцон авч явсан байна.Малчин "С"-ийнх Єверхангайд ирээгїй Дархан-Уул аймагт шилжин ирсэн ба хїїхдийн ар гэр сураг гаргах гээд чадахгїй байсан байна. Гэтэл тэрээр ямарч сураггїй болж У-г тохиролцсон хугацаандаа буцаан явуулахгїй 4 жил 7 сар малаа маллуулж албадан хеделмер хийлгэж, байнга зодож, дарамталж байсан байна. . Іїнийг херш айлынхан нь мэдэж хотоос ирсэн хїмїїстэй хамт зугтаалган 2003 онд эгчийнд нь хїргэж єгчээ. Тэд ХЭІК-т хандаж болсон явдлыг шалгаж хохирлыг нь гаргуулж єгсєн байна. Энэ хугацаанд ар гэрт ямарч мэдээлэл єгєегїй, ар гэрийнхэн нь эрж сурсан боловч ямарч мэдээлэл авч чадаагїй байсан байна.

Нийгмийн хөгжлийн төвийн зөвлөх нэгжээс Өвөрхангай, Ховд аймгийн 12 сумын 291 малчин хүүхдийн дунд явуулсан судалгаанаас харахад айлд мал маллаж буй хүүхдүүдийн 72.8 хувь нь сургууль завсардсан эсвэл огт сургуульд сураагүй байжээ. Тэдний 87.6 хувь нь өөрийн сонирхлоороо бус амьдралын гачаалаас, ах дүүстээ туслах, өөрийн малаа маллах зэрэг шалтгааны улмаас мал маллах болсон байна. Эдгээр хүүхдүүдийн 45 хувь нь цаашид суралцах сонирхолтой байгаа бөгөөд 9-12 насны хүүхдүүд сургуульд сурах, харин 13-16 насны хүүхдүүд голдуу явуулын багшийн тусламжтайгаар, эсвэл зайны сургалтаар, бие дааж суралцах сонирхолтой байжээ. Үүнээс харахад хүүхэд айлд мал малах хөдөлмөр эрхлэх нь сурч боловсрох ялангуяа суурь боловсрол эзэмших эрхэд сөргөөр нөлөөлж байна. Судалгааны явцад айлд мал маллаж буй зарим хүүхдийн эрх ноцтой зөрчигдсөн, амь насаараа хохирсон тохиолдол ч бүртгэгджээ.

Түүнчлэн, Улаанбаатар хотод ам долуулаа амьдарч байсан 16 настай "Г" амьдрахын эрхээр сургуулиасаа гарч Сэлэнгэ аймгийн Зүүнхараа суманд малчин М-ийнд 5 жилийн хугацаатай мал маллахаар очиж хонио хариулж явахад нь хонь руу нь чоно орж, малыг нь чоно барьж тэрээр өөрийгөө боймолж нас баржээ. Энэ мэтээр ядуу айл өрхийн хүүхдүүд ямарч үнээр хамаагүй, ямарч хяналтгүйгээр хөдөлмөр эрхэлж эрх ашиг нь хохирч байна.

Эдгээр баримт жишээ нь мал аж ахуйн салбарт гарч буй хүүхдийн хөдөлмөртэй холбоотой төр засгийн байгууллагаас ялангуяа орон нутгийн засаг захиргааны байгууллагаас анхаарах ёстой асуудлууд яах аргагүй мөн.

Өөр айлд мал маллаж хөдөлмөрлөж байгаа хүүхдүүд эцэг, эх,гэр орноо санах, өлсөх, даарах, халууцах, түүнчлэн зодуулах, загнуулах, айх, ажлын ачаалал хэт ихээс ядрах, өвдөх, амиа алдах, охидын хувьд гэрийн эзэд архи уун дарамтлах, бэлгийн дарамтанд өртөх тохиолдол тодорхой хэмжээгээр байгаа болохыг судалгаанд тэмдэглэгдсэн байна. Айлд мал маллаж буй хүүхдүүдийн 50 гаруй хувь нь хоногт 8-10 цагаар ажилладаг зарим тохиолдолд үүнээс ч илүү цагаар ажилладаг, мал төллүүлэх, алдсан мал хайх, салхи шуурганд хөөгдөх, цас бороонд норох, даарах, олон цагаар хоол ундгүй явах, өлсөх, цангах зэрэг хүнд нөхцөл байдлууд тохиолддог тул өөрсдийнхөө хөдөлмөрийг хүнд гэж тодорхойлсон байна. Иймээс айлд мал маллаж буй хүүхдийн хөдөлмөрийг ялангуяа, бага насны буюу суурь боловсрол эзэмших насны хүүхдийн хөдөлмөрийг хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрт хамруулж, хориглох, мал аж ахуйн салбар дахь хүүхдийн хөдөлмөр эрхлэлтэнд орон нутгийн засаг захиргааны байгууллагаас тавих хяналтыг сайжруулах, орон нутагтаа байнга хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

6.2. Хурдан морь унаач хүүхдийн хөдөлмөр

Монгол орон эрт дээр үеэс эхлэн эрийн гурван наадам хийж баярлаж цэнгэдэг өвөрмөц зан заншил, уламжлалтай орон юм. Эрийн гурван наадмын нэг төрөл болох хурдан

морийг бага насны хүүхдүүдээрээ унуулж уралдуулдаг нь нэг талаас бахархалтай ч нөгөө талаас нь ялангуяа, хүүхдийн аюулгүй байдал талаас нь харахад ихээхэн эрсдэлтэй, сэтгэл түгшээсэн асуудал болоод байна.

Сүүлийн жилүүдэд хурдан морины уралдаан нь зөвхөн үндэсний баяр наадмаар хязгаарлагдахаа больж, хурдан морины уралдааныг өвөл зунгүй, маш олон шалтгаанаар зохион байгуулж, зарим талаар морины уралдаан нь бизнесийн шинжтэй болж, хурдан морь унаж уралдуулдаг хүүхдийн тоо өсөх болсон нь хурдан морь унаач хүүхдүүдийн аюулгүй байдал, эрх ашгийг ярихаас өөр аргагүйд хүргэсэн байна. Засгийн газраас ч энэ асуудалд анхаарлаа хандуулж, Баяр наадмын тухай хууль гаргаж, хурдан морины уралдааны дүрмийг Засгийн газрын тогтоолоор баталж мөрдүүлж, 7-оос доош насны хүүхдээр хурдан морь унуулахыг хориглож, хүүхдүүдийг даатгалд хамруулж, хамгаалалтын хувцас өмсүүлдэг болгосон нь хүүхдийн эрхийн чиглэлээр хийсэн зарчмын ач холбогдолтой арга хэмжээ болсныг үгүйсгэх аргагүй.

2007 онд Хүний эрхийн Үндэсний Комисс, Хүүхдийн төлөө үндэсний газраас хийсэн тооцоогоор улсын хэмжээнд хурдан морь унадаг 27600 орчим хүүхэд байдаг гэсэн тооцоо гарчээ. Эдгээр хурдан морь унаач хүүхдүүд давхардсан тоогоор 150.0 орчим удаа морин уралдаанд оролцдог байна. Хурдан морины бэлтгэл үе шат болох үсэргээний тоог нэмбэл энэ нь хэдэн арав дахин өснө. Хурдан морины уралдаанд бэлтгэх үе шат ч ихээхэн урт удаан хугацаанд үргэлжлэх болсон байна. Жилд олон арван том том уралдаан зохион байгуулагддаг учраас дахиад л дараагийн уралдаанд бэлтгэж, зарим морины эзэд, уяачид нийлж уяачдын отог бий болгож жилийн турш ажиллуулах болжээ. Иймээс хурдан морины уралдаанд болон оролцох явцад хүүхдүүд ихээхэн хүч, хөдөлмөр, цаг зарцуулдаг болох нь тодорхой байна

Үүний зэрэгцээгээр хурдан морины уралдаанд морь унаж буй хүүхдийн тухайд нэг дүгээрт хүүхдийн амь нас, эрүүл мэнд аюулгүй байдлын тухай асуудал, хоёрдугаарт хүүхдийн хөдөлмөрийн хөлс үнэлгээний тухай асуудал онцгой анхаарал хандуулах асуудал болсоор байна Хурдан морины уралдаан нь унаач хүүхдийн амь нас, эрүүл мэндэд аюул занал учруулахгүй гэсэн баталгаа байхгүй байна. Зарим хүмүүс хурдан морь уралдах нь харин ч хүүхдэд бие бялдрын хүмүүжил олгодог, хүүхдийг хэрсүүжүүлдэг гэж үздэг хэдий ч энэ үзэл бодлыг хүлээн зөвшөөрөх ямарч боломжгүйг баримт судалгаа харуулж байна. Хурдан морь унаач хүүхдүүд морь уралдах явцдаа мориноосоо унаж амь насаа алдсан, бие эрхтэндээ гэмтэл, согог авсан тохиолдол багагүй гарсаар байна.

Морь уралдах явцдаа мориноосоо унаж амь насаа алдсан харамсалтай тохиолдол бүрэн биш судалгаагаар 1996 оноос хойш 18 удаа бүртгэгдсэн байна. Эдгээр 18 тохиолдлын хоёроос бусад нь 2000 онд гарсан ба хамгийн их нь 2004 онд 4, 2005 онд 5 тохиолдол бүртгэгдсэн байна. 2005 оны 2 дугаар сарын 18-нд Сүхбаатар аймгийн Сүхбаатар суманд цасан шуургатай өдөр морин уралдаан зохион байгуулж, морь уралдуулж байсан 13 настай хүүхэд морь нь хадуурч, шуурганд төөрч, мориноосоо унаж, хөлдөж осолдсоныг маргааш нь олсон. 2006 оны 2 дугаар сарын 6-нд буюу шинийн 8-ны өдөр Сүхбаатар аймгийн Асгат суманд хурдан морины уралдаан зохион байгуулж, их насны морь унахдаа унаж бэртсэн хүүхдийг эцэг нь албадаж соёолон насны морь дахин унуулснаас хүүхэд уралдааны замд ухаан алдаж мориноосоо унаж эрсэдсэн, 2007 оны 7 дугаар сарын эхээр Сонгинохайрхан дүүргийн Өлзийт хороололд болсон уралдааны үеэр 12 настай мориноосоо унаж тархины хүнд гэмтэл авч эрсэдсэн харамсмаар баримтууд цөөн биш байна. Үүний зэрэгцээгээр мориноосоо унаж бие эрхтэндээ гэмтэл авсан, хөгжлийн бэрхшээлтэй болсон зэрэг тохиолдол харьцангуй олон гардаг байна.

2006 онд тус Комиссоос хийсэн тойм судалгаагаар сүүлийн 3 жилд (2004-2006 онуудад) 206 хүүхэд морин уралдааны явцад мориноосоо унаж бие эрхтэндээ гэмтэл, бэртэл авсан гэж гарсан байна. Тэдний 39.8 хувь нь хөнгөн, 31.0 хувь нь хүндэвтэр, 20.8 хувь нь хүнд гэмтэл авсан байна. Хурдан мориноос унасан хүүхдүүд нь ихэвчлэн гар, хөл, тархи толгой, эгмэндээ гэмтэл бэртэл авдаг байна. Хүүхдэд учирсан гэмтэл бэртлийн 40.3 хувь нь гар, эгэм, мөрөндөө, 29.8 хувь нь тархи толгойндоо, 24.1 хувь нь хөл тулгуур эрхтэндээ гэмтэл авсан байна. Бэртэл гэмтэл авсан 206 хүүхдийн 91.8 хувь нь уралдааны үед, харин 9.2 хувь нь сунгааны үед мориноосоо унаж бэртэл гэмтэл авсан байна.

Гэмтэл согог сэргээн засалтын үндэсний төвийн судалгаагаар 2003-2007 онд нийт 220123 хүн эмнэлгийн тусламж авсан байна. Эдгээрийн 816 нь мориноос унаж гэмтэл авсан хүүхдүүд байсан ба энэ нь нийт тусламж авсан хүмүүсийн 0.3 хувийг эзэлж байна гэж гарчээ.

Хурдан морь унах явцдаа мориноосоо унаж, эрүүл мэнд нь ноцтой хохирч, хөгжлийн бэрхшээлтэй болсон баримт жишээ цөөнгүй байна. Тухайлбал, Өвөрхангай аймагт 2004 онд зохион байгуулагдсан уралдаанд 12 настай эмэгтэй хүүхэд мориноосоо унаж, түнх, булууны яс нь хугарч, хөлгүй болж, байнгын тахир дутуу болсон бөгөөд эмчилгээний зардал байхгүйгээс гадаадад явж эмчлүүлж чадахгүй болсон.

Төв аймагт 2005 онд их насны морины уралдаанд 8 настай хүүхэд мориноосоо унаж, тархи нуруундаа гэмтэл авч суумгай болсон, мөн дааганы уралдаанд 10 настай эрэгтэй хүүхэд дааганаасаа унаж, тархиндаа мэс засал хийлгэж явж чадахгүй болсон, 2006 оны 2 дугаар сард Говьсүмбэр аймгийн Сүмбэр суманд их нас, соёлон уралдуулсан ба энэ уралдааны явцад 2 дугаар ангийн хүүхэд хөлөө хөлдөөж, зогсож чадахаа больсон, 2006 оны 2 дугаар сарын эхээр уяачдын холбооны баярын үеэр 30 орчим хэмийн хүйтэнтэй байхад уралдаан зохион байгуулж, олон хүүхэд хөл, гар, хацраа хөлдөөсөн тухай баримт мэдээлэл байна.

2005 онд холбогдох байгууллагууд хамтарч хурдан морь унаач хүүхдийн үндэсний чуулган зохион байгуулж, тэдний дунд санал асуулга явуулж, эрүүл мэндийн үзлэгт хамруулсан байна. Үндэсний чуулганд оролцсон 120 орчим хүүхдэд эмнэлгийн үзлэг хийхэд 30 гаруй хувь нь бөөрний үрэвсэлтэй, 20.0 хувь нь элэгний үрэвсэлтэй, ихэнхи нь нүүрэндээ шарх сорвитой байсан ба, санал асуулганд хамрагдсан оролцсон 59 хүүхдийн 33.8 хувь нь морь уралдаж байхдаа мориноосоо унаж байсан гэж, 10.1 хувь нь бэртэл гэмтэл авч байсан гэж, 38.9 хувь нь өвлийн улиралд морь уралдах явцдаа хөл, гар, нүүрээ хөлдөөж хайруулж байсан гэж, 28.9 хувь нь хурдан морь уралдахад ядардаг гэж, 10 гаруй хувь нь хурдан морь унах үед айдас төрдөг гэж тус тус хариулсан байна. Эдгээр тоо, баримт мэдээллүүд нь хурдан морь унаач хүүхдүүд нь бэртэж гэмтэх, амь нас, эрүүл мэндээрээ хохирох эрсдэл дагуулж, аюул занал учруулж байдгийг бэлхнээ харуулж байна.

Засгийн газрын 2005 оны 119 дүгээр тогтоолоор батлагдсан “Хурдан морины уралдааны дүрэм” нь зөвхөн Үндэсний их баяр наадам болон Засгийн газрын шийдвэрээр зохион байгуулж буй морин уралдаанд хамаарч бусад уралдааны хувьд хуулийн хүчин төгөлдөр бус байна.

Энэхүү дүрмээр хурдан морь унаач хүүхдүүд нь 7-оос дээш настай байх ба тусгай зориулалтын хамгаалалтын хувцас, хэрэгсэл (малгай, цээживч, өвдөг, тохойны хамгаалалт, хамгаалалт бүхий дөрөөтэй эмээл)-ээр хангагдаж, эрүүл мэндийн болон

ослын даатгалд даатгуулсан, эрүүл мэндийн үзлэгт орсон байх ёстой гэж зохицуулсан боловч энэ журам нь газар дээрээ төдийлөн сайн хэрэгжихгүй байна. Ялангуяа, энэ асуудал хөдөө орон нутагт ор нэрийн төдий байна.

Хамгаалалтын хувцас хэмээн эдгээр зүйлүүдийг дүрэмд нэрлэсэн ч тэдгээр хувцас нь ямар загвар, стандарт, чанар, хэмжээтэй байх нь тодорхой биш байгаа учраас ямар зүйлийг хамгаалалтын хувцас гэж үзэх нь ч хүндрэлтэй байна. Иймд хамгаалалтын хувцасны талаар судалгаа явуулж, ямар төрлийн, ямар үзүүлэлттэй хамгаалалтын хувцас хэрэглэхийг ч нарийвчлан тогтоох хэрэгтэй. Сүүлийн жилүүдэд дотоодын үйлдвэрлэгчид өөрсдөө санаачлага гаргаж, эмээл, дөрөө, малгай зэрэг зүйлийг хийж, гаднаас зарим хэрэглэлийг оруулж ирж байгаа боловч үнийн хувьд харьцангуй өндөр байна. Иймд хамгаалалтын хувцас үйлдвэрлэх, нийлүүлэх асуудлыг төрөөс дэмжих хөгжүүлэх асуудал шаардлагатай байна.

Хурдан морь унаач хүүхдийн эрхтэй холбогдон яригдах нэг асуудал нь тэдний хөдөлмөрийг үнэлэх, хөлс олгох асуудал мөн. Дээр дурьдсан дүрэмд хурдан моринд олгох бай шагналын 20-иос дээш хувийг унаач хүүхдэд олгоно гэж заасан байна. Харин уралдаанд оролцсон морьдын 30 хүртэл хувийг барьж бай шагнал олгодог байна. Гэтэл хацраа сайртаж, бөгсөө холготол морь уралдуулаад морь нь барианд ороогүй хүүхдүүд яах вэ тэдний хохь болох уу гэсэн асуудал ч гарч ирж байна. Энэ мэтээр хурдан морины хүүхдийн хөдөлмөрийг тойрсон олон асуудал хүүхдийн эрхийн үүднээс зөв шийдлээ хүлээсээр байна.

Хурдан морь унаач хүүхэд нь амь нас, эрүүл мэндээрээ хохирох бодит эрсдэл дагуулсан, уг сурвалж нь баяр цэнгээний гаралтай, тодорхой хэмжээний цаг хугацаа зарцуулдаг, хөдөө орон нутгийн хүүхдийн хувьд нийтлэг шинж чанартай, хөдөлмөрийн хөлс, хөдөлмөр хамгаалал, эрх зүйн талаар бүрэн зохицуулагдаагүй байгаа өнөөгийн нөхцөлд энэхүү ажлыг хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрт хамруулах үндэстэй хэмээн үзэж байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Долоо. Нэгдсэн санал, зөвлөмж.

1. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг үл тэвчих, тэдгээрийг нэн даруй устгах, хориглох, тэмцэх талаар нэгдсэн ойлголт төлөвшүүлэх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх;
2. Хүүхдийн хөдөлмөрийн асуудлаарх олон улсын гэрээ, конвенц болон үндэсний хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтэд үнэлгээ хийж цаашид авах арга хэмжээний стратегийг тодорхойлох;
3. Хөдөлмөр эрхэлж буй, янз бүрийн эрсдэлд байгаа хүүхдүүдийн санал, бодолд нийцүүлэн, тэдний нөхцөл байдлыг сайжруулахад чиглэсэн үндэсний хэмжээний бодлого, цогцолбор арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
4. Хүүхдийн хөдөлмөр, түүний тэвчишгүй хэлбэрүүдийг устгах талаар бодлого, эрх зүйн орчны шинэчлэлт хийх, хөдөлмөр зохицуулалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох;
5. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгахад чиглэсэн нөлөөллийн стратегийг боловсруулан энэ чиглэлээр байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх;
6. "Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг хориглох болон устгах тухай" Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 182-р конвенцийг хэрэгжүүлж, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн жагсаалтыг шинэчлэн баталж гаргах;
7. Хүүхдийн хөдөлмөрийн жагсаалтыг үндэслэн тийм хэлбэрийн хөдөлмөр байгаа газрыг тодохойлж, түүнийг устгах, урьдчилан сэргийлэх хөтөлбөр төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх;
8. Конвенцийн 3 дугаар зүйлийн "а", "б", "в" хэсэгт заасан хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг Эрүүгийн хууль тогтоомжид бүрэн тусгах, Эрүүгийн хуулийн зарим зүйл ангийг илтгэлд дурьдсан үндэслэлээр өөрчлөх;
9. Хүүхэд худалдаалах, худалдан авах, хүүхдийг бэлгийн мөлжлөг, садар самууны үйлдвэрлэл, сурталчилгаанд ашиглах, хүүхдийн хөдөлмөрийг мөлжих гэмт хэрэгтэй тэмцэх, энэ талаар гарсан төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулж, энэ төрлийн гэмт хэргийг мөрдөх, шалгах, шийдвэрлэх чадавхийг дээшлүүлж, холбогдох төрийн байгууллагуудын ажилтнуудыг чадавхжуулах, сургах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
10. Насанд хүрээгүй хүүхдийг хил дамжуулан худалдаалах, бэлгийн мөлжлөгт ашиглагдахаас урьдчилан сэргийлэх үүднээс гадаадын иргэдэд хүүхэд үрчлүүлэх журам, дүрмийг хянан үзэж, гадаадад үрчлэгдсэн хүүхдийн эрхийн хэрэгжилтэнд тавих хяналтыг сайжруулах;
11. Худалдаалагдах, гэмт хэргийн золиос болох магадлал өндөртэй хараа хяналтгүй байгаа хүүхдийн бүртгэл судалгааг боловсронгуй болгох, хөдөлгөөнд нь хяналт тавих тогтолцоог бий болгож, гадагшаа зорчиж буй хүүхдүүд эргэн ирж буй

- эсэхэд дүн шинжилгээ хийж, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах,
12. Улсын хэмжээнд хүүхдийн хөдөлмөрийн асуудлаар нэгдсэн судалгаа явуулж, хүүхэд тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхлэхэд хүргэж буй шалтгаан нөхцлийг тогтоож, түүнийг арилгах арга хэмжээ авах, тухайн орон нутагт дахь хүүхдийн хөдөлмөрийн асуудлыг судлан үзэж, хүүхдийг тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөрөөс ангижруулах орон нутгийн засаг захиргааны байгууллагын үүрэг хариуцлагыг дээшлүүлэх;
 13. Хүүхдүүд нь тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхэлж буй ядуу, нэн ядуу өрхийн насанд хүрсэн гишүүдийг ажлын байраар хангах, төсөл хөтөлбөрт хамруулах замаар өрхийн орлогыг нэмэгдүүлж, хүүхдүүдийг тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөрөөс хөндийрүүлэх;
 14. Хүүхдийн хөдөлмөрийн ялангуяа, тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөрийн талаарх олон улсын болон дотоодын хууль тогтоомжийн заалт, хүүхдийн хөдөлмөрийн сөрөг үр дагавар, хор уршгийн талаар эцэг, эхчүүд, олон нийтэд чиглэсэн сургалт сурталчилгааны ажлыг сайтар зохион байгуулж, тэдний хүүхдийн хөдөлмөрт хандах хандлагыг өөрчлөх;
 15. Уул уурхайн албан болон албан бус салбарт алт, жонш, нүүрс олборлох, хог цуглуулах ажилд хүүхэд хөдөлмөрлөх явдлыг нэн даруй хориглож, тэнд ажиллаж буй хүүхдүүдийг тухайн хөдөлмөрөөс хөндийрүүлэх, сургуульд хамруулах арга хэмжээ авч, хүүхдээрээ ийм төрлийн хөдөлмөр эрхлүүлсэн эцэг, эхэд нөлөөлж, хариуцлага тооцох тогтолцоог бий болгох;
 16. Хот суурин газарт хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдийг хөдөлмөрөөс хөндийрүүлэх, албан болон албан бус сургалтанд хамруулах, эрх ашгийг нь хамгаалах, сургалт сурталчилгааны чиглэлээр ажиллаж байгаа иргэд, төрийн бус байгууллагууд, төсөл хөтөлбөрүүдийг дэмжиж хамтарч ажиллах;
 17. 14-өөс доош настай хүүхэд зах, төмөр замын вокзалуудад хүнд ачаа, өргөх, зөөх хөдөлмөр эрхлэхийг таслан зогсоох зорилгоор эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, 14-өөс доош настай хүүхдийг хүнд хөдөлмөр эрхлүүлсэн эцэг эх, асран хамгаалагчид бусад хүмүүст тооцох хариуцлагыг чангатгах, сурталчилгааны өргөн хүрээтэй арга хэмжээ зохион байгуулах;
 18. Урлагийн салбарт ялангуяа, цирк /уран нугаралт, акробат/, хувцас загварын чиглэлээр хүүхдүүдийн дунд сургалт явуулж, тэднийг ашиглан орлого олж буй үйл ажиллагаанд анхаарч, сургалт явуулах, үзүүлбэр үзүүлэх зөвшөөрөл олгоход төрийн зүгээс тавих хяналтыг сайжруулж, хүүхдийн хөдөлмөрийг мөлжих, хүүхдийн амь нас, эрүүл мэндэд сөрөг үр дагавар гарахаас урьдчилан сэргийлэх;
 19. Циркийн албан бус сургалтанд анхаарал хандуулж, сургалтын хөтөлбөр, байр, багшид тавигдах нийтлэг шаардлага, стандартыг боловсруулж, хэрэгжилтэнд нь хяналт тавих;
 20. Бага насны буюу суурь боловсрол эзэмших насны хүүхдүүдийг айлд мал маллуулах, гэрийн үйлчлэгчээр ажиллуулахыг хориглож, бага насны хүүхдийг хөдөлмөрлүүлж буй эзэдтэй хариуцлага тооцдог болох,

21. Хурдан морины хүүхдийн хөдөлмөрийг тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөрт хамруулах эсэхийг УИХ-аар хэлэлцэн шийдвэрлэж, хэрвээ ийм төрлийн хөдөлмөрт хамруулах боломжгүй гэж үзвэл хурдан морины уралдааны тухай асуудлыг хуулиаар зохицуулж, хурдан морь унах хүүхдийн насны хязгаарыг 9-өөс доошгүй байхаар тогтоох, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаанд нь тавих шаардлагыг өндөржүүлж, хөдөлмөрийг нь шударгаар үнэлдэг зохицуулалтыг бий болгох зэрэг болно.



НОМ ЗҮЙ

Олон улсын гэрээ, дотоодын хууль эрхзүйн актууд:

1. Аж үйлдвэрийн салбарт ажилд авах насны доод хязгаарын тухай Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын 59 дүгээр конвенц 1937 он
2. Газар дор болон уурхайд ажиллагсдын насны доод хязгаарын тухай Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 123 дугаар конвенц 1965 он
3. Хүүхдийн эрхийн тухай конвенц 1989 он
4. Хүүхдийг хамгаалах болон улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай конвенц 1993 он
5. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг нэн даруй устгах, хориглох тухай Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 182 дугаар конвенц 1999 он
6. Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн нэмэлт протокол 1999 он
7. Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын 138 дугаар конвенц 1973 он
8. Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенцийн нэмэлт протокол 2000 он
9. Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцийн нэмэлт протокол 2000 он
10. Хөдөлмөрийн тухай хууль 1999 он
11. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль 1996 он
12. Монгол улсын эрүүгийн хууль 2002 он
13. УИХ-аас баталсан “Төрөөс хүн амын талаар баримтлах бодлого” 2004 он
14. УИХ-аас баталсан “Төрөөс албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого” 2006 он
15. Монгол Улсын Засгийн газрын 254 дүгээр хавсралт 2002 он
16. Монгол Улсын Засгийн газрын 3 ба 4 дүгээр тайлан илтгэл 2007 он

Судалгааны тайлан:

17. Өвөрхангай аймгийн Статистикийн эмхэтгэл 2005 он
18. МБХАН, “Монгол дахь сургууль завсардалтын судалгаа” тайлан 2006 он
19. ХАССТ, “Албан бусаар алт, жонш олборлож байгаа насанд хүрэгчдийн суурь судалгаа” 2006 он
20. Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилт Үндэсний 2 дахь илтгэл 2007 он
21. ХАССТ, Улаанбаатар хотын хог хаягдлын судалгааны тайлан

22. Монголын эмэгтэйчүүдийн сан, МУИС-ын Сэтгүүлзүйн тэнхим, Хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр эмэгтэйчүүдийн эрхийн талаар гарч буй агуулга
23. ХАССТ, “Алтны уурхай дахь хүүхдийн хөдөлмөрийн байдлын талаарх судалгаа”
Улаанбаатар 2002 он

UIH.MN
СУДАЛГААНЫ САН